



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ганзоригийн ТЭМҮҮЛЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас 26-25-28, Факс 32-70-16
E-mail: temuulen@parliament.mn
http://www.parliament.mn

2024.04.19 № 44X-03/3080

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд "Малчны тухай" хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж өгөхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Г.ТЭМҮҮЛЭН

А.АДЪЯАСҮРЭН

Ш.АДЪШАА

Н.АЛТАНХУЯГ

С.АМАРСАЙХАН

Г.АМАРТҮВШИН

Ц.АНАНДБАЗАР

П.АНУЖИН

Т.АУБАКИР

Ё.БААТАРБИЛЭГ

Х.БАДЕЛХАН

Э.БАТ-АМГАЛАН

000187



С.БАТБОЛД

Ж.БАТЖАРГАЛ

Д.БАТЛУТ

Ж.БАТСУУРЬ

Б.БАТТӨМӨР

Э.БАТШУГАР

Б.БАТ-ЭРДЭНЭ

Д.БАТ-ЭРДЭНЭ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Б.БАЯРСАЙХАН

Б.БЕЙСЕН

Х.БОЛОРЧУЛУУН

Х.БУЛГАНТУЯА

С.БЯМБАЦОГТ

Ж.ГАНБААТАР

С.ГАНБААТАР

Д.ГАНБАТ

Г.ГАНБОЛД

Н.ГАНИБАЛ

Х.ГАНХУЯГ

Ц.ДАВААСҮРЭН

Г.ДАМДИННЯМ

Т.ДОРЖХАНД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.ЖАВХЛАН

Б.ЖАРГАЛМАА

Г.ЗАНДАНШАТАР




000187



Ц.ИДЭРБАТ

Л.МӨНХБААТАР

Ц.МӨНХ-ОРГИЛ



Г.МӨНХЦЭЦЭГ

Ц.МӨНХЦЭЦЭГ



Н.НАРАНБААТАР

Д.ӨНӨРБОЛОР

Х.НЯМБААТАР

С.ОДОНТУЯА

М.ОЮУНЧИМЭГ

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ПҮРЭВДОРЖ

Ш.РАДНААСЭД




Ц.САНДАГ-ОЧИР

Д.САРАНГЭРЭЛ

Б.САРАНЧИМЭГ

Ж.СҮХБААТАР



Ц.СЭРГЭЛЭН

Д.ТОГТОХСҮРЭН

Ц.ТУВААН

Ч.УНДРАМ

Н.УЧРАЛ

Ч.ХҮРЭЛБААТАР

Д.ЦОГТБААТАР

О.ЦОГТГЭРЭЛ



Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Ж.ЧИНБҮРЭН

000187

С.ЧИНЗОРИГ

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Б.ЭНХ-АМГАЛАН


Л.ЭНХ-АМГАЛАН

Б.ЭНХБАЯР

Н.ЭНХБОЛД

Т.ЭНХТҮВШИН

Ж.ЭРДЭНЭБАТ





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ганзоригийн ТЭМҮҮЛЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-25-28, Факс: 32-70-16
E-mail: temuulen@parliament.mn
http://www.parliament.mn

2024.04.17 № УИХ-03/2972
танай _____ -ны № _____ -т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай**


Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд "Малчны тухай" хуулийн төслийг санаачлан боловсрууллаа. Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох материалыг хавсаргав.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйл, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хавсралт 138 хуудастай.

Хүдэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Г.ТЭМҮҮЛЭН



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ТЭМҮҮЛЭН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.04.09 № хэрг/694
танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулсан Малчны тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хавсралт 0/ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000245007777

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэлд:

“4.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн санаачлан боловсруулсан Малчны тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн санаачлан боловсруулсан Малчны тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах үндэслэлээр дэмжих боломжгүй саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 23.1-д “Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна” гэж заасан. Гэтэл хуулийн төслөөр зохицуулах харилцаа нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Газрын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай зэрэг хуулиудаар тус тус зохицуулагдаж байна.

2.Төрөөс малчин иргэд болон мал аж ахуйн салбарыг дэмжих зорилгоор Төсвийн тухай хууль болон татварын хууль тогтоомжийн хүрээнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, татаас, санхүүжилт олгож, онцгой бодлого авч хэрэгжүүлж байна. Төрийн дэмжлэг шаардлагатай байгаа нийгмийн эмзэг бүлэгт тусгайлан анхаарал хандуулах нь төрийн зүй ёсны үүрэг мөн боловч нийгмийн тодорхой нэг бүлгийг давуу байдлаар дэмжих нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан шударга ёсны зарчимд харшилж, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг хөндөж болзошгүй байна. Тухайлбал, малчдад төрөөс үзүүлж байгаа дэмжлэг, урамшууллыг дурдвал:

-“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын 2 дахь заалтын “а”-д “хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай нийт 1.7 их наяд төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг 2022-2026 онд улсын төсвөөс зээлийн хүүгийн татаас болон батлан даалт, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх”-ийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан;

-жил бүрийн Төсвийн тухай хууль болон татварын хууль тогтоомжийн дагуу төрөөс хүнсний салбарт олон татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, татаас, санхүүжилтийн арга хэмжээг эрчимтэй авч хэрэгжүүлж байна;

-Нийгмийн даатгалын ерөнхий хуульд төрөөс малчдын нийгмийн хамгааллыг дэмжих бодлогын хүрээнд малчдын нийгмийн даатгалын шимтгэлийн

50 хувийг улсын төсвөөс олгохоор, мөн өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх шимтгэл төлсөн жил, насыг бусад этгээдээс 5-аар бага байхаар тус тус заасан;

-малчдын татварын орчныг энгийн, ойлгомжтой болгох, дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд тулгараад байгаа хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.1.29-д заасны дагуу малчин, мал бүхий этгээдийн борлуулсан таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, ноолуур, хонь болон тэмээний ноос, сарлагийн хөөврийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөөр, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21.3 дахь хэсэгт зааснаар өөрийн хүсэлтээр хялбаршуулсан горимыг сонгож, орлогын босго хамаарахгүйгээр үйл ажиллагааны нийт орлогын 1 хувиар хувь хүний орлогын албан татвар төлөх талаар зохицуулалтыг хуульчилсан байна;

-Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10 дахь хэсэгт алслагдсан аймаг, суманд байнгын үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны орлогод ногдох хувь хүний орлогын албан татвар болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар тус тус хөнгөлөх талаар зохицуулсан.

3.Татварын ерөнхий хуулийн 4.1-д заасны дагуу татварыг Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй болохыг, мөн зүйлийн 4.2-т заасны дагуу татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь, хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулах шаардлагатай байна.

4.Хуулийн төсөл нь бодлогын баримт бичгийн бүтэцтэй бөгөөд зохицуулалтыг хариуцан хэрэгжүүлэх байгууллага нь тодорхойгүй байна. Мөн Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.6-д “хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно” гэж заасан зорилттой нийцэхгүй байна. Учир нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.6 дахь заалтад “хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх” гэж заасан шаардлагыг хангаагүй байна.

5.Хуулийн төслийн 3.2-т “Мал бүхий хуулийн этгээд” гэж, мөн төслийн 14.1.5-д тусгагдсан “дигитал мал аж ахуй” гэж тусгасан ойлголтуудыг хэрхэн ойлгох нь тодорхойгүй байна.

6.Хуулийн төслийн 4.1.2-т “малчин” гэж жилийн дөрвөн улирлын туршид мал маллаж, малын ашиг шимээр өрхийн үндсэн орлогоо бүрдүүлж, холбогдох хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээж байгаа 16-аас дээш насны Монгол Улсын иргэнийг ойлгохоор тусгажээ. Гэвч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д “малчин” гэсэн нэр томъёог тодорхойлсон байдаг тул хуулийн төслийн тус заалт давхардал үүсгэж байна.

Мөн Иргэний хуулийн 15.2-т “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүх 16-аас 18 хүртэлх насны иргэнийг, түүний хүсэлт, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж

тооцож болно” гэж, 16.1-д “Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байна” гэж тус тус заасан. Үүний дагуу иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай этгээдтэй холбогдсон аливаа татварын маргаан гарсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх нь ойлгомжгүй байна.

7.Хуулийн төслийн 4.1.5-д “малчны хоршоо” гэж “сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаа, хөдөлмөр, хувь нийлүүлсэн хөрөнгөөр нэгдэж, Хоршооны тухай хуульд нийцүүлэн дүрмээ баталгаажуулж, албан ёсны хуулийн этгээдээр бүртгүүлсэн малчны нэгдлийг” гэсэн нь төслийн 3.2-т “Мал бүхий хуулийн этгээд энэ хуулийн зохицуулалтад хамаарахгүй” гэж заасантай зөрчилдөж байна.

8.Хуулийн төслийн 5.2.5-д “амь ахуй” гэж, мөн зүйлийн 5.2.12-т “залуу малчдын гарааны бизнес” гэж тусгасан нь ойлгомжгүй байна.

9.Хуулийн төслийн 7.11-д “... жил бүрийн хаврын тэргүүн сарын шинийн 8-ны өдөр нь “Малчныг сонсох өдөр” байна.” гэж тусгасан зохицуулалт нь Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулиар зохицуулах харилцаа байна.

10.Хуулийн төслийн 8.1-д заасан малчин өрхийн өвөлжөө, хаваржааны 0,07 га эзэмших эрхтэй газарт өмчлөх эрх олгох зохицуулалт нь Газрын тухай хуулийн 5.2-т “Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно” гэж заасантай зөрчилдөж байна.

11.Хуулийн төслийн 19.3.2-т заасан хөндлөнгийн үнэлгээ буюу хариуцлагатай байдлаа баталгаажуулах хүсэлтийг үнэлж, дүгнэх үүргийг Стандарт, хэмжил зүйн газарт хариуцуулахаар, мөн хуулийн төслийн 25.5-д заасан хариуцлагатай малчин баталгаажуулалтын гэрчилгээ авсан малчны бүлэг, баг, сумын талаарх мэдээллийг стандартчилал, хэмжил зүйн асуудал хариуцсан байгууллага нэгтгэж, олон нийтэд нээлттэй мэдээлэхээр тусгасан нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн зохицуулалттай нийцэхгүй байна.

12.Хуулийн төслийн 22.2, 22.9 дэх хэсэгт арилжааны банкнаас малчдад олгох зээлийн болон даатгалын үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэхээр, зээлийн эх үүсвэрийн санхүүжилт, хүүг Засгийн газраас тогтоохоор заасан нь Банкны тухай хуулийн 10.1-д “Банк иргэн, хуулийн этгээдэд өөрийн болзол, нөхцөлийн дагуу зээл олгож болох бөгөөд зээлийн хүүг өөрөө тогтооно.” гэж заасантай нийцэхгүй байна.


13.Хуулийн төслийн 23 дугаар зүйлд заасан Малчны хөгжлийн сан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлд заасан орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаатай давхцаж байна.

14.Хуулийн төслийн 24.1.12-т “энэ хуулийн 24.1.2-т заасан нөхөн төлөлтийн журмыг Засгийн газар тогтооно” гэсэн нь төслийн 24.1.2 дахь заалтад “малчин өвлүүлэх үл хөдлөх хөрөнгөтэй болохыг дэмжиж, ипотекийн хөтөлбөрт хамруулах, зээлийн хөнгөлөлт үзүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.


15.Төсвийн тухай хуулийн 6.2.4-т “Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа

шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх” гэж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 18.1-д “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж тус тус заасан боловч хуулийн төслийг дагалдуулан төрөөс санхүүжүүлэх арга хэмжээ, зориулалт, үйл ажиллагааны зардлыг бүрэн тооцоолж ирүүлээгүй байна.

16.Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.1-д заасан хуулийн төслийн нэр томьёо, хэл зүй, найруулгын хувьд оновчтой бус хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх, хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбар байх зэрэг хэл зүй, найруулгын шаардлагыг хангахгүй байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



“МАЛЧНЫ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Малчны тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик үндэслэл, шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт “...хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй...” гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан байна.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт ““Үндэсний язгуур ашиг сонирхол”-д Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.2-д “хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, ...салбарыг хөгжүүлнэ”, 3.5.2.5-д “бэлчээрийн мал аж ахуй, малчдын ахуй амьдралд шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, уламжлалт сэтгэлгээ, арга хэвшлийг сэргээж, хурдацтай явагдаж байгаа экосистемийн өөрчлөлтийг мэдэрч түүнд тохирсон, дасан зохицсон амьдралын хэв маяг, аж ахуй эрхлэх менежментийн арга барилыг боловсруулж заан сургах, туршин нэвтрүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон нийтэд хүргэх сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ.”, 3.5.2.2-т “бэлчээр ашигласны төлбөр тогтоох, эзэмшүүлэх, хамгаалах болон нөхөн сэргээх хариуцлага хүлээлгэх чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх...” талаар бодлогын баримт бичигт тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эрхэм зорилгод “...үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэж, ...өөрийгөө тэтгэсэн эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн, ...улс болж хөгжинө.” гэж, зорилт 1.2.-д “...үндэсний өв соёл, нүүдлийн ахуйг уламжлал, шинэчлэлтэй хослуулсан тэргүүлэх

улс болж, нүүдлийн соёл иргэншлийг хадгалах, ...хамгаалахад чиглэсэн төрөлжсөн байгууллагуудтай болно.”, зорилт 2.3.-д “...гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.”, зорилт 2.6-д “хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.”, зорилго 3-д “хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, ...өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг бүрдүүлнэ.”, зорилт 3.3.5-д “малчин ...өрхийн аж ахуй эрхлэхэд нь ...санхүүгийн дэмжлэг үзүүлэх, малчин өрхийн бэлтгэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх оновчтой тогтолцоог бий болгох”, зорилт 5.5-д “иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх...” гэж, зорилго 8.-д “нүүдлийн уламжлалт өв соёлыг хадгалсан, экологид ээлтэй, органик мал аж ахуйг тогтвортой эрхлэх, ...хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн тогтвор суурьшилтай ажиллаж, ая тухтай амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулна” гэж тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилт 4.4-д “эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг ханган, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн зорилт 1.2-д “нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” -ийн 3.1.14-д “эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн бодлого, хууль, эрх зүйн орчныг тодорхой болгоно” гэж, 3.3.6-д “малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, ...малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ” гэж, 3.3.11-д “...үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгоно” гэж, 6.2-д “бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэж тус тус заажээ.

Дээр дурдсан эрх зүйн орчин, төрийн бодлогын хүрээнд үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал, эдийн засгийн болон экологийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа малчдын нийгмийн харилцаанд оролцох эрх зүйн байдлыг тодорхой болгох, хүний эрхийн зарим баталгааг нь хуулиар хамгаалах эрх зүйн таатай орчин зайлшгүй шаардлагатай байна. Түүнчлэн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн “нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан улс орон байх” зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд манай улсын өргөн уудам нутаг, хил хязгаар болон нүүдэлчин ахуй, соёлыг үеэс үед өвлөн хадгалж, хамгаалж байгаа уугуул иргэд болох малчид, малчин өрхийн талаар төрөөс баримтлах бодлогод онцгой анхаарч, тэдгээрийн нийгмийн баталгаа, амьжиргааны нөхцөлийг сайжруулах, уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлээ тогтвортой эрхлэх, хөгжих таатай боломжийг бүрдүүлэх эрх зүйн үндэслэл, шаардлага байна.

1.2.Практик шаардлага.

Мал аж ахуй нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тулгуурын нэг бөгөөд хүн амыг гол нэрийн хүнсээр, уул уурхайн бус салбарын үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах эх үүсвэр нь болж, олон мянган өрхийн өдөр тутмын амьжиргаа, хэрэглээ тус үйлдвэрлэлээс хамааралтай байна. Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 10,9 хувь, экспортын орлогын 5,6 хувийг мал аж ахуй бүрдүүлж, орон нутгийн 80,0 гаруй хувь мал аж ахуйд суурилсан эдийн засагтай, нийт ажиллах хүчний 25,5 хувь¹ тус салбарт ажиллаж байна. Манай улсын нийт газар нутгийн 71,2 хувийг хамарсан мал аж ахуйн үйлдвэрлэлийг 246,3 мянган малтай өрх эрхэлж, үүнээс жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж буй 188,6 мянган малчин өрх² байна.

Монгол малчид нь мал аж ахуйг 10.0 мянга³ гаруй жилийн туршид үе дамжуулан эрхэлж, хүн төрөлхтний нүүдлийн соёл иргэншил, өв соёлыг тээгчид гэж дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, улс орныхоо хязгаар нутаг, хилийг хамгаалах, монгол ухаан, эх хэл, өв соёлыг хадгалах үндсэн цөм болж байна.

Гэвч монголчуудын олон мянган жилийн туршид хуримтлуулсан бэлчээрийн мал аж ахуйн эрхлэх арвин их уламжлалт мэдлэг, түүнээс үр шимийг нь хүртэж ирсэн арга барил, туршлагад дэлхийн даяаршил, техник, технологийн дэвшил нөлөөлж, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх үзэл баримтлал, чиг хандлага өдрөөс өдөрт өөрчлөгдөх боллоо. Малчдын өнөөгийн чадамж, чадавх, орчны нөхцөл, хөгжил, экологийн тэнцвэрт байдлын алдагдал, бэлчээрийн газрын төлөв байдал, ашиглалтаас үүдэлтэй зөрчил, маргаан, малын гаралтай түүхий эдийн үнэгүйдэл зэрэг нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн хүрээнд анхаарал татсан тулгамдсан асуудлууд болж байна.

Нүүдлийн мал аж ахуйн онцлогоо хадгалж үлдэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэлхийн ба улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн өөрчлөлт болон байгаль экологи, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож эрхлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэхийг хөгжлийн шаардлага бий болгож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан ч амьдрал дээр малчдын хувьд зарим эрх ашиг нь ихээхэн хөндөгдөх, эрх нь зөрчигдөх, төр иргэнийхээ өмнө үүргээ бүрэн биелүүлэхгүй, орхигдуулах асуудал байсаар байна.

Байгалийн бэлчээрт суурилсан уламжлалт аж ахуйг тогтвортой эрхлэх, хөгжүүлэх үндэс суурь нь малчид бөгөөд тэдгээр нь өрсөлдөх чадавхтай байж, мал сүргээ идээшлүүлэх газар нутгаа зохистой ашиглах, хамгаалах, хариуцлагатай эзэн байх эрх, үүргээ хэрэгжүүлэх нь чухал боловч малчид эдэлбэр газартай холбогдсон “ашиглах, удирдан зохицуулах” эрхээ эдэлж чадахгүй байна.

Малчин өрх үе дамжин мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж ирэхдээ ашиглаж ирсэн өвөлжөө, хаваржаа, ус, мараа, хужир бүхий зуслан, намаржааны бэлчээр,

¹ Үндэсний статистикийн хорооны 2021 оны эмхэтгэл.

² Үндэсний статистикийн хорооны 2021 оны эмхэтгэл.

³ Малыг генетик нөөцийн үндэсний тайлан ХХААХҮЯ, 2021 он

өвс, хадлан бэлтгэдэг газрыг нутгийг нь уул уурхайн хайгуул, олборлолтын эсхүл бусад зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэчихсэн байдаг нь малчдын эрх ашгийг шууд хөндөж, мэдээлэл авах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, төрийн үйл хэрэгт оролцох хүний эрхийг нь зөрчиж байна. Зарим бүс нутагт уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн замбараагүй урсгал, замын тасралтгүй тоосжилт, тэсэлгээнээс үүдэлтэй бэлчээрийн газрын хөрс, шим, хүн, малын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл, үр дагавар учруулж байгаа нь нутгийн уугуул иргэд, малчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж байна. Мөн зайлшгүй шаардлагын улмаас оторлож байгаа малчдыг нутагтаа оруулахгүй байх, нутгаасаа хөөх, орон нутгийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь торгууль тавих, өндөр хэмжээгээр төлбөр авах, хөрөнгийн байдлаар нь тэгш бус хандах, төрийн үйлчилгээ үзүүлэхгүй байх зэргээр ялгаварлан гадуурхаж, хүний эрхийг нь зөрчих, "экологийн дүрвэгсэд"-ийн үзэгдэл нийгэмд түгээмэл болоод байна. Мал сүргээ жилийн дөрвөн улирлын туршид идээшлүүлэн бэлчээрлүүлэх, сэлгээн амраах, оторлон нүүдэллэх газар нутгийн хүрэлцээ нь өдрөөс өдөрт хумигдаж, уур амьсгал, байгаль экологийн өөрчлөлт, усны хомсдолын нөлөөлөлд өртсөн малчид, мал бүхий иргэдийн хооронд хагарал үүсэж маргалдах, зодолдох, улмаар бие биеийнхээ амь насанд хүрэх асуудал нийгэмд үүсэх болжээ. Түүнчлэн тариалангийн бүс нутагт бэлчээрийн мал аж ахуй эрхэлж буй уугуул болон суугуул малчдыг тухайн бүс нутгаас хаа нэг тийшээ мал, хашаа хороогоо аваад нүүх эсхүл малаа зараад эрчимжсэн аж ахуй эрхлэх, малын тоо толгойн албан татварыг өндөр дүнгээр төлөх зэрэг шахалтыг төрийн байгууллагаас үзүүлж эхэлсэн нь малчдын сэтгэл санаа, эрх ашигт шууд хохирол учруулж, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 18 дахь хэсэгт "улсынхаа нутаг дэвсгэрт түр буюу байнга оршин суух газраа сонгох...", мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт "...ажил мэргэжлээ сонгох..." гэсэн эрхийг нь зөрчиж байна.

Ийнхүү нүүх, суух бэлчээр нутгийн хүрэлцээгүйн улмаас малчид жилийн 4 улирлын туршид нэг газраа суурьшиж, суурин амьдралын хэв шинж рүү шилжих нь аажмаар нүүдлийн соёл иргэншлийн олон мянган жилийн түүх, ахуй, өв, уламжлалт мэдлэг, ондоошлогоо монголчууд алдаж, малын гаралтай органик бүтээгдэхүүн экспортлох боломжоо өөрсдийн гараар устгах эрсдэл өндөр байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэл дээр ажиллагсад нь жилийн 4 улирлын туршид амралтгүйгээр ажилладаг атлаа хөдөлмөрийн үнэлгээгүй, үйлдвэрлэлдээ хөрөнгө оруулалт хийх эрх зүйн баталгаа хангалтгүй, зонхилох хэсэг нь дэд бүтэц, нийгэм соёлын хөгжил, үйлчилгээ муутай алслагдсан бүс нутгийн хүнд нөхцөлд амьдарч байна. Түүнчлэн 15-24 насны залуу малчдын хүйсийн харьцаанд ихээхэн зөрүү үүсэж, эрэгтэй 67.7 хувь, эмэгтэй 32.3 хувийг бүрдүүлэх болсон нь хүн амын бодлогын түвшинд төрөөс анхаарвал зохих асуудал болж байна. Залуу малчдын дундах хүйсийн харьцааны зөрүү нь малчдын дундах гэрлэлт буурах, оройтох, төрөлт буурах, бэлгийн зүй бус харилцаа олшрох, гэрлэлт дагасан шилжилт хөдөлгөөн эрчимжих, цаашлаад малчдын залгамж чанарт сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг дагуулж байна. Хүн амын хот суурин дахь бөөгнөрөл, залуучуудын "хэт хотжих" чиг хандлагатай уялдан мал аж ахуйн салбарт ажиллах хүн хүчний сонирхлыг бий болгох, тэдгээрийн нийгмийн баталгааг хангах, мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлэн хөгжүүлэх, хөдөлмөрийн үнэлгээ бий болгох, мал аж ахуйн

үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэлт, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хөгжүүлэхэд төрийн оролцоог тодорхой болгож хуульчилж өгөх шаардлага байна.

Газар зүйн байршлын онцлогтой уялдаад манай улс уур амьсгалын өөрчлөлтөд дэлхийн дунджаас 3 дахин их хэмжээгээр өртөж, мөн хүний хүчин зүйлсийн сөрөг нөлөөллөөр хөрсний доройтол, цөлжилт, бэлчээрийн талхагдал, хомсдол өдрөөс өдөрт тэлж, ургамлын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, байгалийн унаган төлөв, экологийн тэнцвэрт байдал алдагдах эрсдэлд ороод байна. Тухайлбал, бэлчээрийн эдэлбэр газрын 57,0 хувь тодорхой хэмжээгээр доройтолд орж, 10,3 хувь нь байгалийн аясаар сэргэх боломжгүйгээр цөлжсөн⁴ байна. Нөгөө талаас бэлчээр, хадлангийн эдэлбэр газрын хэмжээ жилээс жилд буурч⁵ байхад түүний багтаамжийн зохист хэмжээ буюу малын тоо⁶ хонин толгойд шилжүүлснээр даруй 25 гаруй сая толгойгоор хэтэрчээ. Малын тоо өсөх нь малчдын амьжиргааг дээшлүүлэхэд хувь нэмэртэй ч байгалийн даацын чадамжийн хэтрэлт, байгаль, цаг уурын өөрчлөлт, ган зудын нөлөөллөөр малчид ихээхэн хохирол амсаж, улмаар амь зуулгаас салах үед суурин бараадаж, хотод төвлөрөл үүсгэх, ядуурал, ажилгүйдэл ихсэхэд шууд нөлөөлөл үзүүлдэг. Иймд малчдын дасан зохицох чадавхыг дээшлүүлэх, байгалийн эрсдэлт хүчин зүйлсийг даван туулах, түүнээс урьдчилан сэргийлэх, малын тоог экологид ээлтэй байх түвшинд барих, бэлчээрийг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, нэгж малаас авах бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагаа, нийгмийн харилцаанд төрийн оролцоо болон малчдын эрх, үүрэг, хариуцлагын механизмыг тодорхой болгох шаардлага ихээхэн байна.

Дэлхий нийтэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эдийн засгийн бусад салбараас ялгагдах онцлогтой гэж үзэж, үйлдвэрлэлийн харилцааг нь хуульчлан баталгаажуулах, төрийн дэмжлэгийн тухайлсан бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хүн амын хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийг тогтвортой байлгадаг. Ялангуяа хөгжсөн орнуудад хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн үнийн тогтворжуулалтыг хадгалах, зохицуулахын тулд мал аж ахуйн үйлдвэрлэлийг өөрийгөө зохицуулах чадвар султай, эрсдэлтэй бизнес гэж үзэж, фермерүүдэд байнгын дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, АНУ-д дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 1,0 хувь, Европын холбоонд 1,3 хувь, Японд 1,4 хувьтай тэнцэх санхүүжилтийн дэмжлэгийг улсын төсвөөс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд зарцуулж байна.

Манай улсын хувьд хүн амын гол нэрийн хүнс, үндэсний хөнгөн аж үйлдвэрийн түүхий эдийг бэлтгэн нийлүүлдэг стратегийн ач холбогдол бүхий салбар мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой явуулах, хөгжүүлэх, нөөцийг нь бүрэн ашиглах зориулалтаар уул уурхайн салбараас орж ирж буй хөрөнгө оруулалтаас тодорхой хувийг тогтмол зарцуулах шаардлагатай байна. Нүүдлийн мал аж ахуй нь байгалийн шууд нөлөөл дор явагддаг эрсдэлтэй салбар гэж үздэг учраас арилжааны банкны зээлийн хүү өндөр (21.5%-23.7%) зээл өгдөг. Гэвч мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжсэн тохиолдолд түүний эрсдэлийг бууруулах нөхцөл бүрдэх тул санхүүгийн үйлчилгээний тусгайлсан арга хэмжээг малчдад зориулан хэрэгжүүлэх

⁴ Монгол Улсын бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан, 2021 он.

⁵ Газрын нэгдмэл сангийн тайлан 2022 оны эмхэтгэл.

⁶ Үндэсний статистикийн хорооны 2022 оны эмхэтгэл.

нь зүйтэй байна. Ялангуяа Засгийн газрын тусгай сан болон Малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэх сангаас малчдын тогтвортой үйлдвэрлэл, тэдгээрийн хөгжилд зориулж жил бүр олгох санхүүжилтийн хувь хэмжээг тогтоох нь нийгмийн тэгш, шударга, хүртээмжтэй байх эрхийг хангахаар байна.

Малчдын нөөц боломжийг нь нээж, тэгш эрх, нээлттэй өрсөлдөөнийг хөгжүүлэх, харилцан туршлага, мэдээллээ солилцох, үйл ажиллагааны үр өгөөж, чанарыг сайжруулах, нийгэм, эдийн засгийн харилцаанд малчны оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн тогтолцоог бүрдүүлэхэд эрх зүйн орчны дэмжлэг чухал байна. Цаашид мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, нүүдлийн соёл иргэншлийн уламжлалт өв соёл, байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ үлдээх боломжийг улам бүр багасах тул төрөөс тухайлсан бодлого, зохицуулалтаар шийдвэрлэх шаардлага их байна.

Дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлага нь малчдын эрх зүйн байдлыг холбогдох хуулиудтай уялдуулж, бие даасан хуулиар нарийвчлан зохицуулах хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байна. Иймд Малчны тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан болно.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь мал аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх малчны эрх зүйн байдлыг тодорхойлж, малчны ажиллах, амьдрах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлж, байгалийн чадамжид нийцсэн, бүтээмж бүхий өрсөлдөх чадвартай мал аж ахуйг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

Хуулийн төсөл нь 6 бүлэг бүхий бүтэцтэй байх ба тус хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлж байна.Үүнд:

Хуулийн төслийн “**Нэгдүгээр бүлэг.Нийтлэг үндэслэл**”-д хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, холбогдох нэр томъёоны тодорхойлолтыг тусгана.

Хуулийн төслийн “**Хоёрдугаар бүлэг.Малчны талаар талаар төрөөс баримтлах бодлого**”-д мал аж ахуй, малчны талаар төрөөс баримтлах зарчим, чиглэлийг тодорхойлж, малчны уламжлал, өв соёл, ёс заншлыг өвлүүлэн хамгаалах, таниулах, малчны эрх, үүргийг тодорхойлж зөв дадалыг эзэмшүүлэх харилцааг зохицуулна.

Хуулийн төслийн “**Гуравдугаар бүлэг.Малчны хөгжил**”-д малчны мэдлэгийг дээшлүүлэх хангах тогтолцоо, зарчмыг тодорхойлж, малчны хөгжлийн хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, малчны үйл ажиллагаанд цахим шилжилтийг нэвтрүүлэх, малчны цахим хөтөч мэдээллийн сан бүрдүүлэх, энэ чиглэлийн үйлчилгээг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгана.

Хуулийн төслийн “**Дөрөвдүгээр бүлэг.Малчны бүтээмж**”-д малчны үйлдвэрлэлийн цар хүрээ, чадавх, хөдөлмөрийн бүтээмжийн болон малчны мэргэшлийн үнэлэмжийн ангиллыг тогтоох, баталгаажуулах харилцааг зохицуулахаар заана. Түүнчлэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхдээ байгальд ээлтэй байх зохистой дадлын шаардлага, шалгуурыг хангахтай холбоотой хариуцлагатай байдлыг нь үнэлж, баталгаажуулах, малчны өрсөлдөх чадвар,

нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмрийг бэхжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар заана.

Хуулийн төслийн “Тавдугаар бүлэг.Малчны хамтын санаачилгыг дэмжих”-д малчны хамтын санаачилга, хоршил, кластерын үйл ажиллагааны хэлбэр, малчны өөрөө удирдах байгууллагын тогтолцоог тодорхой болгож, малчинд үзүүлэх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан малчны хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, эдийн засгийн чадамжийг сайжруулах, малчны нийгмийн баталгааг сайжруулах, малчны гэр бүл ая тухтай амьдрах, ажиллах, хүүхэд нь сурах таатай нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой харилцааг хуульчилна. Мөн малчны амьжиргааны түвшинтэй уялдуулан төрөөс үзүүлэх хөнгөлөлт, дэмжлэг тодорхой байхаар тусгана.

Хуулийн төслийн “Зургаадугаар бүлэг.Бусад зүйл”-д хуулийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр, хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг зохицуулахтай холбогдсон харилцааг тусгана. Мөн хууль хүчин төгөлдөр болох хугацааг заана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Энэ хуулийн төсөл нь бусад холбогдох хууль тогтоомж, салбарын бодлоготой уялдаж байгаа тул сөрөг үр дагавар авчрахгүй гэж үзэж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, эрх зүйн хүрээнд дараах эерэг үр дүн гарна. Үүнд:

- Малчдын эрх зүйн байдлыг тодорхой болгож, нийгмийн өмнө хүлээх эрх, үүргийг тогтоож, үйлдвэрлэгч-менежер, хариуцлагатай байх, хөгжих боломжийг нээнэ.
- Монгол орны бэлчээрийн мал аж ахуй эрхлэх өвөрмөц онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, зан заншлыг хадгалах, хамгаалахад чиглэгдсэн эрх зүйн зохицуулалтын орчин бүрдэнэ.
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрсдэл даах чадавхтай, үр ашигтай, тогтвортой хөгжилтэй салбар болгон хөгжүүлэх үзэл баримтлалыг хангана.
- Хариуцан ашиглах эзэн эрхийг малчдад олгох нөхцөлийг бүрдүүлснээр бэлчээрийн газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагааны хариуцагч эзэн тодорхой болно.
- Сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах малчдын зохион байгуулалтын тогтолцоо бүрдэнэ.
- Малчдын дунд уур амьсгалын өөрчлөлт, ган, зудын сөрөг нөлөөллөөс сэргийлэх менежментийг тодорхой болгосноор мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийг бууруулна.
- Малчдын залгамж халааг бэлтгэх, малчдад насан туршийн боловсрол олгох, мэдлэгжүүлэх, цахим системийг нэвтрүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.

- Малыг эдийн засгийн эргэлтэд тогтмол оруулах, ашиг шим, чанар, бүтээмжийг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх сонирхлыг бий болгоно.
- Малчдыг дэмжих үйл ажиллагааны зарчим, цар хүрээ, дэмжлэгийн хэлбэр, төрийн оролцоо, хязгаарыг тодорхой болно.
- Малчин өрхийн үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих, чанар-үнэ-урамшуулах тогтолцоог хөгжүүлж, эргэлтийг эрчимжүүлэх нөхцөлийг бүрдүүлснээр тэдгээрийн өрхийн орлого, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлнэ.
- Хөдөөд суурьшиж, уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэх малчныг урт хугацааны хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжсэнээр хотоос хөдөө рүү шилжих урсгалыг нээж, нийслэлийн хэт төвлөрөл, замын ачаалал, агаарын бохирдлын ачаалал, сөрөг нөлөөг бууруулна.
- Хариуцлагатай малчдыг хөнгөлөлттэй зээлийн болон татварын бодлогоор дэмжсэнээр малчдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, чадавхжих сонирхлыг нэмэгдүүлнэ.
- Малчдын хөдөөд ая тухтай ажиллаж, амьдрах орчныг сайжруулснаар хөдөөгийн хөгжилд ахиц гарч, малчинд хүргэх нийгмийн үйлчилгээний тогтвортой байдал, эрх тэгш байх эрх хангагдана.

Дөрөв.Хууль батлах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Газрын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах ба хуулийн төсөлтэй холбогдуулан Малын генетик нөөцийн тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулна. Түүнчлэн хуулийн төсөлд Малчны хөгжлийн төвийн үйл ажиллагаа, малчны зохистой дадлыг үнэлж, баталгаажуулах, эрсдэлийн сангийн үйл ажиллагаа, хяналт шинжилгээ хийх, малчинд дэмжлэг үзүүлэх харилцааг журмаар зохицуулахаар заана.

-----oOo-----

“МАЛЧНЫ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Мал аж ахуй нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тулгуурын нэг бөгөөд хүн амыг гол нэрийн хүнсээр, уул уурхайн бус салбарын үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах эх үүсвэр нь болж, олон мянган өрхийн өдөр тутмын амьжиргаа, хэрэглээ тус үйлдвэрлэлээс хамааралтай байна. Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 10,9 хувь, экспортын орлогын 5,6 хувийг мал аж ахуй бүрдүүлж, орон нутгийн 80,0 гаруй хувь мал аж ахуйд суурилсан эдийн засагтай, нийт ажиллах хүчний 25,5 хувь¹ тус салбарт ажиллаж байна. Манай улсын нийт газар нутгийн 71,2 хувийг хамарсан мал аж ахуйн үйлдвэрлэлийг 246,3 мянган малтай өрх эрхэлж, үүнээс жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж буй 188,6 мянган малчин өрх² байна.

Монгол малчид нь мал аж ахуйг 10.0 мянга³ гаруй жилийн туршид үе дамжуулан эрхэлж, хүн төрөлхтний нүүдлийн соёл иргэншил, өв соёлыг тээгчид гэж дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, улс орныхоо хязгаар нутаг, хилийг хамгаалах, монгол ухаан, эх хэл, өв соёлыг хадгалах үндсэн цөм болж байна.

Гэвч монголчуудын олон мянган жилийн туршид хуримтлуулсан бэлчээрийн мал аж ахуйн эрхлэх арвин их уламжлалт мэдлэг, түүнээс үр шимийг нь хүртэж ирсэн арга барил, туршлагад дэлхийн даяаршил, техник, технологийн дэвшил нөлөөлж, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх үзэл баримтлал, чиг хандлага өдрөөс өдөрт өөрчлөгдөх боллоо. Малчдын өнөөгийн чадамж, чадавх, орчны нөхцөл, хөгжил, экологийн тэнцвэрт байдлын алдагдал, бэлчээрийн газрын төлөв байдал, ашиглалтаас үүдэлтэй зөрчил, маргаан, малын гаралтай түүхий эдийн үнэгүйдэл зэрэг нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн хүрээнд анхаарал татсан тулгамдсан асуудлууд болж байна.

Нүүдлийн мал аж ахуйн онцлогоо хадгалж үлдэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэлхийн ба улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн өөрчлөлт болон байгаль экологи, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож эрхлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэхийг хөгжлийн шаардлага бий болгож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан ч амьдрал дээр малчдын хувьд зарим эрх ашиг нь ихээхэн хөндөгдөх, эрх нь зөрчигдөх, төр иргэнийхээ өмнө үүргээ бүрэн биелүүлэхгүй, орхигдуулах асуудал байсаар байна.

Байгалийн бэлчээрт суурилсан уламжлалт аж ахуйг тогтвортой эрхлэх, хөгжүүлэх үндэс суурь нь малчид бөгөөд тэдгээр нь өрсөлдөх чадавхтай байж, мал сүргээ идээшлүүлэх газар нутгаа зохистой ашиглах, хамгаалах, хариуцлагатай эзэн

¹ Үндэсний статистикийн хорооны 2021 оны эмхэтгэл.

² Үндэсний статистикийн хорооны 2021 оны эмхэтгэл.

³ Малыг генетик нөөцийн үндэсний тайлан ХХААХҮЯ, 2021 он.

байх эрх, үүргээ хэрэгжүүлэх нь чухал боловч малчид эдэлбэр газартай холбогдсон “ашиглах, удирдан зохицуулах” эрхээ эдэлж чадахгүй байна.

Малчин өрх үе дамжин мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж ирэхдээ ашиглаж ирсэн өвөлжөө, хаваржаа, ус, мараа, хужир бүхий зуслан, намаржааны бэлчээр, өвс, хадлан бэлтгэдэг газрыг нутгийг нь нэг өглөө босоход уул уурхайн хайгуул, олборлолтын эсхүл бусад зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэчихсэн байдаг нь малчдын эрх ашгийг шууд хөндөж, мэдээлэл авах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, төрийн үйл хэрэгт оролцох хүний эрхийг нь зөрчиж байна. Зарим бүс нутагт уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн замбараагүй урсгал, замын тасралтгүй тоосжилт, тэсэлгээнээс үүдэлтэй бэлчээрийн газрын хөрс, шим, хүн, малын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл, үр дагавар учруулж байгаа нь нутгийн уугуул иргэд, малчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж байна. Мөн зайлшгүй шаардлагын улмаас оторлож байгаа малчдыг нутагтаа оруулахгүй байх, нутгаасаа хөөх, орон нутгийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь торгууль тавих, өндөр хэмжээгээр төлбөр авах, хөрөнгийн байдлаар нь тэгш бус хандах, төрийн үйлчилгээ үзүүлэхгүй байх зэргээр ялгаварлан гадуурхаж, хүний эрхийг нь зөрчих, “экологийн дүрвэгсэд”-ийн үзэгдэл нийгэмд түгээмэл болоод байна. Мал сүргээ жилийн дөрвөн улирлын туршид идээшлүүлэн бэлчээрлүүлэх, сэлгээн амраах, оторлон нүүдэллэх газар нутгийн хүрэлцээ нь өдрөөс өдөрт хумигдаж, уур амьсгал, байгаль экологийн өөрчлөлт, усны хомсдолын нөлөөлөлд өртсөн малчид, мал бүхий иргэдийн хооронд хагарал үүсэж маргалдах, зодолдох, улмаар бие биеийнхээ амь насанд хүрэх асуудал нийгэмд үүсэх болжээ. Түүнчлэн тариалангийн бүс нутагт бэлчээрийн мал аж ахуй эрхэлж буй уугуул болон суугуул малчдыг тухайн бүс нутгаас хаа нэг тийшээ мал, хашаа хороогоо аваад нүүх эсхүл малаа зараад эрчимжсэн аж ахуй эрхлэх, малын тоо толгойн албан татварыг өндөр дүнгээр төлөх зэрэг шахалтыг төрийн байгууллагаас үзүүлж эхэлсэн нь малчдын сэтгэл санаа, эрх ашигт шууд хохирол учруулж, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 18 дахь хэсэгт “улсынхаа нутаг дэвсгэрт түр буюу байнга оршин суух газраа сонгох...”, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт “...ажил мэргэжлээ сонгох...” гэсэн эрхийг нь зөрчиж байна.

Ийнхүү нүүх, суух бэлчээр нутгийн хүрэлцээгүйн улмаас малчид жилийн 4 улирлын туршид нэг газраа суурьшиж, суурин амьдралын хэв шинж рүү шилжих нь аажмаар нүүдлийн соёл иргэншлийн олон мянган жилийн түүх, ахуй, өв, уламжлалт мэдлэг, ондоошлогоо монголчууд алдаж, малын гаралтай органик бүтээгдэхүүн экспортлох боломжоо өөрсдийн гараар устгах эрсдэл өндөр байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэл дээр ажиллагсад нь жилийн 4 улирлын туршид амралтгүйгээр ажилладаг атлаа хөдөлмөрийн үнэлгээгүй, үйлдвэрлэлдээ хөрөнгө оруулалт хийх эрх зүйн баталгаа хангалтгүй, зонхилох хэсэг нь дэд бүтэц, нийгэм соёлын хөгжил, үйлчилгээ муутай алслагдсан бүс нутгийн хүнд нөхцөлд амьдарч байна. Түүнчлэн 15-24 насны залуу малчдын хүйсийн харьцаанд ихээхэн зөрүү үүсэж, эрэгтэй 67.7 хувь, эмэгтэй 32.3 хувийг бүрдүүлэх болсон нь хүн амын бодлогын түвшинд төрөөс анхаарвал зохих асуудал болж байна. Залуу малчдын дундах хүйсийн харьцааны зөрүү нь малчдын дундах гэрлэлт буурах, оройтох, төрөлт буурах, бэлгийн

зүй бус харилцаа олшрох, гэрлэлт дагасан шилжилт хөдөлгөөн эрчимжих, цаашлаад малчдын залгамж чанарт сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг дагуулж байна. хүн амын хот суурин дахь бөөгнөрөл, залуучуудын “хэт хотжих” чиг хандлагатай уялдан мал аж ахуйн салбарт ажиллах хүн хүчний сонирхлыг бий болгох, тэдгээрийн нийгмийн баталгааг хангах, мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлэн хөгжүүлэх, хөдөлмөрийн үнэлгээ бий болгох, мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэлт, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хөгжүүлэхэд төрийн оролцоог тодорхой болгож хуульчилж өгөх шаардлага байна.

Газар зүйн байршлын онцлогтой уялдаад манай улс уур амьсгалын өөрчлөлтөд дэлхийн дунджаас 3 дахин их хэмжээгээр өртөж, мөн хүний хүчин зүйлсийн сөрөг нөлөөллөөр хөрсний доройтол, цөлжилт, бэлчээрийн талхагдал, хомсдол өдрөөс өдөрт тэлж, ургамлын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, байгалийн унаган төлөв, экологийн тэнцвэрт байдал алдагдах эрсдэлд ороод байна. Тухайлбал, бэлчээрийн эдэлбэр газрын 57,0 хувь тодорхой хэмжээгээр доройтолд орж, 10,3 хувь нь байгалийн аясаар сэргэх боломжгүйгээр цөлжсөн⁴ байна. Нөгөө талаас бэлчээр, хадлангийн эдэлбэр газрын хэмжээ жилээс жилд буурч⁵ байхад түүний багтаамжийн зохист хэмжээ буюу малын тоо⁶ хонин толгойд шилжүүлснээр даруй 25 гаруй сая толгойгоор хэтэрчээ. Малын тоо өсөх нь малчдын амьжиргааг дээшлүүлэхэд хувь нэмэртэй ч байгалийн даацын чадамжийн хэтрэлт, байгаль, цаг уурын өөрчлөлт, ган зудын нөлөөллөөр малчид ихээхэн хохирол амсаж, улмаар амь зуулгаас салах үед суурин бараадаж, хотод төвлөрөл үүсгэх, ядуурал, ажилгүйдэл ихсэхэд шууд нөлөөлөл үзүүлдэг. Иймд малчдын дасан зохицох чадавхыг дээшлүүлэх, байгалийн эрсдэлт хүчин зүйлсийг даван туулах, түүнээс урьдчилан сэргийлэх, малын тоог экологид ээлтэй байх түвшинд барих, бэлчээрийг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, нэгж малаас авах бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагаа, нийгмийн харилцаанд төрийн оролцоо болон малчдын эрх, үүрэг, хариуцлагын механизмыг тодорхой болгох шаардлага ихээхэн байна.

Дэлхий нийтэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эдийн засгийн бусад салбараас ялгагдах онцлогтой гэж үзэж, үйлдвэрлэлийн харилцааг нь хуульчлан баталгаажуулах, төрийн дэмжлэгийн тухайлсан бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хүн амын хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийг тогтвортой байлгадаг. Ялангуяа хөгжсөн орнуудад хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн үнийн тогтворжуулалтыг хадгалах, зохицуулахын тулд мал аж ахуйн үйлдвэрлэлийг өөрийгөө зохицуулах чадвар султай, эрсдэлтэй бизнес гэж үзэж, фермерүүдэд байнгын дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, АНУ-д дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 1,0 хувь, Европын холбоонд 1,3 хувь, Японд 1,4 хувьтай тэнцэх санхүүжилтийн дэмжлэгийг улсын төсвөөс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд зарцуулж байна.

⁴ Монгол Улсын бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан, 2021 он.

⁵ Газрын нэгдмэл сангийн тайлан 2022 оны эмхэтгэл.

⁶ Үндэсний статистикийн хорооны 2022 оны эмхэтгэл.

Манай улсын хувьд хүн амын гол нэрийн хүнс, үндэсний хөнгөн аж үйлдвэрийн түүхий эдийг бэлтгэн нийлүүлдэг стратегийн ач холбогдол бүхий салбар мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой явуулах, хөгжүүлэх, нөөцийг нь бүрэн ашиглах зориулалтаар уул уурхайн салбараас орж ирж буй хөрөнгө оруулалтаас тодорхой хувийг тогтмол зарцуулах шаардлагатай байна. Нүүдлийн мал аж ахуй нь байгалийн шууд нөлөөл дор явагддаг эрсдэлтэй салбар гэж үздэг учраас арилжааны банкны зээлийн хүү өндөр (21.5%-23.7%) зээл өгдөг. Гэвч мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжсэн тохиолдолд түүний эрсдэлийг бууруулах нөхцөл бүрдэх тул санхүүгийн үйлчилгээний тусгайлсан арга хэмжээг малчдад зориулан хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Ялангуяа Засгийн газрын тусгай сан болон Малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэх сангаас малчдын тогтвортой үйлдвэрлэл, тэдгээрийн хөгжилд зориулж жил бүр олгох санхүүжилтийн хувь хэмжээг тогтоох нь нийгмийн тэгш, шударга, хүртээмжтэй байх эрхийг хангахаар байна.

Малчдын нөөц боломжийг нь нээж, тэгш эрх, нээлттэй өрсөлдөөнийг хөгжүүлэх, харилцан туршлага, мэдээллээ солилцох, үйл ажиллагааны үр өгөөж, чанарыг сайжруулах, нийгэм, эдийн засгийн харилцаанд малчны оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн тогтолцоог бүрдүүлэхэд эрх зүйн орчны дэмжлэг чухал байна. Цаашид мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, нүүдлийн соёл иргэншлийн уламжлалт өв соёл, байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ үлдээх боломжийг улам бүр багасах тул төрөөс тухайлсан бодлого, зохицуулалтаар шийдвэрлэх шаардлага их байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй", мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт "...хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй..." гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасан байна.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт "“Үндэсний язгуур ашиг сонирхол”-д Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана." гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.2-д "хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, ...салбарыг хөгжүүлнэ", 3.5.2.5-д "бэлчээрийн мал аж ахуй, малчдын ахуй амьдралд шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, уламжлалт сэтгэлгээ, арга хэвшлийг сэргээж, хурдацтай явагдаж

байгаа экосистемийн өөрчлөлтийг мэдэрч түүнд тохирсон, дасан зохицсон амьдралын хэв маяг, аж ахуй эрхлэх менежментийн арга барилыг боловсруулж заан сургах, туршин нэвтрүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон нийтэд хүргэх сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ.”, 3.5.2.2-т “бэлчээр ашигласны төлбөр тогтоох, эзэмшүүлэх, хамгаалах болон нөхөн сэргээх хариуцлага хүлээлгэх чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх...” талаар бодлогын баримт бичигт тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эрхэм зорилгод “...үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэж, ...өөрийгөө тэтгэсэн эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн, ...улс болж хөгжинө.” гэж, зорилт 1.2.-д “...үндэсний өв соёл, нүүдлийн ахуйг уламжлал, шинэчлэлтэй хослуулсан тэргүүлэх улс болж, нүүдлийн соёл иргэншлийг хадгалах, ...хамгаалахад чиглэсэн төрөлжсөн байгууллагуудтай болно.”, зорилт 2.3.-д “...гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.”, зорилт 2.6-д “хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.”, зорилго 3-д “хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, ...өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг бүрдүүлнэ.”, зорилт 3.3.5-д “малчин ...өрхийн аж ахуй эрхлэхэд нь ...санхүүгийн дэмжлэг үзүүлэх, малчин өрхийн бэлтгэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх оновчтой тогтолцоог бий болгох”, зорилт 5.5-д “иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх...” гэж, зорилго 8.-д “нүүдлийн уламжлалт өв соёлыг хадгалсан, экологид ээлтэй, органик мал аж ахуйг тогтвортой эрхлэх, ...хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн тогтвор суурьшилтай ажиллаж, ая тухтай амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулна” гэж тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилт 4.4-д “эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг ханган, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн зорилт 1.2-д “нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” -ийн 3.1.14-д “эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн бодлого, хууль, эрх зүйн орчныг тодорхой болгоно” гэж, 3.3.6-д “малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, ...малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ” гэж, 3.3.11-д “...үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгоно” гэж, 6.2-д “бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэж тус тус заажээ.

Дээр дурдсан эрх зүйн орчин, төрийн бодлогын хүрээнд үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал, эдийн засгийн болон экологийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа малчдын нийгмийн харилцаанд оролцох эрх зүйн байдлыг тодорхой болгох, хүний эрхийн зарим баталгааг нь хуулиар хамгаалах эрх зүйн таатай орчин зайлшгүй шаардлагатай байна. Түүнчлэн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн “нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан улс орон байх” зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд манай улсын өргөн уудам нутаг, хил хязгаар болон нүүдэлчин ахуй, соёлыг үеэс үед өвлөн хадгалж, хамгаалж байгаа уугуул иргэд болох малчид, малчин өрхийн талаар төрөөс баримтлах бодлогод онцгой анхаарч, тэдгээрийн нийгмийн баталгаа, амьжиргааны нөхцөлийг сайжруулах, уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлээ тогтвортой эрхлэх, хөгжих таатай боломжийг бүрдүүлэх эрх зүйн үндэслэл, шаардлага байна.

Дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлага нь малчдын эрх зүйн байдлыг холбогдох хуулиудтай уялдуулж, бие даасан хуулиар нарийвчлан зохицуулах хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байна. Иймд Малчны тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан болно.

Хуулийн төслийн зорилго нь уламжлал, өв соёлыг хамгаалж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх малчны эрх зүйн үндсийг тодорхойлох, малчны хөгжил, бүтээмж, хариуцлагатай байдал, хамтын санаачилга, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдэнэ.

Хуулийн төсөл нь 6 бүлэг 21 зүйл бүхий бүтэцтэй байна. Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, эрх зүйн хүрээнд дараах эерэг үр дүн гарна. Үүнд:

- Малчдын эрх зүйн байдлыг тодорхой болгож, нийгмийн өмнө хүлээх эрх, үүргийг тогтоож, үйлдвэрлэгч-менежер, хариуцлагатай байх, хөгжих боломжийг нээнэ.
- Монгол орны бэлчээрийн мал аж ахуй эрхлэх өвөрмөц онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, зан заншлыг хадгалах, хамгаалахад чиглэгдсэн эрх зүйн зохицуулалтын орчин бүрдэнэ.
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрсдэл даах чадавхтай, үр ашигтай, тогтвортой хөгжилтэй салбар болгон хөгжүүлэх үзэл баримтлалыг хангана.
- Хариуцан ашиглах эзэн эрхийг малчдад олгох нөхцөлийг бүрдүүлснээр бэлчээрийн газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагааны хариуцагч эзэн тодорхой болно.
- Сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах малчдын зохион байгуулалтын тогтолцоо бүрдэнэ.

- Малчдын дунд уур амьсгалын өөрчлөлт, ган, зудын сөрөг нөлөөллөөс сэргийлэх менежментийг тодорхой болгосноор мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийг бууруулна.
- Малчдын залгамж халааг бэлтгэх, малчдад насан туршийн боловсрол олгох, мэдлэгжүүлэх, цахим системийг нэвтрүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.
- Малыг эдийн засгийн эргэлтэд тогтмол оруулах, ашиг шим, чанар, бүтээмжийг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх сонирхлыг бий болгоно.
- Малчдыг дэмжих үйл ажиллагааны зарчим, цар хүрээ, дэмжлэгийн хэлбэр, төрийн оролцоо, хязгаарыг тодорхой болно.
- Малчин өрхийн үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих, чанар-үнэ-урамшуулах тогтолцоог хөгжүүлж, эргэлтийг эрчимжүүлэх нөхцөлийг бүрдүүлснээр тэдгээрийн өрхийн орлого, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлнэ.
- Хөдөөд суурьшиж, уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэх малчныг урт хугацааны хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжсэнээр хотоос хөдөө рүү шилжих урсгалыг нээж, нийслэлийн хэт төвлөрөл, замын ачаалал, агаарын бохирдлын ачаалал, сөрөг нөлөөг бууруулна.
- Хариуцлагатай малчдыг хөнгөлөлттэй зээлийн болон татварын бодлогоор дэмжсэнээр малчдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, чадавхжих сонирхлыг нэмэгдүүлнэ.
- Малчдын хөдөөд ая тухтай ажиллаж, амьдрах орчныг сайжруулснаар хөдөөгийн хөгжилд ахиц гарч, малчинд хүргэх нийгмийн үйлчилгээний тогтвортой байдал, эрх тэгш байх эрх хангагдана.

Хуулийн төслийг боловсруулахдаа Засгийн газар, мал аж ахуйн салбарын судлаач, иргэдээс цахим болон утсаар санал авсан. Мөн олон улсын сайн туршлагаас судлан боловсруулсан болно.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Газрын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах ба хуулийн төсөлтэй холбогдуулан Малын генетик нөөцийн тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулна. Түүнчлэн хуулийн төсөлд Малчны хөгжлийн төвийн үйл ажиллагаа, малчны зохистой дадлыг үнэлж, баталгаажуулах, эрсдэлийн сангийн үйл ажиллагаа, хяналт шинжилгээ хийх, малчинд дэмжлэг үзүүлэх харилцааг журмаар зохицуулахаар заана.

“МАЛЧНЫ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Мал аж ахуй нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тулгуурын нэг бөгөөд хүн амыг гол нэрийн хүнсээр, уул уурхайн бус салбарын үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах эх үүсвэр нь болж, олон мянган өрхийн өдөр тутмын амьжиргаа, хэрэглээ тус үйлдвэрлэлээс хамааралтай байна. Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 10,9 хувь, экспортын орлогын 5,6 хувийг мал аж ахуй бүрдүүлж, орон нутгийн 80,0 гаруй хувь мал аж ахуйд суурилсан эдийн засагтай, нийт ажиллах хүчний 25,5 хувь¹ тус салбарт ажиллаж байна. Манай улсын нийт газар нутгийн 71,2 хувийг хамарсан мал аж ахуйн үйлдвэрлэлийг 246,3 мянган малтай өрх эрхэлж, үүнээс жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж буй 188,6 мянган малчин өрх² байна.

Монгол малчид нь мал аж ахуйг 10.0 мянга³ гаруй жилийн туршид үе дамжуулан эрхэлж, хүн төрөлхтний нүүдлийн соёл иргэншил, өв соёлыг тээгчид гэж дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, улс орныхоо хязгаар нутаг, хилийг хамгаалах, монгол ухаан, эх хэл, өв соёлыг хадгалах үндсэн цөм болж байна.

Гэвч монголчуудын олон мянган жилийн туршид хуримтлуулсан бэлчээрийн мал аж ахуйн эрхлэх арвин их уламжлалт мэдлэг, түүнээс үр шимийг нь хүртэж ирсэн арга барил, туршлагад дэлхийн даяаршил, техник, технологийн дэвшил нөлөөлж, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх үзэл баримтлал, чиг хандлага өдрөөс өдөрт өөрчлөгдөх боллоо. Малчдын өнөөгийн чадамж, чадавх, орчны нөхцөл, хөгжил, экологийн тэнцвэрт байдлын алдагдал, бэлчээрийн газрын төлөв байдал, ашиглалтаас үүдэлтэй зөрчил, маргаан, малын гаралтай түүхий эдийн үнэгүйдэл зэрэг нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн хүрээнд анхаарал татсан тулгамдсан асуудлууд болж байна.

Нүүдлийн мал аж ахуйн онцлогоо хадгалж үлдэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэлхийн ба улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн өөрчлөлт болон байгаль экологи, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож эрхлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэхийг хөгжлийн шаардлага бий болгож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан ч амьдрал дээр малчдын хувьд зарим эрх ашиг нь ихээхэн хөндөгдөх, эрх нь зөрчигдөх, төр иргэнийхээ өмнө үүргээ бүрэн биелүүлэхгүй, орхигдуулах асуудал байсаар байна.

Байгалийн бэлчээрт суурилсан уламжлалт аж ахуйг тогтвортой эрхлэх, хөгжүүлэх үндэс суурь нь малчид бөгөөд тэдгээр нь өрсөлдөх чадавхтай байж, мал сүргээ идээшлүүлэх газар нутгаа зохистой ашиглах, хамгаалах, хариуцлагатай эзэн

¹ Үндэсний статистикийн хорооны 2021 оны эмхэтгэл.

² Үндэсний статистикийн хорооны 2021 оны эмхэтгэл.

³ Малыг генетик нөөцийн үндэсний тайлан ХХААХҮЯ, 2021 он.

байх эрх, үүргээ хэрэгжүүлэх нь чухал боловч малчид эдэлбэр газартай холбогдсон “ашиглах, удирдан зохицуулах” эрхээ эдэлж чадахгүй байна.

Малчин өрх үе дамжин мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж ирэхдээ ашиглаж ирсэн өвөлжөө, хаваржаа, ус, мараа, хужир бүхий зуслан, намаржааны бэлчээр, өвс, хадлан бэлтгэдэг газрыг нутгийг нь нэг өглөө босоход уул уурхайн хайгуул, олборлолтын эсхүл бусад зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэчихсэн байдаг нь малчдын эрх ашгийг шууд хөндөж, мэдээлэл авах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, төрийн үйл хэрэгт оролцох хүний эрхийг нь зөрчиж байна. Зарим бүс нутагт уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн замбараагүй урсгал, замын тасралтгүй тоосжилт, тэсэлгээнээс үүдэлтэй бэлчээрийн газрын хөрс, шим, хүн, малын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл, үр дагавар учруулж байгаа нь нутгийн уугуул иргэд, малчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж байна. Мөн зайлшгүй шаардлагын улмаас оторлож байгаа малчдыг нутагтаа оруулахгүй байх, нутгаасаа хөөх, орон нутгийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь торгууль тавих, өндөр хэмжээгээр төлбөр авах, хөрөнгийн байдлаар нь тэгш бус хандах, төрийн үйлчилгээ үзүүлэхгүй байх зэргээр ялгаварлан гадуурхаж, хүний эрхийг нь зөрчих, “экологийн дүрвэгсэд”-ийн үзэгдэл нийгэмд түгээмэл болоод байна. Мал сүргээ жилийн дөрвөн улирлын туршид идээшлүүлэн бэлчээрлүүлэх, сэлгээн амраах, оторлон нүүдэллэх газар нутгийн хүрэлцээ нь өдрөөс өдөрт хумигдаж, уур амьсгал, байгаль экологийн өөрчлөлт, усны хомсдолын нөлөөлөлд өртсөн малчид, мал бүхий иргэдийн хооронд хагарал үүсэж маргалдах, зодолдох, улмаар бие биеийнхээ амь насанд хүрэх асуудал нийгэмд үүсэх болжээ. Түүнчлэн тариалангийн бүс нутагт бэлчээрийн мал аж ахуй эрхэлж буй уугуул болон суугуул малчдыг тухайн бүс нутгаас хаа нэг тийшээ мал, хашаа хороогоо аваад нүүх эсхүл малаа зараад эрчимжсэн аж ахуй эрхлэх, малын тоо толгойн албан татварыг өндөр дүнгээр төлөх зэрэг шахалтыг төрийн байгууллагаас үзүүлж эхэлсэн нь малчдын сэтгэл санаа, эрх ашигт шууд хохирол учруулж, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 18 дахь хэсэгт “улсынхаа нутаг дэвсгэрт түр буюу байнга оршин суух газраа сонгох...”, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт “...ажил мэргэжлээ сонгох...” гэсэн эрхийг нь зөрчиж байна.

Ийнхүү нүүх, суух бэлчээр нутгийн хүрэлцээгүйн улмаас малчид жилийн 4 улирлын туршид нэг газраа суурьшиж, суурин амьдралын хэв шинж рүү шилжих нь аажмаар нүүдлийн соёл иргэншлийн олон мянган жилийн түүх, ахуй, өв, уламжлалт мэдлэг, ондоошлогоо монголчууд алдаж, малын гаралтай органик бүтээгдэхүүн экспортлох боломжоо өөрсдийн гараар устгах эрсдэл өндөр байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэл дээр ажиллагсад нь жилийн 4 улирлын туршид амралтгүйгээр ажилладаг атлаа хөдөлмөрийн үнэлгээгүй, үйлдвэрлэлдээ хөрөнгө оруулалт хийх эрх зүйн баталгаа хангалтгүй, зонхилох хэсэг нь дэд бүтэц, нийгэм соёлын хөгжил, үйлчилгээ муутай алслагдсан бүс нутгийн хүнд нөхцөлд амьдарч байна. Түүнчлэн 15-24 насны залуу малчдын хүйсийн харьцаанд ихээхэн зөрүү үүсэж, эрэгтэй 67.7 хувь, эмэгтэй 32.3 хувийг бүрдүүлэх болсон нь хүн амын бодлогын түвшинд төрөөс анхаарвал зохих асуудал болж байна. Залуу малчдын дундах хүйсийн харьцааны зөрүү нь малчдын дундах гэрлэлт буурах, оройтох, төрөлт буурах, бэлгийн

зүй бус харилцаа олшрох, гэрлэлт дагасан шилжилт хөдөлгөөн эрчимжих, цаашлаад малчдын залгамж чанарт сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг дагуулж байна. хүн амын хот суурин дахь бөөгнөрөл, залуучуудын “хэт хотжих” чиг хандлагатай уялдан мал аж ахуйн салбарт ажиллах хүн хүчний сонирхлыг бий болгох, тэдгээрийн нийгмийн баталгааг хангах, мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлэн хөгжүүлэх, хөдөлмөрийн үнэлгээ бий болгох, мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэлт, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хөгжүүлэхэд төрийн оролцоог тодорхой болгож хуульчилж өгөх шаардлага байна.

Газар зүйн байршлын онцлогтой уялдаад манай улс уур амьсгалын өөрчлөлтөд дэлхийн дунджаас 3 дахин их хэмжээгээр өртөж, мөн хүний хүчин зүйлсийн сөрөг нөлөөллөөр хөрсний доройтол, цөлжилт, бэлчээрийн талхагдал, хомсдол өдрөөс өдөрт тэлж, ургамлын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, байгалийн унаган төлөв, экологийн тэнцвэрт байдал алдагдах эрсдэлд ороод байна. Тухайлбал, бэлчээрийн эдэлбэр газрын 57,0 хувь тодорхой хэмжээгээр доройтолд орж, 10,3 хувь нь байгалийн аясаар сэргэх боломжгүйгээр цөлжсөн⁴ байна. Нөгөө талаас бэлчээр, хадлангийн эдэлбэр газрын хэмжээ жилээс жилд буурч⁵ байхад түүний багтаамжийн зохист хэмжээ буюу малын тоо⁶ хонин толгойд шилжүүлснээр даруй 25 гаруй сая толгойгоор хэтэрчээ. Малын тоо өсөх нь малчдын амьжиргааг дээшлүүлэхэд хувь нэмэртэй ч байгалийн даацын чадамжийн хэтрэлт, байгаль, цаг уурын өөрчлөлт, ган зудын нөлөөллөөр малчид ихээхэн хохирол амсаж, улмаар амь зуулгаас салах үед суурин бараадаж, хотод төвлөрөл үүсгэх, ядуурал, ажилгүйдэл ихсэхэд шууд нөлөөлөл үзүүлдэг. Иймд малчдын дасан зохицох чадавхыг дээшлүүлэх, байгалийн эрсдэлт хүчин зүйлсийг даван туулах, түүнээс урьдчилан сэргийлэх, малын тоог экологид ээлтэй байх түвшинд барих, бэлчээрийг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, нэгж малаас авах бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагаа, нийгмийн харилцаанд төрийн оролцоо болон малчдын эрх, үүрэг, хариуцлагын механизмыг тодорхой болгох шаардлага ихээхэн байна.

Дэлхий нийтэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эдийн засгийн бусад салбараас ялгагдах онцлогтой гэж үзэж, үйлдвэрлэлийн харилцааг нь хуульчлан баталгаажуулах, төрийн дэмжлэгийн тухайлсан бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хүн амын хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийг тогтвортой байлгадаг. Ялангуяа хөгжсөн орнуудад хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн үнийн тогтворжуулалтыг хадгалах, зохицуулахын тулд мал аж ахуйн үйлдвэрлэлийг өөрийгөө зохицуулах чадвар султай, эрсдэлтэй бизнес гэж үзэж, фермерүүдэд байнгын дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, АНУ-д дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 1,0 хувь, Европын холбоонд 1,3 хувь, Японд 1,4 хувьтай тэнцэх санхүүжилтийн дэмжлэгийг улсын төсвөөс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд зарцуулж байна.

⁴ Монгол Улсын бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан, 2021 он.

⁵ Газрын нэгдмэл сангийн тайлан 2022 оны эмхэтгэл.

⁶ Үндэсний статистикийн хорооны 2022 оны эмхэтгэл.

Манай улсын хувьд хүн амын гол нэрийн хүнс, үндэсний хөнгөн аж үйлдвэрийн түүхий эдийг бэлтгэн нийлүүлдэг стратегийн ач холбогдол бүхий салбар мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой явуулах, хөгжүүлэх, нөөцийг нь бүрэн ашиглах зориулалтаар уул уурхайн салбараас орж ирж буй хөрөнгө оруулалтаас тодорхой хувийг тогтмол зарцуулах шаардлагатай байна. Нүүдлийн мал аж ахуй нь байгалийн шууд нөлөөл дор явагддаг эрсдэлтэй салбар гэж үздэг учраас арилжааны банкны зээлийн хүү өндөр (21.5%-23.7%) зээл өгдөг. Гэвч мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжсэн тохиолдолд түүний эрсдэлийг бууруулах нөхцөл бүрдэх тул санхүүгийн үйлчилгээний тусгайлсан арга хэмжээг малчдад зориулан хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Ялангуяа Засгийн газрын тусгай сан болон Малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэх сангаас малчдын тогтвортой үйлдвэрлэл, тэдгээрийн хөгжилд зориулж жил бүр олгох санхүүжилтийн хувь хэмжээг тогтоох нь нийгмийн тэгш, шударга, хүртээмжтэй байх эрхийг хангахаар байна.

Малчдын нөөц боломжийг нь нээж, тэгш эрх, нээлттэй өрсөлдөөнийг хөгжүүлэх, харилцан туршлага, мэдээллээ солилцох, үйл ажиллагааны үр өгөөж, чанарыг сайжруулах, нийгэм, эдийн засгийн харилцаанд малчны оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн тогтолцоог бүрдүүлэхэд эрх зүйн орчны дэмжлэг чухал байна. Цаашид мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, нүүдлийн соёл иргэншлийн уламжлалт өв соёл, байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ үлдээх боломжийг улам бүр багасах тул төрөөс тухайлсан бодлого, зохицуулалтаар шийдвэрлэх шаардлага их байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй", мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт "...хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй..." гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасан байна.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт "“Үндэсний язгуур ашиг сонирхол”-д Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана." гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.2-д "хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, ...салбарыг хөгжүүлнэ", 3.5.2.5-д "бэлчээрийн мал аж ахуй, малчдын ахуй амьдралд шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, уламжлалт сэтгэлгээ, арга хэвшлийг сэргээж, хурдацтай явагдаж

байгаа экосистемийн өөрчлөлтийг мэдэрч түүнд тохирсон, дасан зохицсон амьдралын хэв маяг, аж ахуй эрхлэх менежментийн арга барилыг боловсруулж заан сургах, туршин нэвтрүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон нийтэд хүргэх сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ.”, 3.5.2.2-т “бэлчээр ашигласны төлбөр тогтоох, эзэмшүүлэх, хамгаалах болон нөхөн сэргээх хариуцлага хүлээлгэх чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх...” талаар бодлогын баримт бичигт тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эрхэм зорилгод “...үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэж, ...өөрийгөө тэтгэсэн эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн, ...улс болж хөгжинө.” гэж, зорилт 1.2.-д “...үндэсний өв соёл, нүүдлийн ахуйг уламжлал, шинэчлэлтэй хослуулсан тэргүүлэх улс болж, нүүдлийн соёл иргэншлийг хадгалах, ...хамгаалахад чиглэсэн төрөлжсөн байгууллагуудтай болно.”, зорилт 2.3.-д “...гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.”, зорилт 2.6-д “хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.”, зорилго 3-д “хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, ...өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг бүрдүүлнэ.”, зорилт 3.3.5-д “малчин ...өрхийн аж ахуй эрхлэхэд нь ...санхүүгийн дэмжлэг үзүүлэх, малчин өрхийн бэлтгэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх оновчтой тогтолцоог бий болгох”, зорилт 5.5-д “иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх....” гэж, зорилго 8.-д “нүүдлийн уламжлалт өв соёлыг хадгалсан, экологид ээлтэй, органик мал аж ахуйг тогтвортой эрхлэх, ...хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн тогтвор суурьшилтай ажиллаж, ая тухтай амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулна” гэж тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилт 4.4-д “эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг ханган, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн зорилт 1.2-д “нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” -ийн 3.1.14-д “эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн бодлого, хууль, эрх зүйн орчныг тодорхой болгоно” гэж, 3.3.6-д “малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, ...малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ” гэж, 3.3.11-д “...үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгоно” гэж, 6.2-д “бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэж тус тус заажээ.

Дээр дурдсан эрх зүйн орчин, төрийн бодлогын хүрээнд үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал, эдийн засгийн болон экологийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа малчдын нийгмийн харилцаанд оролцох эрх зүйн байдлыг тодорхой болгох, хүний эрхийн зарим баталгааг нь хуулиар хамгаалах эрх зүйн таатай орчин зайлшгүй шаардлагатай байна. Түүнчлэн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн “нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан улс орон байх” зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд манай улсын өргөн уудам нутаг, хил хязгаар болон нүүдэлчин ахуй, соёлыг үезс үед өвлөн хадгалж, хамгаалж байгаа уугуул иргэд болох малчид, малчин өрхийн талаар төрөөс баримтлах бодлогод онцгой анхаарч, тэдгээрийн нийгмийн баталгаа, амьжиргааны нөхцөлийг сайжруулах, уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлээ тогтвортой эрхлэх, хөгжих таатай боломжийг бүрдүүлэх эрх зүйн үндэслэл, шаардлага байна.

Дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлага нь малчдын эрх зүйн байдлыг холбогдох хуулиудтай уялдуулж, бие даасан хуулиар нарийвчлан зохицуулах хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байна. Иймд Малчны тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан болно.

Хуулийн төслийн зорилго нь уламжлал, өв соёлыг хамгаалж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх малчны эрх зүйн үндсийг тодорхойлох, малчны хөгжил, бүтээмж, хариуцлагатай байдал, хамтын санаачилга, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдэнэ.

Хуулийн төсөл нь 6 бүлэг 21 зүйлтэй бүхий бүтэцтэй байх ба тус хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Хуулийн төслийн “Нэгдүгээр бүлэг.Нийтлэг үндэслэл”-д хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, холбогдох нэр томъёоны тодорхойлолтыг тусгана.

Хуулийн төслийн “Хоёрдугаар бүлэг.Малчны талаар талаар төрөөс баримтлах бодлого”-д мал аж ахуй, малчны талаар төрөөс баримтлах зарчим, чиглэлийг тодорхойлж, малчны уламжлал, өв соёл, ёс заншлыг өвлүүлэн хамгаалах, таниулах, малчны эрх, үүргийг тодорхолж зөв дадалыг эзэмшүүлэх харилцааг зохицуулна.

Хуулийн төслийн “Гуравдугаар бүлэг.Малчны хөгжил”-д малчны мэдлэгийг дээшлүүлэх хангах тогтолцоо, зарчмыг тодорхойлж, малчны хөгжлийн хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, малчны үйл ажиллагаанд цахим шилжилтийг нэвтрүүлэх, малчны цахим хөтөч мэдээллийн сан бүрдүүлэх, энэ чиглэлийн үйлчилгээг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгана.

Хуулийн төслийн “Дөрөвдүгээр бүлэг.Малчны бүтээмж”-д малчны үйлдвэрлэлийн цар хүрээ, чадавх, хөдөлмөрийн бүтээмжийн болон малчны мэргэшлийн үнэлэмжийн ангиллыг тогтоох, баталгаажуулах харилцааг зохицуулахаар

заана. Түүнчлэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхдээ байгальд ээлтэй байх зохистой дадлын шаардлага, шалгуурыг хангахтай холбоотой хариуцлагатай байдлыг нь үнэлж, баталгаажуулах, малчны өрсөлдөх чадвар, нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмрийг бэхжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар заана.

Хуулийн төслийн “Тавдугаар бүлэг. Малчны хамтын санаачилгыг дэмжих”-д малчны хамтын санаачилга, хоршил, кластерын үйл ажиллагааны хэлбэр, малчны өөрөө удирдах байгууллагын тогтолцоог тодорхой болгож, малчинд үзүүлэх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан малчны хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, эдийн засгийн чадамжийг сайжруулах, малчны нийгмийн баталгааг сайжруулах, малчны гэр бүл ая тухтай амьдрах, ажиллах, хүүхэд нь сурах таатай нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой харилцааг хуульчилна. Мөн малчны амьжиргааны түвшинтэй уялдуулан төрөөс үзүүлэх хөнгөлөлт, дэмжлэг тодорхой байхаар тусгана.

Хуулийн төслийн “Зургаадугаар бүлэг. Бусад зүйл”-д хуулийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр, хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг зохицуулахтай холбогдсон харилцааг тусгана. Мөн хууль хүчин төгөлдөр болох хугацааг заана.

Энэ хуулийн төсөл нь бусад холбогдох хууль тогтоомж, салбарын бодлоготой уялдаж байгаа тул сөрөг үр дагавар авчрахгүй гэж үзэж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, эрх зүйн хүрээнд дараах эерэг үр дүн гарна. Үүнд:

- Малчдын эрх зүйн байдлыг тодорхой болгож, нийгмийн өмнө хүлээх эрх, үүргийг тогтоож, үйлдвэрлэгч-менежер, хариуцлагатай байх, хөгжих боломжийг нээнэ.
- Монгол орны бэлчээрийн мал аж ахуй эрхлэх өвөрмөц онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, зан заншлыг хадгалах, хамгаалахад чиглэгдсэн эрх зүйн зохицуулалтын орчин бүрдэнэ.
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрсдэл даах чадавхтай, үр ашигтай, тогтвортой хөгжилтэй салбар болгон хөгжүүлэх үзэл баримтлалыг хангана.
- Хариуцан ашиглах эзэн эрхийг малчдад олгох нөхцөлийг бүрдүүлснээр бэлчээрийн газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагааны хариуцагч эзэн тодорхой болно.
- Сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах малчдын зохион байгуулалтын тогтолцоо бүрдэнэ.
- Малчдын дунд уур амьсгалын өөрчлөлт, ган, зудын сөрөг нөлөөллөөс сэргийлэх менежментийг тодорхой болгосноор мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийг бууруулна.

- Малчдын залгамж халааг бэлтгэх, малчдад насан туршийн боловсрол олгох, мэдлэгжүүлэх, цахим системийг нэвтрүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.
- Малыг эдийн засгийн эргэлтэд тогтмол оруулах, ашиг шим, чанар, бүтээмжийг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх сонирхлыг бий болгоно.
- Малчдыг дэмжих үйл ажиллагааны зарчим, цар хүрээ, дэмжлэгийн хэлбэр, төрийн оролцоо, хязгаарыг тодорхой болно.
- Малчин өрхийн үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих, чанар-үнэ-урамшуулах тогтолцоог хөгжүүлж, эргэлтийг эрчимжүүлэх нөхцөлийг бүрдүүлснээр тэдгээрийн өрхийн орлого, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлнэ.
- Хөдөөд суурьшиж, уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэх малчныг урт хугацааны хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжсэнээр хотоос хөдөө рүү шилжих урсгалыг нээж, нийслэлийн хэт төвлөрөл, замын ачаалал, агаарын бохирдлын ачаалал, сөрөг нөлөөг бууруулна.
- Хариуцлагатай малчдыг хөнгөлөлттэй зээлийн болон татварын бодлогоор дэмжсэнээр малчдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, чадавхжих сонирхлыг нэмэгдүүлнэ.
- Малчдын хөдөөд ая тухтай ажиллаж, амьдрах орчныг сайжруулснаар хөдөөгийн хөгжилд ахиц гарч, малчинд хүргэх нийгмийн үйлчилгээний тогтвортой байдал, эрх тэгш байх эрх хангагдана.

Хуулийн төслийг боловсруулахдаа Засгийн газар, мал аж ахуйн салбарын судлаач, иргэдээс бичгээр, цахим болон утсаар санал авсан. Мөн олон улсын сайн туршлагаас судлан боловсруулсан болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан дараах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна. Үүнд:

- Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан. Хуулийн төсөл нь 2 зүйлтэй байх бөгөөд 1 дүгээр зүйлд Малын генетик нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгээс “малчинд мэргэжлийн үнэмлэх”, 8.8 дахь хэсгээс “мэргэжлийн үнэмлэх” гэснийг хасах, 2 дугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх хугацааг тусгана.
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна. Хуулийн төсөл 3 зүйлтэй байна. 1 дүгээр зүйлд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “24.1.6.Малчны тухай хуульд заасан бол.” гэж нэмэх, 2 дугаар зүйлд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5 дахь заалтын “.” гэснийг “;” гэж өөрчлөх, 3 дугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх хугацааг тусгана.

- Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл боловсруулна. Хуулийн төсөл 2 зүйлтэй байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Зөрчлийн тухай хуулийн Арван гуравдугаар бүлэгт “13.10 дугаар зүйл.Малчны тухай хууль зөрчих 1.Малчны тухай хуулиар тогтоосон журам зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэх агуулгатай зүйл нэмэх, 2 дугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх хугацааг тусгана.
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан. Хуулийн төсөл 2 зүйлтэй байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.44 дэх дэд заалтын “13.9 дүгээр” гэснийг “13.9, 13.10 дугаар” гэж өөрчлөх, 2 дугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх хугацааг тусгасан болно.

-----oOo-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛЧНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь мал аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх малчны эрх зүйн байдлыг тодорхойлж, малчны ажиллах, амьдрах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлж, байгалийн чадамжид нийцсэн, бүтээмж бүхий өрсөлдөх чадвартай мал аж ахуйг хөгжүүлэхэд оршино.

2 дугаар зүйл.Малчны тухай хууль тогтоомж

2.1.Малчны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Газрын тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Малын тоо толгойн албан татварын тухай хууль, энэ хууль болон малчны үйл ажиллагаатай холбогдсон бусад хууль тогтоомжийн актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь малчин болон мал бүхий иргэн, аж ахуй нэгжийн эрхлэх үйл ажиллагаа, үйлдвэрлэлийг дэмжих, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцаанд хамаарна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“мал аж ахуй” гэж байгаль цаг уурт дасан зохицсон, байгалийн нөөц, чадавхад нийцсэн, уламжлалт болон шинжлэх ухаанч арга барилд суурилсан мал аж ахуйн үйлдвэрлэлийг;

4.1.2.“малчин” Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасан иргэнийг;

4.1.3.“туслах малчин” гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 71.2-т заасныг;

4.1.4.“хот айл” гэж мал аж ахуй эрхэлсэн 2 ба түүнээс дээш малчин өрх хамтран нүүдэллэж, хөдөлмөрөө хоршин мал сүргээ маллах, ашиг шимийг хамтын хүчээр авдаг хөдөлмөр зохион байгуулалтын хэлбэрийг;

4.1.5.“мал аж ахуйн зохистой дадал” гэж хүн, байгальд ээлтэй малчны мал маллагаа, бэлчээр нутаг, малын эрүүл мэнд, үүлдэр угсаа, малын ашиг шим, түүхий эдийн чанар, аюулгүй байдлыг хангах арга барилыг;

4.1.6.“малчны хөгжил” гэж малчин насан туршид мэдлэг, ур чадвар, амьдралын чанараа дээшлүүлэх тогтвортой үйл ажиллагааг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МАЛЧДЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО

5 дугаар зүйл.Малчдын талаар төрөөс баримтлах бодлого

5.1.Малчдын талаар дараах бодлогыг авч хэрэгжүүлнэ:

5.1.1.малчинд мал аж ахуйн үйлдвэрлэлээ тогтвортой эрхлэх суурь нөхцөл, байгалийн нөөц, бэлчээр ашиглах эрхийг баталгаажуулах;

5.1.2.малчны хөгжлийг хангах;

5.1.3.хөдөөд хүйсийн зохистой харьцааг хангах бодлогыг хэрэгжүүлэх;

5.1.4.малчны хөдөлмөрийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх;

5.1.5.малчдын залуу халааг бэлтгэх, чадваржуулах, оролцоо идэвхийг нэмэгдүүлэх, тогтвортой, чанартай амьдрах хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

5.1.6.мал аж ахуйн байгаль цаг уурын эрсдэл даах чадамжийг бүрдүүлэх, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, боловсруулалтын түвшинг ахиулах цогц бодлогыг хэрэгжүүлэх;

5.1.7.мал аж ахуй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд цахим шилжилтийг нэвтрүүлэх;

5.1.8.хуульд заасан бусад дэмжлэг.

5.2.Засгийн газраас дараах бодлогыг авч хэрэгжүүлнэ:

5.2.1.мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлж, үүний хэрэгжилтийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үе шаттай тусгаж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;

5.2.2.мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, малчин өрхийн амьдралын чанарыг дээшлүүлэх үүднээс хөрөнгө оруулалт, хөгжлийн зээл, дэмжлэг, санхүүгийн үйлчилгээг сайжруулах;

5.2.3.мал үржүүлэг, технологи болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн ажил үйлчилгээг технологийн хугацаанд чанартай гүйцэтгэх чадавхыг бий болгоход дэмжлэг үзүүлж, гүйцэтгэл үр дүнд нь хяналт тавих;

5.2.4.малчдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулах үүднээс ипотекийн хөтөлбөрт хамруулах, зээлийн хөнгөлөлт үзүүлэх;

5.2.5.малчнаар 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны нэг хүүхдийг мал аж ахуй, тэжээл бэлчээрийн чиглэлийн мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй суралцуулах;

5.2.6.малчид жил тутам холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулах;

5.2.7.байгалийн гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас малчин нь ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд хөдөлмөр хөлсний 4 жилийн доод хэмжээтэй тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь олгох;

5.2.8.байгалийн гамшигт болон аюулт үзэгдэлд нийт мал сүргийнх нь 50 хувиас доошгүй нь өртсөн малчин өрх болон хонин толгойд шилжүүлснээр 250 хүртэл малтай, 16-40 хүртэлх насны малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хамруулах;

5.2.9.хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх;

Тайлбар: Энэ заалтыг 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.

5.2.10.хууль тогтоомжид заасан бусад.

5.3.Энэ хуулийн 5.2.4-5.2.9-д заасан малчинд үзүүлэх дэмжлэгийн нөхцөл, журмыг Засгийн газар тус тус батална.

6 дугаар зүйл.Малчны эрх, үүрэг

6.1.Малчин нь дараах эрх эдэлнэ:

6.1.1.уур амьсгалын өөрчлөлт, зах зээлийн нөхцөлд мал маллах арга ухааныг эзэмшиж, мэдлэг, туршлага, ур чадвар, арга барилаа ахиулж, малчинд зориулсан сургалт мэдээлэл, зөвлөгөө авах;

6.1.2.мал аж ахуйн үйлдвэрлэлээ тогтвортой эрхлэх суурь нөхцөл байгалийн нөөц, бэлчээр гэрээгээр ашиглах эрхээ баталгаажуулах;

6.1.3.бэлчээрийн даацыг улирлын хуваарьтай зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах;

6.1.4.төрөөс болон олон улсын байгууллагын санхүүжилтээр олгосон хөрөнгө оруулалт, хөгжлийн зээл, дэмжлэг, санхүүгийн үйлчилгээг эдлэх;

6.1.5.малын эрүүл мэнд болон үржил технологийн ажил үйлчилгээг эрх бүхий нэгжээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх;

6.1.6.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлт, нэр төрөл, чанараас хамаарсан урамшуулал, үнийн механизмыг бий болгох, үнэлэмжийг нэмэгдүүлэх,

6.1.7.хуулиар эдлэх бусад эрх.

6.2.Малчин нь дараах үүрэг хүлээнэ:

6.2.1.нутаг орноо хамгаалах, байгалийн нөөц, бэлчээр, усан хангамжийг зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх;

6.2.2.мал маллагааны уламжлалт болон шинжлэх ухаанч арга барилыг эзэмших;

6.2.3.малын эрүүл мэнд, үржил технологийн ажлыг стандартын дагуу хийх;

6.2.4.малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангах;

6.2.5.төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

6.2.6.хуулиар хүлээсэн бусад үүрэг.

6.3.Энэ хуулийн 6.2.1-д заасан үүргийг хүлээхдээ дараах зохистой дадлыг хангасан байна:

6.3.1.малчин өрх, хот айл нь бэлчээр нутгаа дундаа хамтран ашиглаж ирсэн уламжлал дээрээ үндэслэн харилцан зөвшилцөж, зохион байгуулалтад орсон байх;

6.3.2.бэлчээрийг даацад нь нийцүүлэн улирлын хуваарьтай ашиглаж, сэлгэх, өнжөөх, сайжруулж бэлчээрийн төлөв байдал, голлох зүйл ургамлын эзлэх хувийг гэрээ байгуулах үеийн тогтоосон суурь түвшнээс бууруулаагүй байх;

6.3.3.тэжээлийн ургамлыг тариалах, орон нутгийн нөөц боломж дээр тулгуурлаж гар тэжээл, хадлан бэлтгэх.

6.4.Энэ хуулийн 6.2.2-т заасан үүргийг хүлээхдээ дараах зохистой дадлыг хангасан байна:

6.4.1.мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг өөрийн малын тоо толгойд нийцүүлэн бүрэн хангаж, 90-ээс доошгүй хоногт хүрэлцэхүйц өвс, нэмэгдэл тэжээл бэлтгэж нөөцлөх;

6.4.2.байгаль цаг уурын нөхцөлийг хангахуйц өвөлжөө, хаваржааны хашаа, саравч, хороо, байр, зөөврийн хашаатай байх;

6.4.3.малын хэвтэр бууц, хашаа хороог байнга цэвэрлэж, өвөлжөөний хөрзөнг жил бүр авдаг, өтөг хөрзөнг овоолж хэвтрийн нөөц бүрдүүлдэг байх;

6.4.4.дөрвөн улиралд нүүдэллэхдээ орчны хогийг цэвэрлэж, байгаль орчин бохирдуулахгүй, хог хаягдал үлдээдэггүй байх;

6.4.5.уст цэг, худаг, хөв цөөрөм бий болгох, сэргээн засварлах;

6.4.6.мал маллах, хариулах, тууварлах, тээвэрлэхдээ уламжлалт арга барилыг түлхүү ашиглах.

6.5.Энэ хуулийн 6.2.3-д заасан үүргийг хүлээхдээ дараах зохистой дадлыг хангасан байна:

6.5.1.тухайн бүс нутагт зөвшөөрөгдсөн үүлдрийн малаар үржил технологийн ажлыг явуулж хээлтүүлэгч мал нь үржлийн гэрчилгээтэй, бүртгэлтэй байх;

6.5.2.малын төрөл, сүргийн бүтцийг зохистой хангаж, тодорхой хувийг тухайн жилд эдийн засгийн эргэлтэд оруулж, борлуулдаг байх;

6.5.3.тухайн үүлдэр, омгийн нэгж малаас авч болох ашиг шимийн дундаж гарцаас багагүй тоо, хэмжээнд болон түүнээс дээш байх;

6.5.4.мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд 3 жил тутамд чанарын үнэлгээ хийлгэх;

6.5.5.малын эрүүл мэнд, үржүүлэг, технологийн үйлчилгээг мэргэжлийн нэгжээс авах, гэрээ байгуулах;

6.5.6.хээлтүүлэгчийн хүрэлцээг тогтоосон нормд байхаар зохион байгуулах, малын шилжилт хөдөлгөөний талаар мэргэжлийн байгууллагад заавал мэдээлэх;

6.5.7.малын гоц халдварт, халдварт, зооноз, паразит өвчнөөс урьдчилан сэргийлсэн байх;

6.5.8.мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдал, эрүүл мэнд, гарал үүслийн түүхийг мөшгөх нөхцөлийг бүрдүүлж малын шилжилт хөдөлгөөнийг хянадаг, мэдээлдэг байх;

6.5.9.малын эм болон төрөл бүрийн химийн бэлдмэлийн хэрэглээний зохистой дадлыг нэвтрүүлэх, эмийн үлдэгдэл агуулаагүй, баталгаатай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх.

6.6.Энэ хуулийн 6.2.4-д заасан үүргийг хүлээхдээ дараах зохистой дадлыг хангасан байна:

6.6.1.түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг үнэлүүлж, суурь түвшнийг сайжруулах арга замыг боловсруулж, мөрдөн ажиллах;

6.6.2.малын ноос, ноолуур, хөөврийг технологийн хугацаанд холбогдох стандартын шаардлагын дагуу чанарын ялгаатай байдлаар ангилан тордож, бэлтгэн нийлүүлэх;

6.6.3.малын мах бэлтгэлийг хийхдээ малын арьс ширийг механик гэмтэлгүйгээр хоёр цагийн дотор цэвэрлэгээ, анхан шатны тордолтыг хийж, холбогдох стандартын шаардлагын дагуу чанарын хамгаалалттайгаар бэлтгэх;

6.6.4.малын сүү, сүүн бүтээгдэхүүнд тавигдах ерөнхий шаардлагын стандартыг ханган бэлтгэж, эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй байдлыг хангасан байх.

6.7.Малчны хүлээх үүргийн хүрээнд эзэмшсэн зохистой дадлыг үнэлж, баталгаажуулах, журмыг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ МАЛЧНЫ ХӨГЖИЛ

7 дугаар зүйл.Малчны мэдлэгийг дээшлүүлэх тогтолцоо, зарчим

7.1.Малчны мэдлэгийг дээшлүүлэх тогтолцоо нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх мэдлэг олгох, тасралтгүй хөгжүүлэх, чадавхжуулах, мэргэшүүлэх үйл явцаас бүрдэнэ.

7.2.Малчныг өдөр тутмын мэдээ, мэдээллээр хангах тогтолцоо нь малчны эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлж мэдээллийн сан бүрдүүлэх, нэг цонхны цахим хөтөч системд суурилна.

7.3.Энэ хуулийн 7.1-д заасан мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх мэдлэг олгох, тасралтгүй хөгжүүлэх, чадавхжуулах, мэргэшүүлэх сургалтыг мал аж ахуйн чиглэлийн боловсрол, сургалт хариуцсан төрийн байгууллага удирдаж, их сургууль, коллеж, мэргэжил, сургалт үйлдвэрийн төв, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор үндэсний хэмжээнд зохион байгуулна.

7.4.Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх мэдлэг олгох, тасралтгүй хөгжүүлэх, чадавхжуулах, мэргэшүүлэх сургалтын нэгдсэн стандарт, бүс нутгийн онцлогт нийцүүлсэн сургалтын хөтөлбөртэй байна.

7.5.Энэ хуулийн 7.3-д заасан байгууллага нь сургалтын нэгдсэн стандарт, хөтөлбөрийг багцлан боловсруулах ба хөтөлбөрт дор дурдах чиглэлийн мэдлэг, ур чадварыг заавал олгохоор тусгана:

7.5.1.мал маллах, байгаль, цаг уур шинжих, мал аж ахуйн болон ахуй амьдралд шаардлагатай тоноглол, хэрэгслүүд бэлтгэх уламжлалт арга барил, өв соёл, туршлага;

7.5.2.мал аж ахуйн салбарын хөгжлийн чиг хандлага, нийгмийн эрэлт, хэрэгцээ, шаардлага, техник технологийн хөгжил дэвшил;

7.5.3.малын чанарыг сайжруулах, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал маллах, тэжээх, арчлах болон малын өвчин, эмчилгээ, сувилгааны арга технологийн мэдлэг мэдээлэл, цуврал хичээл;

7.5.4.бэлчээрийн сэргэх чадавхад суурилсан менежментийг хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн мэдлэг олгох мэдээлэл, цуврал хичээл;

7.5.5. малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх стандартууд;

7.5.6. зах зээлд нийлүүлэх, бүтээгдэхүүн хөгжүүлэх, үнэ цэнийг нэмэгдүүлэх арга замууд;

7.5.7. малын өтөг бууц, аргал, хөрзөнг цэвэрлэх, дахин боловсруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах техник, технологийн мэдлэг;

7.5.8. ногоон үйлдвэрлэл, ухаалаг мал аж ахуй эрхлэх арга, технологи, ач холбогдол;

7.5.9. малчдын нийгмийн болон эрүүл мэндийн, эд хөрөнгийн даатгалын ач холбогдол;

7.5.10. малын тоо толгойн албан татварын тайланг цахимаар гаргах, малчны цахим хөтөч, төрийн үйлчилгээний цахим системийг ашиглах аргачлал.

7.6. Сургалтын хөтөлбөрөөр бүрэн суралцсан, үнэлгээний шаардлага хангасан төгсөгчид малчин мэргэжлийн үнэмлэх, тэмдэг олгоно.

8 дугаар зүйл. Малчны хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөр

8.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлд суурилсан эдийн засагтай орон нутгийн засаг захиргааны нэгж нь малчдад төрийн бодлого, хууль эрх зүйн мэдлэг олгох, харилцан мэдлэг, туршлагаа солилцох, залуу үеэ бэлтгэх таатай орчныг бүрдүүлсэн Малчны хөгжлийн сургалт, мэдээллийн төв эсхүл тэнхимтэй /цаашид “Малчны хөгжлийн төв” гэх/ байна.

8.2. Орон нутгийн онцлогт нийцүүлж, малчны хөгжлийг дэмжихэд чиглэсэн Малчны хөгжлийн төсөл, хөтөлбөрийг сум, аймаг бүр боловсруулж, хэрэгжүүлэх ба тэтгэлгээр суралцах мэргэжлийн тэргүүлэх чиглэлд малчны мэргэжлийг хамруулахаар тусгана.

8.3. Сумын төрийн захиргааны байгууллага нь малчинд насан туршийн боловсрол, мэдлэг олгохтой холбогдуулан дараах чиг үүргийг хариуцан хэрэгжүүлнэ:

8.3.1. малчдаас гаргасан санал, хүсэлтэд суурилан малчныг сургах, шинээр бэлтгэх, давтан сургах сумын жил бүрийн төлөвлөлтийг боловсруулах, холбогдох сургалтын байгууллагад захиалга өгөх;

8.3.2. малчдаас нөлөө бүхий төлөөллийг сонгож, манлайлагчийн сургалтын хөтөлбөрт хамруулах;

8.3.3. залуу малчид, мал бүхий иргэдийн дунд малчдын залгамж халааг бэлтгэх, чадавхжуулах чиглэлээр ахмад, туршлагатай малчидтай туршлага солилцох уулзалт, сургалт, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулж, малчдын оролцоог хангах;

8.3.4. малчны хөгжлийн төвийн үйл ажиллагаанд зарцуулах зардлыг жил бүрийн аймаг, сумын төсөвт тусгах;

8.3.5. хуульд заасан бусад чиг үүрэг.

8.4. Энэ хуулийн 8.2-т заасан төсөл, хөтөлбөрийг аймаг, сумын Засаг дарга тус тус баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

8.5. Энэ хуулийн 8.2, 8.3.4-т заасан төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардлыг тухайн шатны төсвийн захирагч нар жил бүрийн төсөвт тусгаж, батлан хэрэгжүүлнэ.

8.6. Энэ хуулийн 8.5-д заасан төсвийг малын тоо толгойн албан татвараас төвлөрөх орлогын эх үүсвэрээс бүрдүүлэх асуудлыг холбогдох журамд заасны дагуу хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

8.7. Малчны хөгжлийн төвийн ажиллах журмыг тухайн багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батална.

8.8. Малчны хөгжлийн индексийг сум, аймаг, үндэсний түвшинд 3 жил тутамд тодорхойлж байна.

8.9. Малчны хөгжлийн индексийг аймаг, сум, улсын аварга малчин болон тэргүүний аймаг, сум, дүүрэг шалгаруулах шалгуур үзүүлэлтэд харгалзан үзнэ.

8.10. Малчны хөгжлийн индексийг тооцох аргачлалыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран баталж, үр дүнд хяналт тавина.

9 дүгээр зүйл. Малчны үйл ажиллагаанд цахим шилжилтийг нэвтрүүлэх

9.1. Малчны үйл ажиллагаанд цахим шилжилтийг нэвтрүүлж, цахим малчныг хөгжүүлнэ:

9.1.1. хөдөлгөөнт холбоо, телевиз, интернэт сүлжээний үйлчилгээ;

9.1.2. мэдээлэл авах, солилцох нэг цонхны цахим үйлчилгээ;

9.1.3. банк, санхүү, татвар, төлбөр, тооцоо, худалдааны цахим үйлчилгээ;

9.1.4. төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээний цахим систем;

9.1.5. малын бүртгэлийн систем;

9.1.6. гойд ашиг шимт, шилмэл малын үзэсгэлэн, дуудлага худалдаа, захиалга, малын тэжээл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн цахим худалдаа;

9.1.7. газрын бүртгэл, кадастрын зураглал, бэлчээрийн төлөв байдал, чанарын үнэлгээний үйлчилгээ;

9.1.8.технологийн сүлжээгээр дамжуулан малчдад мэдлэг түгээх бусад цахим үйлчилгээ.

9.2.Малчны болон тэдгээрийн үйл ажиллагааны бүртгэл нь хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын болон улсын бүртгэлийн, татварын, статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын цахим бүртгэлээр тус тус баталгаажна.

9.3.Мал, малын гаралтай чанартай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхдээ бүртгэл, мөшгих тогтолцоо, хяналтын үйл ажиллагааг мэдээлэл технологид суурилсан баталгаажуулалтад үндэслэн хийнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МАЛЧНЫ БҮТЭЭМЖ

10 дугаар зүйл.Малчны бүтээмжийг дэмжих

10.1.Малчны хөдөлмөрийн бүтээмж, үр ашгийг тооцох арга зүйг бий болгож, үндэсний хэмжээнд нэвтрүүлнэ.

10.2.Малчны боловсрол, малын эрүүл мэнд, үржил селекции технологийн ажил, арчилгаа маллагаа, тэжээлийн хангамж, хашаа хороо, мал аж ахуйн үйл ажиллагааг хөнгөвчлөх шинэ арга, техник технологи зэрэг хүчин зүйлсийг дэмжин хөгжүүлж малчны болон салбарын бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлнэ.

10.3.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашиг, нөөц ашиглалтын түвшний өсөлт болон малчны хүлээх үүрэг, зохистой дадлын үнэлгээний үзүүлэлтийг улс, аймаг, сумын аварга, малчин, тэргүүний малчны нөхөрлөл, хоршоо, аймаг, сум шалгаруулах болзолд тусгаж, бүтээмжийг үнэлнэ.

10.4.Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоонд нэр төрөл, чанарын үнэлэмжээс хамаарсан урамшуулал, үнийн үнэлгээг тогтоож, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

10.5.Сум, баг өөрийн онцлогт тохирсон цөм сүргийг бүрдүүлж, мал үржлийн ажлыг явуулж, малын чанар, ашиг шимийн өсөлт, чанарыг тооцдог системд шилжүүлнэ.

10.6.Малын эрүүл мэндийн үйлчилгээг үнэлж, дүгнэдэг болж эрүүл мал сүрэгтэй малчин өрхийг баталгаажуулна.

10.7.Мал, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын баталгаажуулалт, зах зээлийн ханшид суурилсан хөрөнгийн үнэлгээ хөгжүүлэлтийг бий болгож, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд нэвтрүүлнэ.

10.8.Мал аж ахуйн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, малчны өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх, малчны идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор жил бүрийн намрын эхэн сарын шинийн 8-ны өдөр нь "Малчныг сонсох өдөр" байна.

10.9.Энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, аймаг, сумын хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага тус тус хэрэгжүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ МАЛЧНЫ ХАМТЫН САНААЧИЛГЫГ ДЭМЖИХ

11 дүгээр зүйл. Малчны хамтын санаачилга, хоршил, кластерын үйл ажиллагаа

11.1. Малчны хамтын санаачилга, хоршил нь дараах хэлбэртэй байна:

11.1.1. хот айл;

11.1.2. малчдын холбоо;

11.1.3. малчдын үүсгэн байгуулсан ашгийн төлөө байгууллага.

11.2. Энэ хуулийн 11.1.1-11.1.2-д заасан малчны хамтын хоршлын хэлбэр нь Иргэний хуулийн 481.1, 481.2-д заасны дагуу сайн дурын үндсэн дээр зохион байгуулагдаж, үйл ажиллагааны чиглэл, хамтран ажиллах хэлбэрээ харилцан тохиролцож, зөвшилцөн, тэдгээрийг дүрмээр баталгаажуулсан байна.

11.3. Энэ хуулийн 11.1.3-д заасан хамтын хоршлын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа Компанийн тухай болон Хоршооны тухай хуулиар зохицуулагдана.

11.4. Малчны хамтын санаачилга, хоршлыг төрөөс дараах байдлаар дэмжинэ:

11.4.1. хамтран ажиллах хорших, төрөлжих эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

11.4.2. дэд бүтцийн хангамжийг сайжруулах;

11.4.3. мал, малын гаралтай түүхий эдийн бэлтгэл, нийлүүлэлт, үйлдвэрлэл, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бүрдүүлэх, тэдгээрт малчны хувь нийлүүлсэн оролцоог дэмжих;

11.4.4. малчин өрхийн орлогыг бууруулахгүйгээр бэлчээрийн даацаас хэтэрсэн малын тоог үе шаттай бууруулах, малыг борлуулах үр дүнтэй арга, тэргүүн туршлагыг дэлгэрүүлэх;

11.4.5. малчны санхүүгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, малчны эдийн засгийн чадамжийг сайжруулахад чиглэгдсэн хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны цар хүрээг тэлэх, санхүүгийн хүртээмжтэй байдал, чадамжийг нэмэгдүүлэх;

11.4.6. малчин, малчны бүлгийн санал, санаачилгаар цас борооны ус тогтоох, усан сан, нуур, хөв, цөөрөм байгуулах, сэргээгдэх эрчим хүч ашиглах, малын өвс, тэжээл бэлтгэх, нөөцлөхөд зээлийн бодлогыг хэрэгжүүлэх;

11.4.7.байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр санаачлах аливаа малчны хамтын санаачилга, хоршлын үйл ажиллагаа, хөтөлбөрийг дэмжих;

11.4.8.хуульд заасан бусад.

11.5.Хамтын зохион байгуулалтын нэгдэл, кластерын үйл ажиллагаа эрхлэх.

12 дугаар зүйл.Малчны өөрөө удирдах байгууллагын тогтолцоо

12.1.Малчид үйл ажиллагааны чиглэлийн дагуу сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, хамтын менежментийг төлөвшүүлж, эрх ашгийг нь хамгаалдаг, гишүүддээ үйлчилдэг малчны өөрөө удирдах байгууллагын тогтолцоог бүрдүүлж болно.

12.2.Малчны өөрөө удирдах байгууллагын тогтолцоо нь баг, сум, аймгийн түвшинд холбоо, үндэсний хэмжээнд иргэний нийгмийн байгууллагын нэгдсэн холбоо гэсэн шаталсан хэлбэрээр зохион байгуулагдаж, үйл ажиллагаа явуулна.

13 дугаар зүйл.Малчин өрх тэдгээрт газар эдэлбэрийн эрхийг баталгаажуулах

13.1.Малчин өрхийн өвөлжөө, хаваржааны газрын хил заагийг бэлчээрийн даац, малын тоо толгойтой нь уялдуулан тогтоож, гэрээгээр ашиглуулах харилцааг баталгаажуулж, гэрээ байгуулна.

13.2.Өвөлжөө, хаваржааны гэрээгээр ашиглуулах бэлчээрийн газарт гэрээ байгуулах журмыг Засгийн газар батална.

13.3.Өвөлжөө, хаваржааны гэрээгээр ашиглуулах газрыг зөвхөн бэлчээрийн зориулалтаар ашиглана.

13.4.Газрын тухай хуулийн 52.7-д заасан газрыг өөр чиглэлээр давхцуулан газар ашиглах, эзэмшүүлэх, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохгүй.

13.5.Мал сүргээ идээшлүүлэх зориулалтаар өвөлжөө, хаваржааны болон зуслан, намаржааны бэлчээрийн эдэлбэр газрыг улирлын онцлогтой уялдуулан орон нутгийн бэлчээр ашиглалтын журмын дагуу хязгаарлалттай хүрээнд хамтын оролцоонд тулгуурласан малчдын холбоонд гэрээгээр ашиглуулж болно.

13.6.Малчин өрхөөс шинээр гэр бүл болж өрх тусгаарласан малчин залуу гэр бүл болон хот, суурингаас шилжин очиж, 2-оос доошгүй жил тасралтгүй мал маллаж байгаа малчин өрхөд энэ хуулийн 13.1-д заасан эрхийг олгох асуудлыг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, баг, хорооны Иргэдийн нийтийн хурлын шийдвэрт үндэслэн сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ.

13.7.Газрын харилцаатай холбоотой бусад асуудлыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу зохицуулна.

14 дүгээр зүйл.Малчны оролцоотой байгалийн нөөцийн сэргэх чадавхыг бэхжүүлэх

14.1.Бэлчээрийн төлөв байдал, чанарын өөрчлөлтийн явцыг хянах, өөрчлөлтийг цаг тухайд нь илрүүлэх, үнэлэлт, дүгнэлт өгөх үйл ажиллагаа нь газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бэлчээрийн төлөв байдал, чанарын үнэлгээнд суурилна.

14.2.Бэлчээрийн төлөв байдал, чанарын үнэлгээ, үр дүнгийн мэдээлэл, зураглалыг ашиглан холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан, малчны өөрөө удирдах байгууллага, хот айл дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

14.2.1.бэлчээрийн төлөв байдалд үнэлгээ өгөх, сум, аймгийн бэлчээр ашиглалтын журмыг боловсруулж, батлах, мөрдүүлэх;

14.2.2.малчдын оролцоотойгоор бэлчээрт чанарын үнэлгээ хийж, мэдээллийн сан бүрдүүлэх;

14.2.3.малчдын саналд суурилан бэлчээрийн ашиглалтыг тохируулах, доройтлоос сэргийлэх бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах, мөрдөх;

14.2.4.байгаль, цаг уурын нөхцөл, бэлчээрийн даацад малын үүлдэр угсаа, сүргийн бүтцийн зохистой харьцааг тохируулах, малын тоог зохицуулах;

14.2.5.хуульд заасан бусад арга хэмжээ.

14.3.Малчдын болон багийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батална.

14.4.Бэлчээрийн даац, хангамжийн түвшнийг тогтоох аргачлал, бэлчээрийн мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

14.5.Доройтсон бэлчээрийн нөхөн сэргэх чадавхын ангилал тооцох аргачлалыг хөдөө аж ахуйн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

15 дугаар зүйл.Уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн нөлөөллийг бууруулах

15.1.Аймаг, сум бүр уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэйгээр малчид, малчин өрхийн амьжиргаанд нөлөөлөх хүчин зүйлс, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлж, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

15.2.Малчин нь эдэлбэр газар, байгалийн нөөцийг ашиглан хувийн өмчийн мал сүргийг адгуулан маллах замаар үйлдвэрлэл явуулахдаа экологийн тогтвортой байдлыг алдагдуулахгүй байх үүрэгтэй.

15.3.Малчин нь учирч болзошгүй гэнэтийн аюул, эрсдэлээс хамгаалж, үйл ажиллагааны борлуулалтын орлогоос хуримтлал үүсгэж, дундын эрсдэлийн сантай байж болно.

15.4.Эрсдэлийн санд хуримтлал үүсгэх, зарцуулах, хяналт тавих журмыг харилцан тохиролцож, албан ёсоор баталгаажуулсан байна.

15.5.Уур амьсгалын өөрчлөлтийн хүндрэлийг даван туулахад чиглэгдсэн мэдлэг, мэдээллийг малчдад олгох, үр нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээг олон талт оролцоогоор хэрэгжүүлнэ.

15.6.Малын бэлчээрийн газарт авто зам гаргах, бэлчээрийн хөрсийг эвдэх, бохирдуулах, бэлчээрийн эрүүл ахуйг алдагдуулах, цөл, цөлөрхөг хээрийн бүсийн болон хөрсний эвдрэл, цөлжилт үүсэх нөхцөл бүрдсэн бэлчээрт ургамал түүх, хадахыг хориглоно.

16 дугаар зүйл.Малчинд үзүүлэх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ

16.1.Санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан банк, үйлдвэр, малчны хамтын ажиллагаа, уялдааг сайжруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, малчны орон нутагтаа ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулна.

16.2.Арилжааны банкинд малчинд зориулсан нэн хөнгөлөлттэй, хөнгөлөлттэй зээлийн болон даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний шинэ нэр төрлийг нэмэгдүүлж, малчин үйлдвэрлэлдээ чанарын өөрчлөлт гаргах, байгальд ээлтэй, тогтвортой үйл ажиллагаа эрхлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

16.3.Энэ хуулийн 16.2-д заасан зээлийг дор дурдсан шаардлагыг хангасан малчинд олгоно.

16.3.1.малын тоо толгойн албан татвар төлөгч байх;

16.3.2.арилжааны банкинд малчин данстай байх;

16.3.3.эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл төлдөг байх;

16.3.4.малын эрүүл мэнд, үржил технологийн ажлыг мэргэжлийн байгууллагаар технологийн цаг хугацаанд хийлгэн баталгаажуулсан байх.

16.4.Малчны нэн хөнгөлөлттэй зээлийн олгохдоо улс орны нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, тухайн жилийн байгаль, цаг уурын болон гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөлөл, түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт хэрэгцээ зэргийг харгалзана.

16.5.Малчны дараах үйл ажиллагаанд нэн хөнгөлөлттэй зээл олгоно:

16.5.1.байгаль цаг уурын нөхцөлийг хангахуйц өвөлжөө, хаваржааны хашаа, саравч, хороо, байр барих;

16.5.2.доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, малын тэжээл тариалах;

16.5.3.хөдөлмөр хөнгөвчлөх дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;

16.5.4.хадлан, тэжээлийн техник, тоног төхөөрөмж худалдан авах;

16.5.5.эрсдэлийн үед цас цэвэрлэх, бэлчээр гаргах техник болон сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжтэй болох;

16.5.6.цас борооны ус тогтоож хөв, цөөрөм байгуулах;

16.5.7.тухайн бүс нутгийн малын үржлийн хөтөлбөрт заагдсан сайн чанарын үржлийн хээлтүүлэгч, хээлтэгч мал худалдан авах;

16.5.8.малчны ахуй амьдрал болон мал аж ахуйд шаардлагатай эд эдлэл, тоног хэрэгслүүд бэлтгэх, түүхий эдийн анхан шатны ангилалт, тордолт хийх, бэлтгэн нийлүүлэх үйл ажиллагаа явуулах;

16.5.9.түүхий эд бүтээгдэхүүнээ хадгалах эрүүл ахуйн шаардлага хангасан байр барих, түүхий эд, бүтээгдэхүүний чанарын үнэлгээ хийлгэх;

16.5.10.бусад.

16.6.Малчны дараах үйл ажиллагаанд хөнгөлөлттэй зээл олгоно:

16.6.1.шинээр гэр, орон байр болон зөөврийн сууц барих, засварлах, шинэчлэх;

16.6.2.зөөврийн хашаа, өвс тэжээлийн агуулах, хүлэмж шинээр барих, засварлах;

16.6.3.гүн өрөмдлөгийн болон гар худаг гаргах;

16.6.4.малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд анхан шатны боловсруулалт хийх болон хөргөх тоног төхөөрөмж, хөргүүр зоорьтой болох;

16.6.5.малын сүү сааль, дайвар бүтээгдэхүүний ашиглалтыг нэмэгдүүлэх.

16.7.Малчны нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хүүг бууруулах арга хэмжээг Засгийн газар авна.

17 дугаар зүйл.Малчны хөрөнгө оруулалт, эдийн засгийн чадамжийг сайжруулах

17.1.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжихэд зориулан сум бүрд Малчны хөгжлийн санг байгуулна.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

17.2.1.малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтэд төрөөс олгож байгаа мөнгөн урамшууллын нэг удаагийн орлогын хуваарилалт;

17.2.2.уул уурхайн салбарын орлогоос баялаг бүтээх салбарт хуваарилах хөрөнгөөс ногдох хувийн эх үүсвэр;

17.2.3.малчны малын тоо толгойн албан татварын орлогын төвлөрүүлэлтээс хуваарилах хөрөнгө;

17.2.4.малчны, малчны бүлгийн хувь нийлүүлэх хөрөнгө;

17.2.5.малчны өөрөө удирдах байгууллагаас хувь нийлүүлэх хөрөнгө;

17.2.6.малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах үндэсний үйлдвэрийн хувь нийлүүлэх хөрөнгө;

17.2.7.олон улсын байгууллагын санхүүгийн буцалтгүй зээл, дэмжлэгийн эх үүсвэр;

17.2.8.хуулиар хориглоогүй бусад санхүүжилтийн дэмжлэгийн эх үүсвэр.

17.3.Энэ хуулийн 17.1-д заасан сангийн хөрөнгийн 30 хувийг бэлчээрийн мал ахуйд гэнэтийн гамшиг, эрсдэлийн үед ашиглахаар хуримтлуулна.

17.4.Сангийн бусад төвлөрүүлсэн хөрөнгийг жил бүр дор дурдсанаар хуваарилж, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчны хөгжилд дэмжлэг үзүүлэхэд зарцуулна:

17.4.1.тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд 30 хувь;

17.4.2.ногоон, тогтвортой үйлдвэрлэлийг дэмжихэд 30 хувь;

17.4.3.малчдыг хөгжүүлэх, чадавхжуулахад 10 хувь.

17.5.Энэ хуулийн 17.4.1, 17.4.2-д заасан зориулалтаар зарцуулах хөрөнгө нь бага хүүтэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл хэлбэртэй байна.

17.6.Малчны хөгжлийн сангийн удирдлага, зохион байгуулалтын жишиг дүрэм, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмыг сангийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

17.7.Малчин өрхийг тогтмол орлого, хуримтлалтай болгох зорилгоор малчин, хоршоо, малчны холбоо үндэсний үйлдвэрүүдтэй 3 жилийн бүтэгдэхүүн нийлүүлэлтийн тогтвортой гэрээ байгуулж, стандартын шаардлагын дагуу бэлтгэсэн түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлийн дээд ханшаар бэлтгэн нийлүүлэх тогтолцоог хөгжүүлнэ.

17.8.Энэ хуулийн 17.7-д заасан тогтолцоог төр, хувийн хэвшил, малчны өөрөө удирдах байгууллагын хамтын гэрээ, үйл ажиллагаагаар хөгжүүлнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

18 дугаар зүйл.Санхүүжилт

18.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

18.1.1.улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

- 18.1.2.малын тоо толгойн албан татварын орлогыг төвлөрүүлэх сан;
- 18.1.3.орон нутгийг хөгжүүлэх сан;
- 18.1.4.сумын хоршооны сан;
- 18.1.5.олон улсын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалт, зээл, хандив, тусламж;
- 18.1.6.арилжааны банкны эх үүсвэр;
- 18.1.7.малчид, мал бүхий этгээдийн хөрөнгө оруулалт;
- 18.1.8.гадаад, дотоодын байгууллагын хөрөнгө оруулалт;
- 18.1.9.хуульд заасан бусад эх үүсвэр.

19 дүгээр зүйл.Хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

19.1.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

18.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын баталсан журмын дагуу хийж, тайланг Засгийн газарт хүргүүлнэ.

19.3.Энэ хуулийн 19.1-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд шаардлагатай мэдээллийг цуглуулах, судалгаа, шинжилгээ хийх, малчны болон бусад хамаарал бүхий оролцогчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах, санал зөвлөмжийг авах ажлыг аймаг, сумын хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох бүтцийн нэгж хариуцан гүйцэтгэнэ.

19.4.Хэрэгжилтийн тайланд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлж болох ба шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

20 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

20.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

20.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

21 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

21.1.Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малын генетик нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7, 8.8 дахь хэсгийг дор дурдсанаар тус тус өөрчилсүгэй:

1/8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг:

“8.7. “тэмдэг” гэсний дараа “, малчинд мэргэжлийн үнэмлэх” гэснийг хассугай.”

2/8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсэг:

“8.8.“тэмдэг” гэсний дараа “, мэргэжлийн үнэмлэх” гэснийг хассугай.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Малчны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... сарын ...-ны өдөр
хот

Улаанбаатар

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт "24.1.6.Малчны тухай хуульд заасан бол." гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5 дахь заалтын "." гэснийг ";" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Малчны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн Арван гуравдугаар бүлэгт доор дурсан агуулгатай зүйл нэмсүгэй:

“13.10 дугаар зүйл.Малчны тухай хууль зөрчих

1.Малчны тухай хуулиар тогтоосон журам зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Малчны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.44 дэх дэд заалтын "13.9 дүгээр" гэснийг "13.9, 13.10 дугаар" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Малчны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

“МАЛЧНЫ ТУХАЙ” ХУУЛИЙН ТАНДАЛТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УДИРТГАЛ

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН НЬ

1.1. Асуудлыг болон асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон нь

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, бусад этгээдийг тодорхойлсон нь

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг тодорхойлсон нь

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛСОН НЬ

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ЭЕРЭГ БА СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН НЬ

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛСАН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН НЬ

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛЖ, ДҮГНЭЛТ ХИЙСЭН НЬ

ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫГ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН НЬ

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХАВСРАЛТ

“МАЛЧНЫ ТУХАЙ” ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Нэг.Ерөнхий зүйл.

Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай¹ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “хууль санаачлагч нь хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эсхүл энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх” ажлыг зохион байгуулахаар заасан.

Иймд Малчны тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1.2-д заасан аргачлал² -ын дагуу тодорхойлох”, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасны дагуу “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцэх эсэхийг судлах, тухайн асуудлыг хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай эсэхийг тодорхойлох, тухайн асуудлыг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг тодорхойлох, зохицуулах эрх зүйн хэм хэмжээний зерэг болон сөрөг талыг харьцуулан судлах, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр тухайн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг тодорхойлох, шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар бусад улсын эрх зүйн зохицуулалтын талаарх судалгаа хийх асуудлыг судалж, зөвлөмж гаргах” гэсэн заалтуудыг тус тус удирдлага болгон гүйцэтгэлээ.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал³-ын (цаашид “Аргачлал” гэх) дагуу энэхүү судалгааг дор дурдах 7 үе шаттайгаар гүйцэтгэж, тайланг боловсруулав. Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
6. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
7. Зөвлөмж боловсруулах.

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2015, №25

² Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал

³ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлын зорилго нь тодорхой асуудлыг шийдвэрлэх, зохицуулалтын хувилбарыг тодорхойлж, эерэг болон сөрөг талыг харьцуулан судалсны үндсэн дээр үр нөлөөг урьдчилан тооцож, уг асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг хууль санаачлагчид уламжлахад оршиж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн⁴ Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн нь ...эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, ...хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах, ... хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх, ...эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, ...сурч боловсрох, ...улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох эрхтэй бөгөөд ...гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан. Үндсэн хуульд заасан дээрх иргэн хүний үндсэн эрхийн хэрэгжилтийн баталгааг хангах нь өнөөгийн нийгэмд улам чухал болж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн⁵ 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт “...монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, ...экологийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал” хамаарна гэжээ.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын⁶ 3.2.1.2-д “хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн салбарыг ...хөгжүүлэх” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлого⁷-ын зорилт 1.2-д “үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно.” гэж, зорилт 2.1-д “хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, ... насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.” гэж, 2.3.1-д “...гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.” гэж, зорилт 2.5-д “амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат хүнсээр хангана” гэж, зорилт 2.6.3-д “хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ” гэж, зорилт 8.3.-д хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ” гэж, хүрэх үр дүнгийн 8.3.1-д “хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ногоон эдийн засгийн зарчмыг баримтлан уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах

⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992, №01

⁵ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207333&showType=1>

⁷ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2020, №25

чадавхыг бэхжүүлж, даатгал, бүртгэл, мэдээлэлд суурилсан ухаалаг системийг хөгжүүлнэ”, 8.3.2-т “нүүдлийн уламжлалт өв соёлыг хадгалсан, экологид ээлтэй, органик мал аж ахуйг тогтвортой эрхлэх, хөдөө аж ахуйн эрчимжсэн үйлдвэрлэлийг төрөлжүүлж, кластер, логистик, санхүүгийн түрээсийн үйлчилгээг хөгжүүлж, төлөвшүүлнэ”, 8.3.3-д “хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн тогтвор суурьшилтай ажиллаж, ая тухтай амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулна”, 8.3.7-д “хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээл, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлж, эдийн засгийн чадамж, үр өгөөжийг сайжруулна”, 8.3.8-д “хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээс хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулж, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангана” гэж тус тус заажээ.

УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр⁸-ийн зорилт 4.4-д “эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг ханган, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.” гэж заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”⁹-ийн зорилт 1.2-д “нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ” гэж, 2.3.1-д “...гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ” гэж, зорилт 3.6-д “Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ” гэж, 3.6.2-д “хаягжилтын нэгдсэн системийг Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулна.” гэж, зорилт 5.5.2-д “төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллах тогтолцоо төлөвшүүлнэ” гэж, зорилт 8.3-д “хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ” гэж гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”¹⁰ -ийн 3.1.14-д “эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн бодлого, хууль, эрх зүйн орчныг тодорхой болгоно” гэж, 6.2-д “бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэж, 6.2.14-д “хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн ...бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно” гэж тус тус заажээ.

Иймд энэхүү судалгаагаар төрийн бодлого, үйл ажиллагааны зорилт, хүлээж байгаа үр дүн, улс орны нийгэм, эдийн засгийн өнөөгийн төлөв байдлын хүрээнд малчны гүйцэтгэж байгаа үүрэг, тэдгээртэй холбоотой тулгамдсан асуудлууд, тэдгээрийн мөн чанар, цар хүрээг тогтоож, асуудал үүсгэж байгаа шалтгаан,

⁸ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2022, №09

⁹ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2020, №36

¹⁰ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2020, №38

нөхцөлийг тодорхойлж, эрх зүйн хүрээнд нарийвчилсан зохицуулалт хийх шаардлага байгаа эсэх асуудалд дүн шинжилгээ хийхийг зорьсон болно.

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН НЬ

1.1. Асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоосон нь:

Энэхүү урьдчилан тандан судлах судалгааг гүйцэтгэхдээ Аргачлалын 3 дахь хэсэгт заасны дагуу асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд, тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох ажлыг гүйцэтгэв.

Манай улс төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоог халж, ардчилсан тогтолцоог нутагшуулснаас хойших өнгөрсөн 32 жилийн хугацаанд зах зээлийн шилжилтийн замыг туулахдаа уул уурхай, барилга, худалдаа, үйлчилгээний салбарт тодорхой ахиц дэвшилд хүрч, хөгжлийн тодорхой хэдэн үзүүлэлтээр дэлхийн дундаж түвшний хөгжилтэй орнуудын тоонд багтсан. Гэвч засаглал тогтворгүй, эдийн засгийн төрөлжилт, үйлдвэржилт, дэд бүтцийн хөгжил сул, тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт, түүнийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, хариуцлага тооцох механизм дутагдалтай, хүний нөөцийн нэгдсэн бодлого алдагдсан зэргээс улбаалан сөрөг олон үр дагаврууд бий болсон ба эдийн засгийн тэргүүлэх салбарууд бэхжээгүй, хөгжил нь эмзэг хэвээр байна. Тухайлбал, уул уурхайн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл савлагаа ихтэй, ХАА-н салбарын өсөлт байгаль цаг уурын нөлөөллөөс хэт хамааралтай байна. Улс орны нийгэм, эдийн засагт тулгамдаж буй асуудлуудын нэгээхэн хэсэг нь стратегийн ач холбогдол бүхий салбаруудыг тогтвортой хөгжүүлэх асуудал юм. Стратегийн ач холбогдол бүхий тэргүүлэх салбаруудын эдийн засгийн өсөлтийг авч үзэхэд сүүлийн 10 жилийн хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) үйлдвэрлэлд тэдгээрийн эзлэх хувь нийт дүнгээр өсөөгүй байна.¹¹ Түүнчлэн экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах, хотын төвлөрлийг сааруулах, хөдөөг хөгжүүлэх, орон нутгийн эдийн засгийг зонхилон бүрдүүлж байгаа мал аж ахуйн үйлдвэрлэл болон байгаль орчин, боловсрол, эрүүл мэндийн салбарт тулгарч байгаа бэрхшээлүүдийг багасгах, хөдөөд ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх, иргэд эрүүл, аюулгүй орчинд орлоготой, ая тухтай ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, сайжруулах зэрэг асуудлууд нэн чухал байна.

Энэхүү тандан судалгаагаар улс орны иргэдийн хүнсний хангамж, эдийн засагт голлох хувь нэмрээ шууд оруулдаг, хүн амын болон ажиллах хүчний томоохон давхарга болох малчин өрх, малчдын үйл ажиллагаатай холбоотойгоор практик дээр тулгарч буй бэрхшээлт асуудлуудыг судалж, тодорхойлох, тухайн асуудлуудын мөн чанар, цар хүрээг тогтоох, асуудал үүсгэж буй шалтгаан, нөхцөл, нөлөөллийн хүчин зүйлсийг тодорхойлох, тэдгээрээс гарах гарц, шийдлийн саналыг харьцуулалт ба дүн шинжилгээ, үнэлгээнд суурилан тогтоохыг зорьсон.

¹¹ Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, Үндэсний Статистикийн Хорооны танилцуулга, 2020 он

Иймд дүн шинжилгээ хийж асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх гэж байгаа асуудлын мөн чанарыг тогтоохын тулд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага(ХХААХҮЯ) болон Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны мэдээллийн сангаас статистик мэдээ, мэдээлэл цуглуулах, холбогдох бүтцийн нэгжийн удирдлага, мэргэжилтнүүдтэй уулзаж асуудлыг тодруулах, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид, малчидтай холбоотойгоор өмнө нь хийгдсэн төрөл бүрийн судалгааны материалуудыг цуглуулах, судлах, орон нутгийн удирдлага, мал аж ахуйн салбарын мэргэжилтнүүд, малчид, мал бүхий иргэдтэй ярилцах, тэдгээрийн дунд өмнө нь зохион байгуулсан хурал, зөвлөгөөний дүгнэлт, зөвлөмж, уриалга, санал асуулга явуулсан талаарх материалыг цуглуулж, судлах, зарим нэмэлт судалгааг авах зэргээр ажилласан. Түүнчлэн тулгамдаж байгаа асуудлын цар хүрээг тогтоохын тулд хамрах хүн ам, нийгмийн бүлэг, салбар, нутаг дэвсгэр зэргийг тодорхойлж, шаардлагатай мэдээллийг цуглуулсан ба мэдээллийг цуглуулах явцад сүүлийн жилүүдэд өссөн, буурсан зэрэг өөрчлөлт, хөдөлгөөний мэдээллийг цогцоор нь бүрдүүлэхэд анхаарсан болно.

Монгол малчид нь мал аж ахуйг 10,0 мянга гаруй жилийн туршид үе дамжуулан эрхэлж, хүн төрөлхтний нүүдлийн соёл иргэншил, өв соёлыг тээгчид гэж дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, улс орныхоо хязгаар нутаг, хилийг хамгаалах, монгол ухаан, эх хэл, өв соёлыг хадгалах үндсэн цөм болж байна. Үндэсний хэмжээнд 94,0 хувь нь уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг, 3,2 хувь хосолсон аж ахуйг, 2,7 хувь суурин аж ахуйг тус тус эрхэлж байгаа бол хөдөөд уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг 99,3 хувь нь, 0,7 хувь нь хосолсон мал аж ахуйг, нийслэл орчимд 30,0 хувь нь бэлчээрийн, 28,0 хувь хосолсон аж ахуйг, 42,0 хувь суурин аж ахуйг тус тус эрхэлж байна.

Манай улсын малтай өрхийн тоо 2022 онд 248,3 мянга болж өсжээ. Жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрхийн тоо 190.8 мянга буюу малтай өрхийн 76.8 хувийг эзэлж байгаа бол малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй өрх 23.1 хувийг бүрдүүлж байна. Малчин өрхийн тоо 2022 онд өмнөх оноос 2.2 мянга буюу 1.2 хувиар өссөн байна.


Хүснэгт 1.Малчин өрх ба малчны тоо¹²

	2010 он	2015 он	2020 он	2021 он	2022 он
Малтай өрхийн тоо	216,570	216,734	242,024	246,302	248,296
Малчин өрхийн тоо	160,265	153,085	181,051	188,605	190,776
Малчны тоо	327,154	297,828	298,789	305,430	305,079

¹² ҮСХ мэдээ, 2022 он

2022 оны байдлаар нийт малчдын дунд 15-44 хүртэлх насны малчид 26.9 хувь, 35-44 хүртэлх насны малчид 58.5 хувь, 55-аас дээш насны малчид 14.6 хувийг тус тус эзэлж байна. Сүүлийн 3 жилд 15-34 насны залуу малчдын тоо 2.9 нэгж хувиар буюу 7.0 мянгаар багсаж, 35-59 насны малчдын эзлэх жин 1.7 нэгж хувиар буюу 8.8 мянгаар нэмэгдсэн байна.

Зураг 1. Малчдын насны бүтцийн өөрчлөлт, хувиар¹³



15-34 насны малчид 2010 онд нийт малчдын 43.5 хувийг эзэлж байсан бол 2022 онд 26.9 хувь болж 16.6 пунктээр буурч, 35-55 насны малчид мөн хугацаанд 15 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Залуу малчдын тоо жилээс жилд буурч байгаа нь малчдын залгамж халаа алдагдах, дунд болон ахмад малчдын тоо өсөх хандлагатай, хөдөлмөрийн насны малчдын дунд насжилтын өөрчлөлт нэлээд явагдаж байгааг зайлшгүй анхааралд авах, бодлогын хариу арга хэмжээ авах шаардлагатай байна.

Малчдын үйл ажиллагааны хүрээнд тулгарч байгаа бэрхшээл, хүндрэл, нөхцөл байдал, шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг судалгааны явцад бүлэглэн авч үзэхэд дор дурдах асуудлууд байна. Үүнд:

1. Малчдын аж ахуй эрхлэх арга барил, хандлагад өөрчлөлт орсон.

Хэдийгээр манай улсын мал аж ахуйн салбар олон мянган жилийн нүүдлийн соёл иргэншлийн бахдам түүхтэй ч сүүлийн 30 жилд малчдын үзэл баримтлалын чиг хандлага эрс өөрчлөгдөж байна. Жилийн 4 улиралд сэлгээн нүүдэлдэг, малаа сүргээ оторлон бэлчээрлүүлж, тарга тэвээрэг авхуулдаг морио номхотгон унаж ахуйдаа ашигладаг, малаа хариулдаг зэрэг нүүдлийн ахуй өв соёл, иргэншлийн олон мянган жилийн уламжлал, соёл сарнин алдагдаж байна.

2. Малчдад үйлдвэрлэл явуулах эрх хязгаарлагдмал, бэлчээрийг нийтээр дундаа ашиглах эрх зүйн зохицуулалтын үлмээс бэлчээрийн газрын доройтол, цөлжилтөд хариуцлага хүлээх эзэнгүй болсон ба малын тэжээл өвс бэлтгэх боломж, хүрэлцээ мүүдсаар байна. Малчид малаа оторлуулан бэлчээх, жилийн 4 улиралд сэлгэн нүүдэллэх, малаа идээшлүүлэн бэлчээх, хадлан өвсөө бэлтгэх газрын хүрэлцээ хомс, үүнээс үүдэлтэй маргаан, улмаар амь насаа алдах тохиолдол нийгэмд үүсээд удаж байна.

¹³ ҮСХ мэдээ, 2022 он

Уур амьсгалын өөрчлөлтийн хүчин зүйлс, хүний буруутай үйл ажиллагаа, хавсарсан нөлөөллөөр сүүлийн 10 жилд бэлчээрийн эдэлбэр газрын хэмжээ 2.1 сая га-гаар буурч, малын тоо 2.2 дахин өсөж, 100 га бэлчээрийн талбайд ногдох малын тооны ачаалал нэмэгдэж, бэлчээрийн ургац жил тутамд 0.01-0.12 ц/га-аар буурч байна. 100 га бэлчээр, хадлангийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 1961 онд 32, 2010 онд 48 байсан бол 2022 онд 114 болж, бэлчээрт үзүүлэх ачаалал нь 3.6 дахин, сүүлийн 3 жилд буюу 2020 оноос 10.7 хувиар нэмэгдээд байна.¹⁴ Бүс нутаг тус бүрд ашиглалтын горим, ачааллыг нь нэн яаралтай өөрчилж, сайжруулах шаардлагатай 29.4 сая га бэлчээрийн газар байна гэж дүгнэжээ.¹⁵ Бэлчээрийн ургац буурч байгаа нь малын үндсэн шим тэжээлийн нөөцийг хомсдуулж, улмаар бэлчээр бараадсан отор нүүдлийн маргаан орон нутагт улам бүр ихсэх болсон ба малчин өрхийн гишүүд тус тусдаа өөр өөр сумын харьяат болох замаар малаа бэлчээх эрх авч, гэр бүл зохиомлоор салах үндэс болж байгаа нь эрх зүйн хүрээнд шинэчлэл хийх шаардлага байгааг харуулж байна. Мөн цаашид бэлчээрийн ургамалжилт өөрчлөгдөж, даац улам бүр буурах хандлагатай байгаа тул малчид жил бүр малын тэжээлээ бэлтгэх нөхцөлийг бүрдүүлэх, тэжээл үйлдвэрлэгч, борлуулагчдаас малчид малын тэжээл худалдан авах чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санхүүгийн хөнгөлөлттэй зээл, хүүгийн дэмжлэгийн зохицуулалт шаардлагатай байна.

3. Малчин өрхийн гэр бүлийн болон хүйсийн харьцааны бүтцэд эрсдэл үүссэн. 2022 оны байдлаар 15-24 насны малчдын 67.7 хувийг эрэгтэй, 32.3 хувийг эмэгтэй малчид эзэлж байна.¹⁶ Энэ нь залуу малчдын хүйсийн харьцаанд ихээхэн зөрүү үүсч эхэлсэн болохыг харуулж байна. Энэ нь малчин залуучуудын дундах гэрлэлт буурах, оройтох, төрөлт буурах, бэлгийн зүй бус харилцаа олшрох, гэрлэлт дагасан шилжилт хөдөлгөөн эрчимжих, цаашлаад малчдын залгамж чанарт сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг дагуулж байна. Иймд хүн ам зүй, эдийн засаг үйлдвэрлэл, соёлын хүчин зүйлд үндэслэн малчдын хүйсийн харьцааг тэнцвэржүүлэхэд төрийн бодлого чиглэгдэх шаардлагатай болжээ. Түүнчлэн 6 настай хүүхдийг сургуульд оруулах тогтолцоотой холбоотойгоор хүүхдээ дагаж эмэгтэйчүүд нь гол төлөв сум, аймгийн төвд удаан хугацаагаар амьдрах болсон ба гэртээ малаа маллаж үлдсэн эрэгтэй нь хоол унд муутай ажилласаар эрүүл мэндээр хохирох, аажимдаа гэр бүлийн маргаан, салалтыг ихэсгэх үр дагаврыг бий болгож байна.

4. Малчдыг мэдлэгжүүлэх, хөгжүүлэх асуудал нь зөвхөн олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслийн үүрэг болж хувирсан. Сүүлийн 20-иод жилд төсөв санхүү хүрэлцээгүй гэсэн үндэслэлээр малчдыг сургах, зөвлөгөөн, хурал хийх арга хэмжээ зөвхөн гадаад төслийн санхүүжилтийн хүрээнд зохион байгуулагдах ажил болжээ. Иймд төрийн бодлогыг орон нутагт, иргэдэд үнэн зөв хүргэх, малчдыг мэдээ мэдээллээр шуурхай, тасралтгүй хангахад шийдлийн оновчтой гарц, эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна. Ялангуяа Төсвийн хуульд заасан малын тоо толгойн албан татварын орлогын төвлөрүүлэлтээс малчдыг сургах, мэдээллээр хангахад зардал орон нутагт ангиллынхаа дагуу огт тавигдахгүй байна. Татвар төлөгч малчин өөрөө зарцуулсан мөнгөө хянах

¹⁴ ҮСХ мэдээ, 2022 он

¹⁵ Бэлчээрийн газрын төлөв байдлын фото мониторингийн судалгаа, 2022 он

¹⁶ ҮСХ мэдээ, 2022 он

чадвартай болохын тулд малчдыг хөгжүүлэх асуудал чухал байна. Наад зах нь, малчдад орчин үеийн технологийн хөгжил, байгалийн гамшигт эрсдэлээс хэрхэн хамгаалах вэ гэдэгт мэдлэгийг нь нэмэгдүүлэх шаардлагатай. Жишээ нь, татвар төлөгч болсон малчин татварын тайлангаа цахим, И-Монголиа аппликейшнээр авах мэдлэгтэй болгох шаардлагатай. Бид мал аж ахуйгаа хөгжүүлэе, бэлчээрээ сайжруулъя, мал махны чанараа сайжруулах тухай мянган зорилт дэвшүүлээд үр дүн багатай. Хувь хүний хөгжил, мэдлэгийн цар хүрээг хөгжүүлэхгүйгээр дээрх зорилтууд цаг хугацаа алдсан асуудал болно. Иймд малын тоо, толгойн албан татварын бүрдүүлэлтээс Төсвийн тухай хуулиар эрх олгосон хүрээнд нь малчныг сургаж сурталчлах, зардалд зарцуулахыг орон нутгийнханд санал болгон дэвшүүлж байгаа. Тиймээс биш малчин хүн хэзээ ч өөрийнхөө саналаар “өөрийгөө хөгжүүлэе, надад зориулж татварын мөнгөнөөс зарцуул” гэж хэлэхгүй.¹⁷ Тэгэхээр Төсвийн тухай хуулиараа тодорхой хувийг малчны хөгжилд зарцуулах талаар хувь зааж хуульчлах хэрэгцээ байна.

5. Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл манай улсын мал аж ахуйн үйлдвэрлэлд хүчтэй илрэл үзүүлж, түүнийг дагаад хохирол нь улам бүр нэмэгдэх болсон. Манай оронд сүүлийн 70 жилийн хугацаанд 13 удаагийн томоохон зуд тохиож, одоо байгаа бүх малын 62.7 хувьтай тэнцэхүйц хэмжээний мал хорогдож, мал аж ахуйн салбарт үлэмж хохирол учруулсан юм. Сүүлийн 30 жилийн зудын хохирлыг мөнгөн дүнгээр илэрхийлэхэд 860.0 орчим тэрбум төгрөг болжээ. Ялангуяа 2009-2010 оны зудад 76900 малчин өрх өртөж, 527.0 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Ургамалжилтын бүх бүс бүслүүрт тохиолдох зудын индекс өссөн ба Хангай, Хэнтий, Хан хөхий, Хөвсгөлийн уулс, Дорнодын талд цагаан зуд 10 жилд 1-2 удаа, Тэсийн голын хөндийд 2 жилд 1 удаа, цөлийн хээр, цөлийн бүсэд хар зуд 2 жилд 1 удаа тохиолдож байна. Хэдийгээр монгол малчин өрхүүд хатуу ширүүн орчинд амьдрах уламжлалт аргатай ч улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын хүчин зүйлсийн нөлөөгөөр даван туулах чадавх нь суларч байна. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас “Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд хариу үзүүлэх бэлэн байдлыг нэмэгдүүлэх нь” хамтарсан хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгааны¹⁸ дүгнэлтээр манай улсын малчин өрхийн гамшгийн эрсдэл даах чадавхын дундаж түвшин 40.45 индекс оноотой байна. Эрсдэл даах чадвар муу өрхүүд хөрөнгө, боломж хязгаарлагдмал тул өвлийн бэлтгэлээ сайн базаах чадамжгүй, нэг удаагийн байгалийн цочир үзэгдэлд малаа алдаж, ядуурлын доод шугам руу буух эрсдэлтэй байна. Судалгаанд хамрагдсан 21 аймгийн 330 сумын 10,023 малчин өрхийн амьжиргаанд сүүлийн 12 сарын хугацаанд хамгийн их нөлөөлсөн цочрол нь Ковид-19 цар тахал (75.6 хувь), дараа нь ган/зуд (48 хувь), энэ хоёр цочролоос үүдэлтэй мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, өвс тэжээлийн үнийн хэлбэлзэл (37.2 хувь) байжээ.

6. Малаас авах бүтээмж багасаж, малын чанар улам бүр муудах болсон нь малчид малын тоогоо өсгөхөд хүргэж байна. Мал сүргээс авах ашиг шим, бүтээмж нь мал аж ахуйн салбарын түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, үр ашгийг тодорхойлох, ирээдүйд бий болгох үнэ цэнийг тогтооход чухал үзүүлэлт болдог. Малчдын мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх уламжлалт хандлага нь

¹⁷ <https://news.mn/r/2549270/>, 2022 он

¹⁸ Малчин өрхийн гамшгийн эрсдэл даах чадварын судалгаа

"өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл" явуулах буюу малын тоог өсгөхөд чиглэгдэж, малын чанар эдийн засгийн эргэлт, үр өгөөж, нэг малаас авах ашиг шимийг өсгөхөд төдийлөн анхаарал хандуулахгүй байна. 1993 оноос ямааны ноолуур үнэд орж эхэлсэнтэй холбоотойгоор сүүлийн 25 жилд малчид ямаагаа хониноос давамгайлан өсгөсөн нь аажмаар малын бэлчээр ашиглалтын болон мал сүргийн төрлийн уламжлалт, зохист харьцааг алдагдуулахад хүргэв. Сүрэгт бог малын эзлэх жин дээрх хугацаанд 8.6 нэгж хувиар өсжээ. Иймээс малчдын одоогийн орлогыг бууруулахгүйгээр малын тоо, төрлийн бүтцийг бэлчээр, тэжээлийн нөөц, чадамжид тохируулах, эдийн засгийн эргэлтэд оруулах менежментийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага бий болсон байна. ХХАА-н яамнаас баталсан норм, нормативаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад бод малд хээлтэгч 50.0-55.0 хувь, бог малд 60.0-65.0 хувийг эзэлж, нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм азаргад 12-15, бухад 35-45, буурт 20-25, хуц, ухнад 25-30 байх нь зохистой гэж тогтоожээ. Одоогийн төлөвөөр хээлтүүлэгчид үүссэн ачаалал адуу болон үхэр сүрэгт хэвийн, тэмээн сүрэгт буур тутамд 7 ингэ илүү, богийн сүрэгт 2.6 дахин хэтрэлттэй байна. Малын ашиг шим буурахад бэлчээрийн доройтол, хуурайшилт зэрэг байгалийн хүчин зүйлс нөлөөлөхийн зэрэгцээ зах зээл бараадсан төвлөрөл ихэссэн, малын отор нүүдэл багассан, хамгийн гол нь малын үржил, селекцийн ажлын систем задарч, энэ чиглэлийн хувийн хэвшлийн нэгжид хөрөнгө оруулалт бараг хийгдэхээ больсон зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. Малын үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээнд төрөөс дэмжлэг үзүүлдэггүйн улмаас орон нутагт мэргэжлийн ажил, үйлчилгээ үзүүлэх хүний нөөцгүй болж, үйлчилгээний хүртээмж хангалтгүй байна. Энэ нь малын ашиг шимийг шинжлэх ухааны үндэслэлтэй сайжруулах боломжийг хязгаарлаж, малчид үржлийн ажлыг дур мэдэн явуулах болсонтой холбоотой байна.

7. Малчид үйлдвэрлэсэн түүхий эд, бүтээгдэхүүнээ зах зээлд шууд нийлүүлэх боломж хомс, тэдгээрийн үнэ бага байгаагийн улмаас өрхийн орлогоо нэмэгдүүлж чадахгүй байна. Хэдийгээр Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан хууль, тогтоомж, шийдвэрийн дагуу малчид, мал бүхий этгээдэд ноосны, сүүний, арьс ширний урамшууллыг 2011 оноос хойших хугацаанд төсвөөс олгосоор ирсэн боловч төрөөс олгож буй урамшуулал нь малчин, мал бүхий иргэдэд төдийлөн үр ашиг, орлогыг нэмэгдүүлэхгүй байна гэж салбарын мэргэжилтнүүд, судлаачид дүгнэжээ. Малын гаралтай түүхий эдийг тогтмол хүлээж авах тогтолцоо хөгжихгүй байгаагийн улмаас малчид зөвхөн ченжийн гарыг харсаар ирсэн ба ченжүүд нь Хятад Улсын зах зээлээс хамааралтай үйл ажиллагаатай байна. Иймээс малын гаралтай түүхий эдийн үнэ тогтворгүй байгаа ба тээвэр логистикийн сүлжээ хангалтгүй, шатахууны үнэ өндөр зэргээс үүдэлтэйгээр сүүлийн жилүүдэд нэхий, ямааны арьс болон малын дайвар бүтээгдэхүүнийг хаях болсон ба үйлдвэрүүд гаднаас түүхий эд импортлох үзэгдэл тэлсэн. Тухайлбал, гадаад худалдааны тэнцлийн сүүлийн гурван жилийн дунджаар мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспорт импортоосоо 2.1 дахин бага, 2022 оны импорт өмнөх оноос 17.0 хувиар өссөн үзүүлэлттэй¹⁹ байна.

8. Малчдаас бэлтгэн нийлүүлж буй стратегийн гол нэрийн зарим бүтээгдэхүүн малын гаралтай түүхий эд, бэлтгэлийн тогтолцооны гажуудлаас

¹⁹Гаалийн Ерөнхий газар, 2022 он

үүдэлтэйгээр инфляцын өсөлтөд нөлөөлөл үзүүлж байна. Тухайлбал, махны үнэ улирлын шинж чанартай нийлүүлэлтээс хамааран хавар, зуны улиралд өсөх, намар, өвлийн улиралд буурах хандлагатайгаар хэлбэлзэж, инфляцад үзүүлэх нөлөөлөл нь сүүлийн жилүүдэд тогтмол өсч байна. Малчдаас мал, мах худалдан авсан дундын зуучлагч нар үнэ нэмсээр хэрэглэгчдэд өндөр үнэтэйгээр борлуулагдах болсон. Иймд малчдаас түүхий эдийг хүлээн авах бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог нэгдсэн зохион байгуулалтад оруулах шаардлага их байна. Мал аж ахуйн салбарын жилийн бодит өсөлтийн хэмжээ тогтворгүй байгаа нь байгаль, цаг уурын нөлөөлөлд уламжлалт мал аж ахуй эмзэг байдаг, бэлчээрийн даац, малын тоо толгойн тэнцвэргүй байдал, тэжээлийн нөөцийн хомсдол зэргээс шалтгаалж байна.

9. Малчдын дүнд нэгдмэл үйл ажиллагаа, санаачилга, удирдлага, зохион байгуулалт, манлайлал дутагдаж байна. Сүүлийн 20-иод жилийн туршид малчдын загвар хоршоог бий болгох, хөгжүүлэх зорилгоор олон талт шийдвэр, арга хэмжээг зохион байгуулсан боловч одоог хүртэл тодорхой үр дүнд хүрэхгүй, өрх болгон дор дорноо мал, түүхий эдээ борлуулах гэж цаг хугацаа алдаж, зардал гаргасан хэвээр байгаа нь малчдын санаачилга, үйл ажиллагаа, удирдлагыг нэгдмэл зохион байгуулалтад оруулах эрх зүйн хүрээний шинэ гарц хэрэгтэй байгааг практик харуулж байна.

10. Малчдын малын тоо толгойн албан татварыг хэт олон зүйлд зарцуулахаар зохицуулсан нь дорвитой үр дүн авчрахгүй байдалд хүргэж байна. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д “малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна” гэж заасан. Малын тоо толгойн албан татварын хуулийг баталснаар улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж байгаа нь сайн талтай. 2021 оны татвар гэхэд 14.5 тэрбум төгрөг төвлөрүүлжээ. Гэвч төвлөрүүлсэн орлогын зарцуулалт хяналтгүй, бодит арга хэмжээнд зарцуулахгүй байна гэж нийгэмд шүүмжилсээр байна. Тухайлбал, Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр хэрэгжүүлж буй “Хоршоонд суурилсан тогтвортой мал аж ахуйн үйлдвэрлэл” төслийн хүрээнд Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт сэдэвт хэлэлцүүлгийн үед²⁰ малчдаас төвлөрүүлсэн татварын орлогын зарцуулалт, үр ашиг тодорхойгүй, зардлын ангиллууд одоо хүртэл нарийвчилсан зохицуулалтгүй байгаа учраас малчдаас төвлөрүүлсэн татварын зарцуулалт олон нийтийн хяналтаас гадуур байна гэжээ.

Цаашид мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхэлж, эдийн засгийн тулгуур нөөц байлгах, мөн нүүдлийн ахуй уламжлал, өв соёлыг хамгаалахын тулд малчны эрх зүйн үндсийг тодорхой болгох, тэдгээрийн хамтын санаачилга, өрсөлдөх чадвар, бүтээмж, хариуцлагыг сайжруулах, дэмжих хөшүүргийг бий

²⁰ <https://news.mn/r/2549270/>, 2022 он

болгох зэрэг харилцааг эрх зүйн хүрээнд нарийвчлан тогтоох, зохицуулах шаардлага байна.

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, бусад этгээдийг тодорхойлсон нь

Энэхүү хэсэгт тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, бусад этгээдийг Үндэсний статистикийн газрын болон ХХААХҮ-ийн яамны цахим хуудасны мэдээлэл болон нэмэлт бусад мэдээлэл, цахим, нүүр хуудасны мэдээ, хэвлэл, мэдээллийн ярилцлага зэрэгт тус тус үндэслэн тодорхойлсон болно.

Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлэг нь малчин өрх, малчин, туслах малчин байхаар байна. Манай улсад нийт малчин өрхийн 96.5% нь үндсэн малчин, 3.5% хувь нь туслах малчин байна.

Жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж, амьжиргааны эх үүсвэр нь мал сүрэг болж байгаа 188.6 мянган малчин өрхөд 305,1 мянган малчин ажиллаж байна. 2022 онд малчдын тоо 2010 онтой харьцуулахад 6.7 хувиар буурсан бол 2021 онд өмнөх оноос 2.2 хувиар өсч, 2022 онд 0.1 хувиар буурч тоо нь тогтвортой бус байна.

Зураг 2. Малчин өрхийн малын тоо ба бизнесийн орлогын түвшин



Малын тооны бүлгээр нийт малчин өрхөд 201-500 малтай өрх 0.4 хувиар, 501-999 малтай өрх 8.2 хувиар, 1000-2000 малтай өрх 13.3 хувиар, 2001-ээс дээш малтай өрх 15.3 хувиар өссөн бол 50 хүртэлх малтай өрх 1.9 хувиар, 51-200 хүртэлх малтай өрх 2.2 хувиар, тус тус буурсан байна.

Малчин өрхүүдийн 45.9%-ийг 200 хүртэлх малтай буюу бага орлоготой, 31.4%-ийг дундаж, 16.4%-ийг дунджаас дээш орлоготой, 6.6%-ийг 1000-аас дээш малтай буюу бизнесийн орлоготой малчин өрх эзэлж байна.

Малчид нь манай улсын нийт ажиллах хүчний 25,3 хувийг бүрдүүлж, эдийн засаг, нийгмийн салшгүй хэсэг болж байгаагийн хувьд эрх, үүргийг хэрэгжүүлэх олон талт харилцаанд их, бага хэмжээгээр оролцож байна. Иймд нийгмийн харилцааны нэг бүрдэл хэсэг болсон малчин иргэдийн эрх зүйн үндсийг нарийвчлан тогтоох

хэрэгцээ байна. Ялангуяа сүүлийн үед дэлхий нийтээрээ хөгжлийн түвшнийг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэг хандлагаас зайлсхийж, хүний хөгжлийн асуудалд онцгой анхаарал хандуулж байна. Улс үндэстний гол баялаг, хөгжлийн хүч, ирээдүйг тодорхойлогч үнэт зүйл бол хүн өөрөө юм. Хүн төвтэй хөгжил нь хүний хөгжлийн үйл явц, үр дүн байдаг учраас малчныг хөгжүүлэх үндэс нь өөрсдийнх нь оролцоо байхаар байгаа тул малчны өөрөө удирдах байгууллагын тогтолцоог тодорхой болгож өгөх нь эрх зүйн хүрээнд чухал байна. Малчны тухай хуулийн төсөл нь эдийн засаг, нийгэмд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсгэхээргүй байгаа бөгөөд малчин хүнийг эрүүл саруул байх, урт удаан наслах, бүтээлчээр ажиллаж амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх нь манай улсын хөгжлийн гол зорилгын нэг байхаар байна.

Хүснэгт 2. Эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүлэг

№	Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй бүлэг	Тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хэрхэн нөлөөлж байгаа талаар
1	"малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасан буюу "мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг;"	Монгол улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь хэсэгт "өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй" гэж заасан ч малчдын хувьд энэ эрх нь байнга зөрчигдөж байна Нийгэм, эдийн засгийн нөлөөллөөс хамаарч нийгмийн даатгал төлөлт хожимдуулан төлөх боломжгүй болсоны улмаас
2	"туслах малчин"	Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2."Туслах малчин" гэж үндсэн малчны дэргэд амьдарч, түүний удирдлага, хяналтын доор мал маллах, мал аж ахуйтай холбоотой бусад ажил эрхэлж цалин хөлс авахаар харилцан тохиролцон ажиллаж байгаа хүнийг ойлгоно. Бусдын малыг бие даан хөлсөөр маллахтай холбогдсон харилцааг Иргэний хуулиар зохицуулна.

Малчдын эрх зүйн байдлыг тодорхой болгож, холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгосноор монголчуудын олон мянган жилийн түүхт, бусдаас ондооших нүүдлийн ахуй уламжлалт өв соёлыг хадгалах, хамгаалах, энэхүү нийгэм, эдийн засгийн чухал үнэ цэнтэй үйл ажиллагааны тогтвортой байдлыг хадгалж, ирээдүй хойч үед үлдээх боломжийг эрх зүйн хүрээнд баталгаажуулах юм.

1.3.Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон нь:

Манай улсын малчид, мал аж ахуйн үйлдвэрлэлд үүссэн, үүсч болзошгүй сөрөг нөлөөл үзүүлж байгаа асуудлуудын мөн чанар, шалтгааны талаар иргэд, судлаачид өөр өөр үзэл бодлын үүднээс хандсан дүгнэлтүүд хийсэн байна. Үүнд:

- Олон мянган жилийн туршид эрхлэн ирж, нүүдлийн соёл иргэншлийг хүн төрөлхтний өмнө тээж яваа, бусад улс үндэстнээс ялгарах онцлогтой бэлчээрийн мал аж ахуйг эрхэлж байгаа малчдын асуудлыг төр засаг тусгайлсан бодлогоор авч үзэж, нүүдлийн ахуй өв соёлыг хүн төрөлхтөн, монголын ирээдүй хойч үед өвлөн үлдээх нь чухал байна.
- Байгаль, экологи, уур амьсгалд гарч байгаа өөрчлөлтүүд, уул уурхайн болон зам харгуйн замбараагүй ашиглалт, малын тооны эрчимтэй өсөлт зэрэг хүчин зүйлсийн нөлөөллөөр мал сүрэг идээшлэх бэлчээр хэт доройтож, ашигтай ургамлын төрөл, зүйл багасаж, бүрэлдэхүүн нь өөрчлөгдөж байгаа нь малчид бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх боломжийг улам бүр хумьж байна. Бэлчээрийн газрын эрх зүйн харилцааг сайжруулахгүйгээр, малчдын үйлдвэрлэлийг газартай нь нягт уяж өгөхгүйгээр бэлчээрийн мал аж ахуйг тогтвортой эрхлэх боломжгүй юм.
- Малыг гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг чанартай нь уялдуулан тогтмол хүлээн авах тогтолцоог бүрдүүлэхгүйгээр малчны орлого ченжээс буюу Хятадын мөнгөнөөс хамааралтай байсаар байх болно. Төр үүнд дорвитой өөрчлөлт гаргах хэрэгтэй. Мах, сүү зэрэг стратегийн хүнсийг бэлтгэн нийлүүлэх тогтолцоонд малчдын шууд оролцоог бүрдүүлж, тэдгээрт эдийн засгийн сонирхлыг бий болгохгүйгээр махны үнэ инфляцад нөлөөлсөөр байх болно.
- Малчдыг хөгжүүлэхгүйгээр, тэдгээрт ажиллах, амьдрах эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхгүйгээр, зах зээлтэй холбож өгөхгүйгээр мал аж ахуйг хөгжүүлэх олон сайхан бодлого, хөтөлбөр гаргаад, хэрэгжүүлээд үр дүн муутай тул хуулийн зохицуулалт хэрэгтэй. Малчдад мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх арга барил, технологи, техникийн дэвшил, цахим системийн талаар суурь ойлголт, мэдээллийг тасралтгүй өгч байх тэнхимийн болон орон зайн сургалтыг төлөвшүүлэх зохицуулалтыг хуульчлах хэрэгтэй байна. Боломжтой бол төр малчны мэргэжлийн чиг баримжаа олгох байнгын сургалтын ангийг сургалтын байгууллагуудыг түшиглэн зохион байгуулах, малчдын өөрөө удирдах байгууллагын бүтэц, үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөх нь чухал юм.
- Хөдөөд ажиллах хүчний дутагдал бий болж, малчны залуу халаа байхгүй болж байгаагаас цаашид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллах хүчний дутагдалд орохоор байна. Мөн хүйсийн харьцаанд өөрчлөлт орж, хөдөөд гэр бүл зохиоход хүйсийн тэнцвэр алдагдсан, мөн малчдын 6 настай хүүхдийг сургуульд оруулах зохицуулалтаас улбаалан гэр бүл салалт ихэсч байгаа нь мал аж ахуйг тогтвортой эрхлэхэд сөрөг нөлөөлөл авчирч байна.
- Мал аж ахуйн салбарын бодлого, зорилтот үйл ажиллагааг хэт ерөнхий байдлаар томъёолж байгаа тул нарийвчилсан зохицуулалт, тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэхдээ өрөөсгөл, хайнга ханддаг, сонирхсон ажлаа хийгээд

үр дүн нь удаан хугацаанд гарах ажлыг орхигдуулдаг, санхүүжилт, хөрөнгө оруулалт хомс зэргээр асуудалд залгамж чанартай, цогц байдлаар хандахгүй байна.

- Мал аж ахуйн үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд нэг малаас авах шим, чанарыг сайжруулах бодлогыг хүчтэй хэрэгжүүлэх, малчдыг мэдлэгжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх сонирхлын хөшүүргүүд бий болгох, малчдад нэн хөнгөлөлттэй зээлийн болон урт хугацааны хөнгөлөлттэй зээл, техник хэрэгслийн дэмжлэг үзүүлэх эрх зүйг бүрдүүлэх хэрэгтэй байна. Одоогийн ХАА-г дэмжих сан зөвхөн тариаланчдад үйлчилж байгааг хязгаарлах шаардлагатай.

Мал аж ахуйг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхдээ малын тоо толгойг өсгөх, малын өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, бэлчээрийн царцаа, оготнотой тэмцэх зэрэг асуудалд голлон анхаарч, ажиллах гол хүчин болсон малчдын асуудал дээр төдийлөн анхаарал хандуулахгүй байна гэх зэрэг шүүмж, санал, дүгнэлт, зөвлөмж, уриалгыг удаа дараалан зохион байгуулсан Малчдын сумын, аймгийн, улсын Зөвлөгөөнүүд дээр гаргасан байна. Мөн малчид, тэдгээрийн эрхэлж байгаа аж ахуйтай холбоотой тулгамдсан асуудлуудыг төрийн бодлогын түвшинд шийдвэрлэх хэрэгцээ, шаардлага хэдийнээ бий болсон гэж эрдэмтэд, судлаачид, малчид, мэргэжлийн холбоодын зүгээс шүүмжилсээр иржээ.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛСОН НЬ

Малчны эрх зүйн байдал, малчдын ажиллаж, амьдрах орчинд тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудлуудыг судалж, тодорхойлж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"-ын 4 дүгээр зүйлд заасны дагуу асуудлуудыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар томьёолж байна.

Асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгыг малчны эрх зүйн байдлыг тогтоох, тэдгээрийн ашиг сонирхол, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, малчны үйл ажиллагааны тогтвортой хөгжлийг хангах малчдыг хөгжүүлэх, чадавхжуулах харилцааг зохицуулахад чиглэсэн хуулийн төсөл боловсруулах гэж тодорхойлж байна.

Ерөнхий зорилгын хүрээнд түүний хэрэгжүүлэх зорилт нь нүүдлийн ахуй уламжлал, өв соёлыг хамгаалж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх малчны эрх зүйн үндсийг тодорхойлох, малчны хөгжил, бүтээмж, хариуцлагатай байдал, хамтын санаачилга, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдэнэ.

Хуулийн төслийн зорилтоор дараах эрх, харилцаа хангагдана гэж үзэж байна.

- Малчин, малчин өрхийн статусыг тодорхой болгох,
- Малчны хөдөлмөрийн хүрээний эрхийг хангах Малчны хөдөлмөрийн харилцаанд хамааралтай эрхийг хүлээн зөвшөөрч, малчны үнэлэмж, үнэ цэний онцлогийг тодорхойлж, мэргэшлийн зэрэг олгох, нийт малчид, ялангуяа

дэмжлэг, туслалцаа шаардлагатай буюу бага орлоготой малчдын эрхийг хуулиар хамгаалж, төлөөлөл, оролцоог нь баталгаажуулах.

- Малчны үйл ажиллагааны тогтвортой хөгжлийг хангах зорилгын хүрээнд малчны үйл ажиллагааны тогтвортой хөгжлийн зарчим, шалгуурыг тодорхой болгож, малчны хөдөлмөрийн ур чадварыг баталгаажуулах харилцааны зохицуулалттай болгож, тэдгээрийн хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмжийг нэмэгдүүлэх.
- Малчдын ажлын байрыг хадгалах, шинээр бий болгох Малчдын ур чадвар тогтвортой ажлын байртай байх бизнесийн үйл ажиллагаа, амьжиргааг сайжруулахад санхүү, хөрөнгө оруулалт, эдийн засгийн үйл ажиллагаагаар дэмжих.
- Нийгмийн харилцаан дахь хамтын нэгдэл, санаачилга, түншлэлийг дэмжих. Малчдын сайн дурын санаачилгын зохион байгуулалтыг дэмжих, малчдын өөрөө удирдах тогтолцооны бие даасан нэгдмэл байдал, эрх, чиг үүргийг тодорхой болгох, харилцан ойлголцсон эе эвтэй, харилцан үр ашигтай байх тогтолцоог бүрдүүлэх, аливаа маргаан зөрчлөөс урьдчилан сэргийлэх, малчдын нийгэм, эдийн засгийн харилцааны оролцоо, эрх тэгш байдлыг хангах.
- Нийгмийн хамгааллыг өргөжүүлэх. Эрэгтэй, эмэгтэй малчдын ажиллах, амьдрах орчныг байгальд ээлтэй байх, эрүүл, аюулгүй нөхцөлөөр хангах боломжийг бүрдүүлэх, зохистой хугацаанд амрах, чөлөөт цагтай байх боломжийг бүрдүүлэх, гэр бүл, нийгмийн үнэт зүйлсийг нь хүндэтгэн үзэх, хүн ам зүйн бодлогоор хүйсийн харьцааны тэгш байдлыг ойртуулах, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чанартай үйлчилгээнд хамрагдах баталгааг бүрдүүлэх, орлого багатай тохиолдолд хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх.
- Бэлчээрийн эдэлбэр газрын ашиглалттай холбоотой харилцааг бэхжүүлэх. Бэлчээрийн газрыг малчдын бүлэг, хэсэг төртэй гэрээ байгуулсны үндсэн дээр ашиглах, ашиглагч хариуцагч байх үүрэг хүлээх.
- Малчны гэр бүлийн ая тухтай амьдрах, үр хүүхдээ сургах, цахим боловсрол эзэмших, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээг шуурхай авах зэрэг амьдрах, ажиллах таатай орчныг бүрдүүлэхтэй холбогдсон зохицуулалт тусгах.
- Малчныг хөгжүүлэх, чадавхжуулах. Малчин өөрийгөө болон гэр бүлийн гишүүдээ хөгжүүлэх, уламжлалт мэдлэгээ баяжуулан дамжуулж, монгол малчны эрхэм зүйлсийг нандигнаж, нүүдэлчин өв соёлоо хадгалах. Үүнтэй холбоотойгоор малчдын мэдлэгийг арвижуулах, мэдээллээр тасралтгүй хангах, насан туршид мэдлэг боловсролоо дээшлүүлэх үүднээс цахим боловсрол олгох, сургалт явуулах, малчны мэргэжлийн үнэмлэхийг давтамжтай сургалттай холбох, малчны залуу халааг бэлтгэх тогтолцоог бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгах.

- Малчин төрийн цахимжуулсан үйлчилгээг авах, цахим хөтөчтэй болох, малчин өрхийн хаягийн цахимжуулалт, өмчлөлийн малын цахим бүртгэлийг хөгжүүлэх, малчин, малчин өрх, мэдээллийн санг хариуцлагатай малчдын баталгаажуулалттай уялдуулах.
- Малчны эдийн засгийн эргэлт, өсөлтийг дэмжих. Малчдаас мал, малын гаралтай түүхий эдийг орон нутагт хүлээн авч, чанараар нь ангилж, үнэ тогтоох, түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх.
- Малчны үйлдвэрлэл эрхлэлтийн хэв, шинж, төрлийн ангилалтай уялдуулан оруулж, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих санхүүжилтийн дэмжлэгийн механизмыг бүрдүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тус тус тусгаж, хуулийн зорилтыг хэрэгжүүлэх нь зохистой байна гэж үзлээ.
- Малчны хуулийн төслийн зорилт, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай уялдан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ байна. Ялангуяа “малчин”, “туслах малчин”, “малчин өрх” гэсэн нэр томъёог нэгдсэн байдлаар цэгцлэх, зөрчлийг арилгах хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Малыг генетик нөөцийн тухай, Малыг тоо толгойн албан татварын тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРЫГ ТОГТООЖ, ЭЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН НЬ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасны дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоохын тулд зохицуулалтын дараах хувилбаруудын эерэг болон сөрөг талыг зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд харьцуулан судалж, үр дүнг тодорхойлоход дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Асуудлуудыг шийдвэрлэх хувилбаруудын харьцуулалт

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1 “Тэг” хувилбар	Малчдын талаар хийсэн олон төрлийн судалгаа, хурал зөвлөгөөнөөс гарсан дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн хангалтгүй байгаа тул малчдад өнөөгийн тулгамдаж буй асуудлууд, бэрхшээл хэвээр үргэлжлэхээр байна. Иймд энэхүү хувилбараар дэвшүүлж	Нэмэлт зардал гарахгүй ч сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ. Үр өгөөж өгөхгүй.	Үр дүн сөрөг байна.

		хувилбараар зорилгод хүрч чадахгүй.	бууруулж чадахгүй.	
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх	Малчдын тулгамдсан асуудлууд нь өргөн цар хүрээтэй, олон салбарыг хамарч байгаа тул төрийн холбогдох байгууллагууд нэгдсэн бодлогын хүрээнд малчид, малчдын нэгдсэн холбоо, тэдгээрт үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн нийгэмлэг, холбоо, бусад төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй харилцан уялдаатай хамтран ажиллах шаардлагатай байгаа юм. Иймд уг харилцааг эрх зүйн хүрээнд нарийвчлан зохицуулж тодорхой болголгүйгээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлснээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй. Энэ хувилбараар зорилгын тодорхой хэсэгт үр дүн гаргахаар байгаа ч тулгамдсан асуудлуудыг бүрэн шийдвэрлэн зорилгод бүрэн хүрэхгүй.	Төрөөс бага хэмжээнд зардал гарах ч асуудлыг цогцоор нь бүрэн шийдвэрлэхгүй тул үр өгөөж бага.	Бүрэн үр дүнд хүрэхгүй, үр дүн сөрөг
6	Захиргааны шийдвэр гаргах	Дан ганц захиргааны шийдвэр гаргах замаар асуудлыг шийдвэрлэж зорилгод хүрэх боломжгүй. Түүнчлэн хуулиар зохицуулагдаагүй харилцаанд захиргааны шийдвэр гарган хэрэгжүүлэх боломжгүй тул энэ хувилбараар зорилгод хүрэхгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч сөрөг үр дагавар буурахгүй, үр өгөөж гарахгүй.	Үр дүнд хүрэхгүй
		Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас өнөөг хүртэл малчдын үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомж, шийдвэрүүдийг гаргасан боловч малчин хүний	Тодорхой хэмжээний зардал гарах боловч энэ хувилбар нь	

7	<p>Хууль тогтоомжийн төсөл боловсруулах</p>	<p>нийгмийн харилцаанд эрх тэгш байх, зөрчигдөж байгаа эрхийг нь хамгаалах, тогтвортой үйл ажиллагаа эрхлэх, чадавхжих, эрсдлээ бууруулах, аюулгүй, хариуцлагатай ажиллах түвшнээр үнэлэмжээ нэмэгдүүлэх, үнэн зөв мэдээлэл авах, хөдөөд ая тухтай, гэр бүлээрээ амьдрах орчинг бүрдүүлэх, насан туршийн боловсрол эзэмших, эрүүл мэндийн үйлчилгээ авах зэргээр нийгмийн хамгааллын доод түшингээ хангах зэрэг харилцаанд эрх зүйн орчинг нь бүрэн бүрдүүлж чадаагүй байна.</p> <p>Энэхүү хувилбараар малчид хэмээх нийгмийн томоохон бүлэг, баялаг бүтээгчид, нүүдлийн соёл иргэншлийн өв тээгчдийн эрх зүйн байдал, үнэлэмж, шалгуурыг тодорхой болгох, тэдгээрийн орон нутагтаа тогтвортой ажиллах, амьдрахтай холбогдсон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхээр дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжтой гэж үзэж байна.</p> <p>Малчдад хамааралтай үйлчилж байгаа одоогийн хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар арилгах боломжтой байна.</p>	<p>асуудлыг үүсгэж байгаа гол шалтгаануудыг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх, үр өгөөжтэй байх боломжтой, хувилбар гэж үзэж байна.</p> <p>Малчдад хамааралтай төрийн шийдвэр гаргах ажиллагаа ил тод, шуурхай болно.</p> <p>Зардал гарахгүй бөгөөд одоо үүсээд байгаа тулгамдсан асуудлуудын шалтгаан, сөрөг үр дагавар арилна.</p> <p>Малчид, малчдын өөрөө удирдах байгууллага, холбоо, холбогдох төрийн байгууллагуудын чиг үүрэг тодорхой болсноор цаашлаад үр ашиггүй, давхардсан хөрөнгө оруулалт</p>	Үр дүнтэй
---	---	---	---	-----------

			зогсож, улсын төсөв хэмнэгдэнэ	
--	--	--	-----------------------------------	--

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр анх тавьсан зорилгод хүрч чадах эсэхийг тогтоосон. Ингэхдээ тухайн зохицуулалтын хувилбарыг өөр салбарт хэрэглэсэн адилтгах туршлага байгаа эсэхийг судлах, уг асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа малчид, салбарын мэргэжилтнүүд, эрдэмтэн, судлаачдын саналыг сонсож, өмнө хийсэн судалгааны материал ашиглах зэрэг ажиллагаа хийсэн болно.

“Зардал, үр өгөөжийн харьцаа” шалгуур үзүүлэлтийг дүгнэхдээ зохицуулалтын хувилбарын нийгэмд үзүүлэх үр өгөөжийг ерөнхий байдлаар тодорхойлж, уг хувилбарыг хэрэгжүүлснээр нийгэмд үзүүлэх үр өгөөж нь хэр байх (зэрэг ба сөрөг, үр дүн их, бага, үр дүнгүй) талаарх тайлбарыг холбогдох этгээдэд ачаалал, нэмэлт зардал үүсэх эсэхийг ерөнхий байдлаар тандан судлах, дүгнэх замаар гүйцэтгэв.

Асуудлыг зохицуулах хувилбаруудын зэрэг болон сөрөг талыг харьцуулж үзэхэд зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенци хийх, төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байгаа тул хууль тогтоомж батлан гаргах хувилбар нь хамгийн сайн оновчтой хувилбар байна гэж үзэж байна. Иймд асуудлын мөн чанар, цар хүрээг харгалзаж, Малчны тухай хуулийн төслийг шинээр боловсруулах шаардлагатай гэж дүгнэв.

Түүнчлэн энэхүү тайлангаар судалсан асуудал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2-д заасан “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, мөн хуулийн Зургаадугаар зүйлийн 4-д “Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх”, Арван зургаадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх, сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, улсынхаа нутаг дэвсгэрт түр буюу байнга оршин суух газраа сонгох зэрэг үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ” гэж тус тус хуульчлан заасантай шууд хамааралтай харилцаа байгаа юм. Иймээс “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.4.1-д заасны дагуу хууль тогтоомжийн төсөл хэрэгжүүлэх хувилбарыг шууд сонгохоор байгаа нь эдгээр асуудлуудыг зохицуулах хүрээнд хууль тогтоомж батлан гаргах хувилбар нь хамгийн сайн хувилбар мөн гэдгийг давхар нотолж байна.

Иймд хуулийн төслийн агуулга, зохицуулалтыг өмнө тодорхойлсон зорилгын дагуу дараах байдлаар томъёолж байна. Энэхүү хуулийн төсөл нь “нүүдлийн ахуй уламжлал, өв соёлыг хамгаалж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх малчны эрх зүйн үндсийг тодорхойлох, малчны хөгжил, бүтээмж, хариуцлагатай байдал, нийгмийн хамгаалал, хамтын санаачилга, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах” зорилготой байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН НЬ

Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газраас баталсан аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд “хуулийн төсөл боловсруулах”-аар сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасан “хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө”, “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал” гэсэн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тандан судлав.

Малчны тухай хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг аргачлалд заасан суурь асуултуудад хариулах замаар тандан судалж, асуудлыг тус бүрт нь дараах байдлаар дүгнэж байна.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө:

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	1.1.3. Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх. Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж байгаа.
	1.2. Оролцоог хангах		
1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч, мэргэжилтэн, эрдэмтэн судлаач нар, мэргэжлийн холбоод, орон нутгийн удирдлагын төлөөллийг оролцуулж хэлэлцүүлэг хийж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлага байгаа эсэхийг тогтоосон.	

		Мөн оролцогчдын санал, хүсэлтийг хуулийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төсөлд тусгана.	
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Нийтийн эрх ашигт нийцнэ.
1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Малчин хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын конвенци, гэрээнд аливаа байдлаар харшлахгүй.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Үгүй.	Ийм зохицуулалт байхгүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Үгүй	Ийм зохицуулалт байхгүй
	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй

3.Эрх агуулагч	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл авчирна
5.Жендэрийнэрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Үгүй	Ийм зохицуулалт байхгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Ийм зохицуулалт байхгүй

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын конвенци, гэрээнд аливаа байдлаар харшлахгүй бөгөөд хүний эрхэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй, харин хуулиар тунхагласан хүний эрхийг баталгаажуулахад эерэг нөлөө үзүүлэхээр байна.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө:

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Гэхдээ одоогийн мал аж ахуй, малчны асуудал эрхлэх чиг үүргийг нягтруулахаар тусна
	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.

10.Макро эдийн засгийн хүрээнд	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь эдийн засагт сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй. Харин Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбарын нэг болох мал аж ахуйн салбар дахь хүний нөөцийн бодлого, эрх ашгийг хамгаалах, хөгжүүлэх, тэдгээрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх замаар мал аж ахуйг тогтвортой эрхлэх боломжийг бүрдүүлж, улс орны эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө авчирна.

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө:

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Ажлын ачаалалыг нягтаруулах ч сөрөг нөлөөгүй.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Ажлын ачаалалыг нягтаруулах ч сөрөг нөлөөгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.

6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхээргүй байна. Харин эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор хувь хүний эрх, эрх тэгш байдлыг хангахын зэрэгцээ цаг хугацаа, орон зайнаас үл хамаарч төрийн үйлчигээг хүнд сурталгүй, хүртээмжтэй, ил тод, хялбар, түргэн

шуурхай авах боломжийг бүрдүүлж, энэ нь нийгмийн хөгжилд эерэг нөлөөлөл үзүүлэхээр байна.

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар сөрөг байхгүй	нэгэн нөлөө
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар сөрөг байхгүй	нэгэн нөлөө
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар сөрөг байхгүй	нэгэн нөлөө
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар сөрөг байхгүй	нэгэн нөлөө
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Эерэг нөлөөлөл авчирна	
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар сөрөг байхгүй	нэгэн нөлөө
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.	
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар сөрөг байхгүй	нэгэн нөлөө
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар сөрөг байхгүй	нэгэн нөлөө
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл авчирна	
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар сөрөг байхгүй	нэгэн нөлөө

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Хуулийг хэрэгжүүлснээр бэлчээрийн доройтол, бэлчээрийн даац хэтрэлт, нөөцийн хомсдолыг бууруулах, хөрс талхлагдах, улмаар доройтох зэрэг учрах эрсдэлээс сэргийлж, байгаль орчинд эерэг нөлөөллийг авчрахаар байна.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн нь ...эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, ... хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй...”, мөн хуулийн Арван ёс дүгээр зүйлд “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль²¹-ийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт “Үндэсний аюулгүй байдал нь Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал, иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, экологийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байна” гэж тус тус заасантай нийцэхээр байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6-д “Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, нөхөрлөл, хоршооны гишүүн, дагалдан ба дадлагажигч зэрэг албан болон албан бус эдийн засагт ажиллаж, ажил хайж, мэргэжил эзэмшиж байгаа хүн бүр энэ хуулийн 5.1-д заасан дараах үндсэн эрхийг эдэлж, холбогдох үүргийг хүлээнэ.” гэж заасан. Үүнд:

5.1. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд оролцогч дараах суурь зарчмыг баримталж, холбогдох үндсэн эрхийг эдэлнэ:

5.1.1. үл ялгаварлан гадуурхах;

5.1.2. хөдөлмөрлөх эрх чөлөөг баталгаажуулах, ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангагдах, цалин хөлс авах, амрах;

5.1.3. дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох;

5.1.4. албадан хөдөлмөрлүүлэхийг хориглох;

5.1.5. барьцаа хэрэглэхгүй байх;

5.1.6. эвлэлдэн нэгдэх, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр байгуулах, ажилтан, ажил олгогч, тэдгээрийн төлөөлөгчдийн хоорондын харилцааг зохицуулах эрхийг хангах;

5.1.7. шударга бус үйлдлийг хориглох;

5.1.8. нийгмийн түншлэлийг хангах;

5.1.9. хүүхдийн хөдөлмөрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах.

Иймд малчны эрх зүйн байдлыг тодорхойлох, тэдгээрийн эрхийг хамгаалах зорилго бүхий шинээр боловсруулах хуулийн төсөл нь нийгэмд малчны хөдөлмөрлөх эрх чөлөөг баталгаажуулах, ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангагдах, цалин хөлс авах, амрах, нийгмийн хамгаалалд хамрагдах, эвлэлдэн нэгдэх, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр байгуулах, нийгмийн түншлэлийг хангах, үл ялгаварлан гадуурхах эрхийг эдлэх

²¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002, №3

боломжийг хангасан эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцнэ.

Тус хуулийн төсөлтэй уялдуулан хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй. Харин зарим холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах шаардлага гарна гэж үзэж байна. Малчин болон туслах малчны талаарх нэр томъёо, хуулийг эшилсэн Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Малын генетик нөөцийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн зохицуулалтад давхардал, хийдэл, зөрчил үүсэх магадлалтай байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "малчин" гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг;" гэж, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14-д "малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасан иргэнийг;" гэж, Малын генетик нөөцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11-д "малчин" гэж Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.14-д заасныг;" гэж, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-д "малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасныг;" гэж, Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2-д "туслах малчин" гэж үндсэн малчны дэргэд амьдарч, түүний удирдлага, хяналтын доор мал маллах, мал аж ахуйтай холбоотой бусад ажил эрхэлж цалин хөлс авахаар харилцан тохиролцон ажиллаж байгаа хүнийг ойлгоно. Бусдын малыг бие даан хөлсөөр маллахтай холбогдсон харилцааг Иргэний хуулиар зохицуулна." гэж тус тус заасан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд "малчин" гэж тодорхойлсон нэр томъёо нь өнөөгийн нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн харилцаанд хэт ерөнхий байгаа талаар салбарын мэргэжилтэн, эрдэмтэн, судлаачид шүүмжилдэг байна. Иймд нэгэнт малчны эрх зүйн байдлыг тодорхойлсон бие даасан хуулийн зохицуулалттай болох тохиолдолд "малчин", "туслах малчин" гэсэн тодорхойлолтыг нэр томъёоны хувьд нэг мөр болгон шинэчлэн тодорхойлж, бусад хуулиуд нь энэхүү хуулиас эшлэл авах байдлаар зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Иймд дээр дурдсан нэр бүхий хуулиудад холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар дагалдах хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж үзэж байна. Мөн Малчны тухай бие даасан хуулийн төслийг баталсан тохиолдолд Зөрчлийн тухай, Зөрчил хянан шалгах тухай хуульд холбогдох, нэмэлт, өөрчлөлтийг тусгахаар дагалдах хуулийн төслийг боловсруулахаар байна.

ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛЖ, ДҮГНЭЛТ ХИЙСЭН НЬ

Аргачлалын 7-д зааснаар зохицуулалтын хувилбарын үр нөлөөг урьдчилан тандаж судалсны үр дүнд илрүүлсэн зохицуулалтын хувилбарын эерэг болон сөрөг үр нөлөөг хооронд нь харьцуулж, эерэг болон сөрөг талуудыг зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцаа, хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, хууль тогтоомжтой нийцэж буй эсэх, гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягталж үзэв. Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх хувилбарыг сонгосноор төрийн үйл ажиллагаа, үйлчилгээ цахим

хэлбэрээр явагдах эрх зүйн үндсийг бий болгохгүй бөгөөд харин хууль тогтоомж батлагдан гарсны дараа энэхүү хувилбарыг хэрэглэн энэ талаарх мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд хүргэх нь чухал юм. Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрээр явуулах асуудлыг зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийх боломжгүй юм. Учир нь эрх зүйн орчин дутагдалтай байгаа тул төрөөс шууд зохицуулалт хийх боломжгүй байна.

Дээрх зохицуулалтын хувилбаруудын харьцуулалт болон шийдвэрлэхээр сонгосон асуудлуудын цар хүрээг Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, бусад хууль тогтоомж, Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зарчим, үзэл баримтлал, дэвшүүлсэн зорилго, зорилт зэргийг харьцуулан үзсэний үндсэн дээр дараах дүгнэлтийг хийв.

Малчны тухай хуулийн төсөл шинээр боловсруулах шаардлага байгааг хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах аргачлалд дурдсан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу авч үзээд дор дурдсан байдлаар нэгтгэн харуулж, дүгнэлт хийж байна.

Хүснэгт 5.Хуулийн төсөл шинээр боловсруулах шаардлага

Шалгуур үзүүлэлт	Зохицуулалтын хувилбар: "шинээр хуулийн төсөл боловсруулах"
Зорилгод хүрэх байдал	Хууль тогтоомжийн төсөл боловсруулснаар Монгол Улсын Үндсэн хууль -ийн Арван зургадугаар зүйлд "Монгол Улсын иргэн нь ... эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, ... хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй...", Арван ёс дүгээр зүйлд "төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод "үндэсний өв соёл, нүүдлийн ахуйг уламжлал, шинэчлэлтэй хослуулсан, нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно." гэсэн зорилгын хэрэгжилтийг хангах бөгөөд уг үр дүнд хүрэх суурь үндэс нь нүүдлийн ахуй, соёл иргэншлийг тээж яваа малчны эрх зүйн үндсийг тодорхой болгох, тэдгээр нь энэ

	<p>чиглэлийн үйлдвэрлэлээ тогтвортой эрхлэх эрх зүйн таатай орчин бүрдүүлэх зорилгод хүрэх юм.</p> <p>Хуулийн төслийн зорилтоор малчин, малчин өрхийн статусыг тодорхой болгох, малчны хөдөлмөрийн хүрээний эрхийг хангах, малчны үйл ажиллагааны тогтвортой хөгжлийг хангах, малчдын ажлын байрыг хадгалах, шинээр бий болгох, малчдын бизнесийн үйл ажиллагаа, амьжиргааг сайжруулахад санхүү, хөрөнгө оруулалт, эдийн засгийн үйл ажиллагаагаар дэмжих., малчдын нийгмийн харилцаан дахь хамтын нэгдэл, санаачилга, түншлэл, эдийн засгийн эргэлт, өсөлтийг дэмжих, малчдын сайн дурын санаачилгын зохион байгуулалтыг дэмжих зэрэг малчдын нийгэм, эдийн засгийн харилцааны оролцоо, эрх тэгш байдлыг хангах зорилгод хүрнэ.</p>
<p>Хүний эрх, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө</p>	<p>Малчны тухай хуулийн төслийг боловсруулснаар малчин хүний үндсэн эрх хангагдах нөхцөл бүрдэж, эдийн засагт эерэг нөлөөг бий болгохын дээр малчны үйлдвэрлэл эрхлэх үндсэн суурь болсон харилцааг зохицуулж, эдийн засаг, байгаль орчинд дараах эерэг нөлөө үзүүлэхээр байна.</p> <p>Бэлчээрийг нийтээр ашиглаж, хариуцлага хүлээдэггүй байдлыг зогсоож, бэлчээрт өөриймсөг хандаж, даацад нь тааруулан хуваарь сэлгээтэйгээр зохистой ашиглах, хөрөнгө хүч зарж хамгаалах сэтгэлгээ төлөвшин, малын тоог өсгөх биш харин эдийн засгийн эргэлтэд оруулан борлуулах, ашиг шим, чанарыг эрхэмлэх өөриймсөг сэтгэлгээ хүчирхэгжин, хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. Бэлчээрийн унаган төрхийг сэргээн хадгалж, нүүдлийн уламжлалт мал аж ахуйг дэмжин хөгжүүлснээр аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх ба өсөн нэмэгдэж буй органик хүнсний эрэлт, хэрэгцээ, хангамжийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.</p> <p>Мөн манай улсын бэлчээрийн мал аж ахуй эрхлэх өвөрмөц онцлог, уламжлал, зан заншил, бэлчээрийн зохистой ашиглалт, хамгаалалтад чиглэгдсэн оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</p> <p>Бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх цар хүрээг тодорхой болгосноор мал аж ахуйн</p>

	<p>үйлдвэрлэлийн харилцаанд оролцогчдын нийгмийн өмнө хүлээх эрх, үүрэг, хариуцлага тодорхой болж, хариуцлагатай нүүдэлчин малчдыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ. Сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах, бэлчээрийн газар нутгаа зохистой ашиглах, хамгаалах, эрүүл, мал сүргээ өсгөн үржүүлэх, үр ашигтай ажиллах зохион байгуулалтын тогтолцоо, харилцаанд нийгмийн үүрэг, ёс зүйн хэм хэмжээг сахих, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.</p> <p>Хөдөөд суурьшиж, уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэх малчныг урт хугацааны хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжсэнээр нийслэлийн хэт төвлөрөл, замын ачаалал, агаарын бохирдлын ачаалал, сөрөг нөлөөг бууруулна.</p> <p>Мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлэх, дэмжих үйл ажиллагааны зарчим, цар хүрээг тодорхой болгож, урт хугацааны хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжсэнээр малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний орц, гарцын сүлжээнд бүтээмж, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэж, хөдөөгийн хөгжилд ахиц гарч, малчдын үйл ажиллагааны эрх тэгш, тогтвортой байдал хангагдана.</p> <p>Малын гаралтай хүнс, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, тэдгээрийг боловсруулах үйлдвэрийн сүлжээг орон нутагт дэмжин хөгжүүлснээр малчин өрхөөс хүн амын хүнсний хангамжид оруулах хувь хэмжээг өсгөж, малчин өрхийн орлого, эдийн засгийн чадавх сайжирна.</p>
Зардал үр өгөөжийн харьцаа	Хуулийн төсөл батлагдсанаар нэмэлт зардал улсын төсөвт гарахгүй
Гарч болох сөрөг үр дагаврыг илрүүлэх	Гарч болох сөрөг үр дагаврыг илрүүлж, зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар дагалдах хуулийн төслийг боловсруулна.
Хууль тогтоомжид нийцэх эсэх	Дээр дурдсанчлан Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ бусад хууль тогтоомжид нийцэхээр байна.

Тухайн зохицуулалтаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох	Тухайн зохицуулалтаар малчин иргэн, мал бүхий этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хангагдах ба малчны хөдөлмөр эрхлэлтийн үнэлэмж тодорхой болж, малчин хүн, тэдгээрийн өрхийн гишүүдийн нийгмийн баталгаа, гэр бүл төлөвлөлтөд эерэг нөлөөлөл үзүүлж, эрх, хууль ёсны ашиг сонирхол хангагдахаар байна.

Малчны эрх зүйн байдал нь шударга, эрх тэгш байх хүний салшгүй эрхэд хамааралтай бөгөөд дээр дурдсан асуудлуудыг зохицуулах хүрээнд хууль тогтоомж батлан гаргах замаар шийдвэрлэх хувилбар нь хамгийн тохиромжтой, оновчтой хувилбар байна гэж дүгнэв.

ЗУРГАА. ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН НЬ

Малчны эрх зүйн байдалтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахдаа хууль тогтоомжийн төсөл шинээр боловсруулах хувилбарыг сонгосон тул тухайн зохицуулалтын талаарх олон улсын эрх зүйн холбогдох зохицуулалт, бусад улсын адил төстэй хууль тогтоомжийг харьцуулсан судалгааг хийлээ.

Аргачлалын 8.2-д зааснаар "тухайн асуудлыг зохицуулсан олон улсын эрх зүйн холбогдох зохицуулалтад Монгол Улсын олон улсын гэрээ, түүнчлэн тухайн харилцааг зохицуулсан олон улсын гэрээ, хууль тогтоомж, олон улсын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичиг (тогтоол, шийдвэр, тунхаглал г.м), зөвлөмж зэрэг хамаарах"-аар байгаа тул эдгээр эх сурвалжийн хүрээнд судалж, харьцуулалтыг хийсэн болно.

Хүний эрхийн тухай хууль тогтоомжид төрөөс дараах үндсэн үүргийг хүлээнэ гэж үздэг. Үүнд

- хүний эрхийг хангах- хүний эрхээ эдлэх үйл явцад саад тотгор учруулахгүй байх
- хүний эрхийг хамгаалах – хүн эрхээ эдлэх үйл явцад бизнесийн болон төрийн бус байгууллагууд зэрэг гуравдагч тал саад тотгор учруулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх буюу хуулиар хүний эрхийг хамгаалах
- хүний эрхээ эдлэх таатай орчныг бүрдүүлэх
- засаглалын аливаа зохицуулалт нь хүний эрхийг үл зөрчих гэжээ.

Олон улсын түвшний малчны эрх зүйн зохицуулалтад хамааралтай эрх зүйг судлахдаа Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт, Монгол Улсын нэгдэн соёрхсон Олон Улсын конвенци, тунхаг, протокол, НҮБ-ын дэргэдэх төрөлжсөн, тухайлбал, Олон Улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ буюу ILO), Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ буюу FAO) зэрэг байгууллагаас санаачлан малчид, фермер эрхлэгч нарын эрх, тэдгээрийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлтэй холбоотой НҮБ-ын

гишүүн орнуудын баталж, хэрэгжүүлж байгаа эрх зүйн баримт бичиг, зохицуулалтыг судалж, харьцуулсан болно.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217/A/III/ тогтоолоор баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 22 дугаар зүйлд "хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ хэрэгжүүлэх эрхтэй", 23 дугаар зүйлд "хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй", "ажил хөдөлмөр эрхэлж байгаа хэн боловч хувийн болон ам бүлийнхээ ахуй амьжиргааг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц бөгөөд зайлшгүй тохиолдолд нийгмийн хангамжийн эх үүсвэрээр нэмэн арвижуулсан, хийсэндээ таарсан, хүртээмжтэй шан хөлс авах эрхтэй", 24 дүгээр зүйлд "хүн бүр ажлын цагаа зохистойгоор хязгаарлуулах, цалинтай ээлжийн амралт эдлэх эрхийг оролцуулан амрах, зав чөлөөтэй байх эрхтэй", 25 дугаар зүйлд "хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаагаар байх эрхтэй", "...бүх хүүхэд нийгмээс адилхан хамгаалалт эдлэх ёстой", 26 дугаар зүйлд "хүн бүр сурч боловсрох эрхтэй, ...анхан шатны боловсролыг заавал эзэмшүүлэх ёстой. Техникийн болон тусгай мэргэжлийн боловсрол нийтэд хүртээлтэй байх ёстой. Авьяас чадвартай нь уялдан хүн бүрт дээд боловсрол эзэмших боломж адилхан хүртээлтэй олгох ёстой", 27 дугаар зүйлд "хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй", "хүн бүр өөрийн ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрхтэй", 28 дугаар зүйлд "хүн бүр энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг бүрэн эдлэж болохуйц нийгмийн болон олон улсын дэг журамд аж төрөх эрхтэй", 29 дүгээр зүйлд "хүн бүр нийгмийнхээ өмнө тодорхой үүрэг хүлээнэ..." гэж тус тус заасан.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-аас эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд хүний хөгжил улам бүр чухал болж байгааг тодорхойлох зорилгоор үндэстний хүний хөгжлийн илтгэлийг гаргаж байхыг гишүүн орнууддаа уриалан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ) 1990 онд дэлхийн хүний хөгжлийн анхны илтгэлийг боловсруулсан. Энэхүү илтгэл нь хүний хөгжлийн үзэл баримтлалыг танин мэдэх, тухайн улс оронд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх нөөц бололцооны талаарх нэгдсэн мэдээлэл, судалгаа бий болгох зорилготой. Өнгөрсөн хугацаанд дэлхийн 140 гаруй улс орны нийт 700 гаруй илтгэл боловсруулагдан бэлэн болсон байна. Монгол Улс 1997 оноос хойш 3 жилийн давтамжтайгаар нийт 6 илтгэлийг боловсруулаад байна. Дэлхийн тогтвортой хөгжлийн бодлогын 17 зорилго 169 зорилт нь хүний хөгжлийн үзүүлэлттэй шууд болон шууд бусаар холбогдож байгаа юм.

Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ) нь олон улсад нийцэх хөдөлмөрийн хэм хэмжээг тогтоож, хөдөлмөрийн хүрээний эрхийг хангах, зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах, хөдөлмөрийн асуудлаарх нийгмийн түншлэлийг бэхжүүлэх чиглэлээр ажиллаж байна. 1946 оны "Филадельфийн Тунхаглал"- аар

хөдөлмөр бол бараа бүтээгдэхүүн биш гэдгийг тунхаглаж, энэ хүрээнд төр баталгаажуулах ёстой хүний үндсэн болон эдийн засгийн эрхийг тодорхойлсон бол 1998 онд "Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн тухай Тунхаглал"-аар хөдөлмөрийн суурь хэм хэмжээг тогтоосон байна.

НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын "Амьтны генетик нөөцийн хууль эрх зүйн орчин" тайланд мэргэжлийн холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны зохицуулалтыг нарийвчлан тогтоох шаардлагатай талаар дурдаж, холбооны үйл ажиллагааны чиглэлийг тодорхой байлгах асуудлыг дэвшүүлсэн байна. Тухайлбал, мал аж ахуйн мэргэжлийн холбоо нь малын бүртгэл, мал аж ахуйн арга, ажиллагааны мэдээллийг бүрдүүлэх, баяжуулах, хамгаалах, худалдаа, олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулах, мал аж ахуйн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, мал, амьтны үржүүлгийн зохион байгуулалттай ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, сургалт, дадлагажуулах ажиллагааг зохион байгуулах, мал аж ахуй эрхлэгчдийн дундах уралдаан, тэмцээн, бусад үйл ажиллагаа зохион байгуулах, идэвхжүүлэх зэрэг ажлыг хариуцах гэжээ.

Аргачлалын 8.3-д заасны дагуу тухайн зохицуулалтын талаарх бусад улсын адил төстэй хууль тогтоомжийн харьцуулсан судалгааг хийхдээ манай улсын хөрш хоёр орон БНХАУ, ОХУ ба хөдөө аж ахуйн чиглэлээр сайн туршлагыг хэрэгжүүлж, илүү дэвшилттэйгээр зохицуулж байгаа Канад, Австрали улсыг сонгон авч холбогдох хууль тогтоомжийг нь судлав. Эдгээр улсын хуулийн харьцуулсан судалгааг хийхдээ эрх зүйн зохицуулалт хийж буй хуулийн нэр, хуулийн агуулга, ерөнхий зохицуулалт, онцлог зохицуулалт гэсэн дарааллаар судалсан.. Судалгаа хийсэн улс орнуудын хуулийн онцлог зохицуулалтыг дурдахад дараах байдалтай байна.

БНХАУ: Хятад улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих үндсэн арга бол татаас юм. Улс, орон нутгийн онцлогтоо тохируулан ДХБ-ын дүрэмд нийцүүлэх замаар хөдөө аж ахуйн үндсэн бодлогоо хэрэгжүүлдэг. Татаас нь хөдөө аж ахуйн орцод зориулсан ерөнхий татаас, үр тариа үйлдвэрлэгчдэд олгох шууд татаас, дээд зэргийн үр тарианы сортын татаас, газар тариалангийн дэвшилтэт багаж хэрэгсэл, машин механизм худалдан авахад зориулсан татаас гэсэн үндсэн хэлбэрүүдтэй. Засгийн газраас 2013 онд баталсан "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хөгжлийн санхүүжилтийн удирдлагын арга хэмжээ" баримт бичигт хөдөө аж ахуйд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэхдээ тариалангийн газар нутгийг анхаарч, тариалангийн газрын нөөцийг хамгаалах, хөдөө аж ахуйн, голчлон дэвшилтэт машин техник худалдан авах, машин механизмыг худалдаж авах, шинэчлэх, инновацын туршилтын төслүүдийг хэрэгжүүлэх, хөдөө аж ахуйн шинэ аж ахуйн нэгжүүдийг дэмжих, хөдөө аж ахуйн нийгмийн үйлдвэрлэлийн үйлчилгээ, чадварлаг тариаланчдад зориулсан тариалалтын төлөвлөгөө, хөдөө аж ахуйн зээлийн баталгаа гаргах зэрэгт чиглэгддэг. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ голчлон ашигтай, онцлог шинж чанартай хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих, сүүний үйлдвэрийг сэргээж, мал, шувууг эрүүлжүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн парк, суурин газруудад анхдагч, хоёрдогч, гуравдагч үйлдвэрүүдийг нэгтгэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний газарзүйн заалтыг хамгаалах, тосгонуудад мэдээллийн технологи нэвтрүүлэх зэрэгт анхаардаг. Санхүүгийн дэмжлэгийг

голчлон тариаланчид, шинээр хөдөө аж ахуй эрхлэгчид, үйл ажиллагаанд оролцогч нэгж, хувь хүмүүст олгодог байна.

ОХУ: Хөдөө аж ахуйн хөгжлийн тухай, Хөдөөгийн тосгоны тухай, Мал аж ахуйн тухай зэрэг хуулиудыг батлан мөрдөж байгаа. ОХУ-ын хувьд ХАА-г хөгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэг нь үндсэн 13 чиглэлтэй байна. Үүнд: малын үржлийн аж ахуй, элит үр үйлдвэрлэл, хөрсний үржил шимийг сайжруулах, зорилтот бүсэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдийг дэмжих, органик хөдөө аж ахуйг хөгжүүлж, органик үйлдвэрлэгчдийг дэмжих зэрэг болно. Төрийн дэмжлэгийг улсын хөдөө аж ахуйн хөтөлбөрт илүү нарийвчлан тодорхойлж, ОХУ-ын Засгийн газраас бүс нутгийн төсөвт татаас хэлбэрээр олгодог. Эдгээр татаас олгох тусгай журам, шалгуурыг бүс нутгийн түвшинд тогтоож, хөдөө аж ахуйн нэгжүүдэд олгох татаасны хэмжээг бүс нутгийн эрх баригчид тогтоодог. Төрийн дэмжлэгийн нэмэлт хэлбэр болгон төрөөс сонгон шалгаруулсан хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, боловсруулагчдад олгох зээлийн хүүгийн хүртээмжтэй, хөнгөлөлттэй нөхцөл, түүнчлэн хөдөө аж ахуйн эрсдэлийн татаасаар даатгалд хамруулдаг. Хөдөө аж ахуйн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээг бүс нутгийн хөтөлбөрийн хүрээнд бүс нутгийн түвшинд тогтоодог. Тэдгээрийн агуулга нь тухайн бүс нутгийн онцлог шинж чанар, хөдөө аж ахуйн боломж, хэрэгцээ шаардлагаас хамааран ихээхэн ялгаатай байдаг.

Австрали Улс: Хөдөө аж ахуй, Ус, Байгаль орчны газар (DAWE) нь хөдөө аж ахуй, загасны аж ахуй, ойн аж ахуйн салбарын бүтээмж, экспортыг нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын үйл ажиллагааг дэмжих зорилгоор буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалт, санхүүгийн тусламж, татварын хөнгөлөлт үзүүлдэг. DAWE нь Австралийн фермерүүдэд ган болон хөдөөгийн дэмжлэг: гантай холбоотой нөхцөл байдлыг зохицуулах, ирээдүйн ган гачигт бэлтгэхэд туслах, байгаль орчныг хадгалах, хамгаалах чиглэлээр ажилладаг эрх бүхий байгууллагуудад хандив өгөхөд татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг хэлбэрээр дэмжлэг, хөнгөлөлт үзүүлдэг. Засгийн газрын хөдөө аж ахуй дахь инновацыг санхүүжүүлэх үндсэн хэрэгсэл нь Хөдөөгийн Судалгаа, Хөгжлийн Корпорацуудын сүлжээ юм. Эдгээр төрийн өмчит аж ахуйн нэгж, аж үйлдвэрийн өмчит ашгийн бус байгууллагууд нь хөдөө аж ахуйн бүтээмж, ашигт ажиллагаа, тогтвортой байдлыг сайжруулахын тулд судалгаа шинжилгээ, хөгжүүлэлт, нэвтрүүлэх, зах зээлд нэвтрэх, зах зээлийг хөгжүүлэх, сурталчлахад хөрөнгө оруулалт хийх замаар ажилладаг. Хөдөө аж ахуй, загас агнуур, ойн аж ахуйн салбарын хувьд холбоо, муж, нутаг дэвсгэр, орон нутгийн засаг захиргаа зохицуулалт, бодлогыг хэрэгжүүлдэг. Тэдгээр нь хөдөө аж ахуй, хүнсний хуулийн төрөл бүрийн асуудлыг хариуцдаг бөгөөд заримдаа байгаль орчныг хамгаалах гэх мэт салбарыг хамарсан давхацсан зохицуулалттай байдаг. Муж, нутаг дэвсгэрийн засгийн газар нь эрүүл мэнд, байгалийн баялаг, хөдөө аж ахуй, нийтийн аж ахуй (цахилгаан, ус), ой мод зэрэг асуудлаар хууль гаргах өргөн хүрээний эрхтэй. Муж, нутаг дэвсгэрийн засгийн газрууд газар эзэмших, газар ашиглах, байгаль орчныг хамгаалах, уугуул ургамлын менежмент, генийн өөрчлөлттэй (ГМ) тариалалт, зам тээвэр, мал аж ахуйн зохицуулалт зэрэг зохицуулалтыг хэрэгжүүлдэг. Орон нутгийн засаг захиргаанд эрх мэдлээ муж улсын хуулиар олгодог. Тэд газар ашиглалт, төлөвлөлт, хог хаягдал, байгаль орчныг хамгаалах, хүнсний аюулгүй байдал, тусгай зөвшөөрөл олгох

чиглэлээр зохицуулалтыг (ихэвчлэн муж, нутаг дэвсгэрийн засгийн газрын нэрийн өмнөөс) хэрэгжүүлж, орон нутгийн замд нэвтрэх, тээвэрлэх, машин механизм ашиглах нөхцөлийг тогтоодог.

Канад Улс: Хөдөө аж ахуйг дэмждэг олон төрийн бус болон ашгийн бус байгууллагууд байдаг. AgPal зэрэг вэбд суурилсан төрөл бүрийн хэрэгслүүд Канадын фермерүүд болон хөдөө аж ахуйн бизнесүүдийг ижил төстэй түншүүд болон байгууллагуудын удирддаг хөтөлбөр, үйлчилгээтэй холбодог. Хөдөө аж ахуйн зээлийн корпораци нь ашгийн бус корпораци бөгөөд Канад даяар тариаланчдад хямд өртөгтэй үйл ажиллагааны зээл олгодог. Түүхий эдийн зээлийн хөтөлбөрөөр үр тариа, тосны ургамал, хүнсний ногоо боловсруулахад 22 хүртэлх сарын орцын санхүүжилт олгож байна. Урьдчилгаа төлбөрийн хөтөлбөр нь баталгаа гаргаж, тодорхой зээлийн хүүгийн төлбөрийг нөхөх замаар Канад даяар үйлдвэрлэгчдэд бэлэн мөнгөний урьдчилгаа олгодог. Farm Credit Canada нь анхдагч үйлдвэрлэгчид, хүнсний үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн бизнесүүдэд зээл, зээлийн баталгаа, бизнесийн удирдлагын зөвлөгөө, сургалт, даатгал, венчур хөрөнгө, удирдлагын нягтлан бодох бүртгэлийн программ хангамж зэрэг үйлчилгээ үзүүлдэг. Канадын хөдөө аж ахуйг холбооны болон мужийн засгийн газар удирддаг. Холбооны засгийн газар банк, худалдаа, худалдаа, дампуурал, төлбөрийн чадваргүй байдлын асуудлыг шийдвэрлэх эрх мэдэлтэй. Мужийн засаг захиргаа нь аймагтаа эд хөрөнгө, газартай холбоотой эрх мэдэлтэй байдаг. Улсын хэмжээнд импорт, үйлдвэрлэлийн төлөвлөлтөд онцгой хяналтыг холбооны засгийн газарт олгодог боловч хөдөө аж ахуйн эрх зүйг ерөнхийд нь мужууд нь зохицуулдаг. Муж бүр байгаль орчны хууль, хортон шавьжтай тэмцэх дүрэм, ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хууль, цагаач ажилчдын дүрэм, хүнсний бүтээгдэхүүний баталгаажуулалтын стандарт, орон нутгийн засаг захиргааны бүсчлэл, газар ашиглалтын хязгаарлалт зэргээр дамжуулан хөдөө аж ахуйн газрыг өмчлөх, ашиглахад хязгаарлалт тавьдаг. Холбооны засгийн газар нь тариалан тарьсан, мал өсгөсний дараах процесст оролцоо нь илүү байдаг. Канадын Хүнсний хяналтын агентлаг (CFIA) нь мужаас гадуур худалдаалагдах бүх бүтээгдэхүүнийг хянаж, зөвшөөрнө. Холбооны засгийн газар мөн хэл, агуулга, гэрчилгээ зэрэг бүтээгдэхүүний сав баглаа боодлыг зохицуулдаг байна.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"-ын дагуу хийсэн энэхүү судалгааны дүгнэлтийг үндэслэн дараах Зөвлөмжийг хууль санаачлагчид хүргүүлж байна. Үүнд:

1. Малчидтай холбоотойгоор нийгэм, эдийн засагт үүссэн асуудлууд, түүний мөн чанар, цар хүрээ, асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг тодорхойлон дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлэх зорилго, зохицуулах хувилбаруудыг тогтоож, эерэг ба сөрөг талуудыг харьцуулж, хувилбаруудын үр нөлөөг тандан судлаад хамгийн үр дүнтэй хувилбар нь шинээр "хуулийн төсөл боловсруулах" гэж тодорхойлж байна.

2. Монгол Улсын нүүдлийн ахуйт уламжлал, өв соёлыг хамгаалж, хүн амын хүнс, үндэсний үйлдвэрийн түүхий эдийн үндсэн нөөцийг мал аж ахуйн үйлдвэрлэлээс хангаж байгаа "малчин"-ы эрх зүйн үндсийг тодорхой болгож, тэдгээрийн хөгжил, бүтээмж, хариуцлагатай байдал, нийгмийн хамгаалал, хамтын санаачилга, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг хуулийн төсөл боловсруулах аргаар шийдвэрлэх нь хамгийн оновчтой хувилбар гэж үзэв.
3. Малчин хүн газар нутагтаа эзэн байж, мал аж ахуйн үйлдвэрлэлээ тогтвортой эрхлэх эрх зүйн таатай нөхцөлийг бүрдүүлснээр уугуул иргэдийн жам ёсны болон Үндсэн хуулиар баталгаажсан эрхийг хангахын зэрэгцээ тэдгээр нь нийгмийн харилцаанд хөдөлмөрийн үнэлэмжтэй эрх тэгш байх, үүрэг, хариуцлага хүлээх, насан туршид сурч боловсрох, мэдээллээр хангагдах, хөгжих, нийгмийн хамгаалал, дэмжлэгийг хүртэх цар хүрээг тодорхой болгох нь хуулиар зохицуулах шаардлагатай харилцаа гэж үзэв.
4. Тухайн асуудлын зохицуулалтыг манай улсын болон бусад олон улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулахад шинээр боловсруулах Малчны тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол улсын Олон улсын гэрээ бусад холбогдох холбогдох хууль тогтоомжоор зохицуулсан харилцаа, төрийн болон салбарын урт, дунд хугацааны бодлого, зорилттой уялдаж байгаа тул сөрөг үр дагавар үүсэхгүй гэж үзэж байна.
5. Тухайн асуудлыг зохицуулах харилцаатай холбогдон бусад хууль тогтоомжид давхардал, хийдэл, зөрчил үүсгэхгүйн тулд нэр бүхий холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулж, дагалдах хуулиар өргөн мэдүүлэх шаардлагатай гэж үзлээ.
6. Түүнчлэн тус хуулийн төслийг баталж, хэрэгжүүлэх үйлчлэлийн хугацаатай уялдуулан дагалдах хуулиудыг хэрэгжүүлэх хугацааг тогтоох нь зүйтэй.
7. Сонгосон зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлэхэд гарах үр нөлөөг "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын дагуу, гарах зардлыг "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын дагуу тус тус судалж, нарийвчлан тогтоох шаардлагатай.
8. Дээрх асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Малчны тухай хуулийн төслийг боловсруулахдаа дор дурдах зохицуулалтыг тусгахыг зөвлөж байна. Үүнд:
 - Малчны эрх зүйн байдал, хуулийн үйлчлэх хүрээг тогтоох;
 - малчны үйл ажиллагааны тогтвортой байдал, хөгжлийг хангахад чиглэгдсэн, ялангуяа малчдыг хөгжүүлэх, чадавхжуулах талаарх зохицуулалтыг тусгах;
 - малчны бүтээмж, хариуцлагатай байдлыг тодорхойлох, үнэлэх баталгаажуулах зарчим, шалгуурыг тогтоох;
 - малчны хамтын санаачилга, хоршил, өөрөө удирдах байгууллагын тогтолцоог тодорхойлж, эрх, чиг үүргийг тогтоох;
 - малчны үйл ажиллагаанд цахим системийг нэвтрүүлэх, малчны үйл ажиллагааг дэмжихтэй холбогдсон зохицуулалтыг тусгах

- малчны эдийн засгийн эргэлт, өсөлт, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, дэмжлэг үзүүлэх харилцааг нарийвчлан зохицуулах;
- бусад зэрэг болно.

9. Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны үндэслэл, дүгнэлт, зөвлөмжид тулгуурлан асуудлыг шийдвэрлэхэд “хамгийн үр дүнтэй хувилбар” буюу Малчны тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, холбогдох шатуудад хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх хувилбарыг сонгох нь зүйтэй гэж үүгээр зөвлөж байна.

---o0o---

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

I. Судалсан Монгол Улсын хууль, тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль;
3. Монгол Улсын Их Хурлын тухай хууль;
4. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
5. Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
6. Хууль тогтоомжийн тухай хууль;
7. Хөдөлмөрийн тухай хууль;
8. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль;
9. Малын генетик нөөцийн тухай хууль;
10. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль;
11. Малын тоо толгойн албан татварын тухай хууль;
12. Зөрчлийн тухай хууль;
13. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль;
14. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол;
15. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол;
16. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоол;
17. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол;
18. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”;
19. Монгол малчин үндэсний хөтөлбөр батлах тухай Засгийн газрын 2020 оны 34 дүгээр тогтоол;

II. Ашигласан судалгаа, мэдээ, мэдээллийн жагсаалт:

- Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992, №01
- Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1994, №09.
- Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2015, №25
- Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2020, №25
- Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2020, №36

- Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2020, №38
- Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2021, №11
- Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2022, №09
- Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, Үндэсний Статистикийн Хорооны танилцуулга, 2020 он
- Монгол Улсын хөгжлийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанар, уялдаанд хийсэн шинжилгээ (Тайлан I), ҮХГ, 2018
- ХАА-н салбарын статистик танилцуулга, ҮСХ, 2000-2021 он
- <https://www.1212.mn/>
- <https://google.com/>
- Бусад эх сурвалж

Товчилсон үг:

ХАА – Хөдөө аж ахуй

МАА – Мал аж ахуй

ХХААХҮЯ -Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

ҮСХ -Үндэсний статистикийн хороо

ХАВСРАЛТ

МАЛЧНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛӨӨР ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦААТАЙ ХОЛБОГДУУЛАН СУДАЛСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

д/д	Хуулийн нэр	Зохицуулалт
1	Монгол Улсын Үндсэн хууль	<p>Тавдугаар зүйл.</p> <p>1.Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлог нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.</p> <p>2.Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.</p> <p>3.Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.</p> <p>4.Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.</p> <p>5.Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна.</p>
		<p>3.2."Үндэсний язгуур ашиг сонирхол"-д Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн</p>

2	Үндэсний аюулгүй байдлын тухай хууль	<p>засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана.</p> <p>3.4.Үндэсний аюулгүй байдал нь дараахь бүрэлдэхүүн хэсэгтэй байна:</p> <p>3.4.1.Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал;</p> <p>3.4.3.иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал;</p> <p>3.4.4.эдийн засгийн аюулгүй байдал;</p> <p>3.4.7.монгол соёл иргэншлийн аюулгүй байдал;</p> <p>3.4.9.экологийн аюулгүй байдал.</p> <p>3.4.10.хүнсний аюулгүй байдал.</p>
3	Хууль тогтоомжийн тухай хууль	<p>1.1.Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид "хууль тогтоомж" гэх/-ийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд оршино.</p> <p>2.1.1."хууль санаачлагч" гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийг;</p> <p>2.1.2."хууль санаачлах эрх" гэж Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хүрээ, хязгаарт нийцүүлэн энэ хуулийн 2.1.1-д заасан этгээдээс мэргэжлийн түвшинд боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг;</p> <p>2.1.3."хуулийн төсөл" гэж хууль санаачлагчаас энэ хуульд заасан шаардлагыг ханган боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн төслийн эх бичвэрийг;</p> <p>3.1.Энэ хууль нь хууль тогтоомжийг санаачлан боловсруулах, олон нийтийн оролцоог хангах, эрх зүйн дүгнэлт хийх, өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, олон нийтэд сурталчлах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт</p>

		<p>шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулна.</p> <p>4.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчмаас гадна дараах нийтлэг зарчмыг баримтална:</p> <p>4.1.1.ил тод, нээлттэй байх;</p> <p>4.1.2.олон нийтийн оролцоог хангах;</p> <p>4.1.3.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;</p> <p>4.1.4.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх.</p> <p>5.1.Хууль санаачлагч тодорхой хууль санаачлах бол Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хүрээ, хязгаарт нийцүүлэн, хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.</p> <p>8.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:</p> <p>8.1.1.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эсхүл энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх;</p> <p>8.1.2.энэ хуулийн 14, 15 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлах;</p> <p>8.1.3.энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийг боловсруулах;</p> <p>8.1.4.энэ хуулийн 17, 18 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх;</p> <p>8.1.5.эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах;</p>
--	--	--

		<p>8.1.6.хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах;</p>
4	Хөдөлмөрийн тухай хууль	<p>3.6.Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, нөхөрлөл, хоршооны гишүүн, дагалдан ба дадлагажигч зэрэг албан болон албан бус эдийн засагт ажиллаж, ажил хайж, мэргэжил эзэмшиж байгаа хүн бүр энэ хуулийн 5.1-д заасан үндсэн эрхийг эдэлж, холбогдох үүргийг хүлээнэ.</p> <p>34.2.Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, нөхөрлөл, хоршооны гишүүн, албан бус эдийн засагт ажиллаж байгаа хүний энэ хуулийн 5.1-д заасан үндсэн эрх, суурь зарчмыг хэрэгжүүлэх, тэдгээрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлыг тухайн нутаг дэвсгэрийн хамтын хэлэлцээрт тусгаж, хэрэгжүүлж болно.</p> <p>71 дүгээр зүйл.Туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээний онцлог</p> <p>71.1.Ажил олгогч нь туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтантай энэ хуульд заасан шаардлагад нийцсэн хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулна.</p> <p>71.2."Туслах малчин" гэж үндсэн малчны дэргэд амьдарч, түүний удирдлага, хяналтын доор мал маллах, мал аж ахуйтай холбоотой бусад ажил эрхэлж цалин хөлс авахаар харилцан тохиролцон ажиллаж байгаа хүнийг ойлгоно. Бусдын малыг бие даан хөлсөөр маллахтай холбогдсон харилцааг Иргэний хуулиар зохицуулна.</p> <p>71.3.Туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтан нь ажил олгогчийн гэрт, эсхүл ажил олгогчийн өмчлөлийн болон эзэмшлийн байранд нь амьдарч, ажиллах бол тэдгээрийг хэвийн амьдрах нөхцөлөөр хангах үүргийг ажил олгогч хүлээнэ.</p> <p>71.4.Ажил олгогч, түүний гэр бүлийн гишүүн нь туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтны нэр төр, эрх, хууль</p>

		<p>ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн харилцаж, аливаа ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас ангид ажлын байрны нөхцөлөөр хангах үүрэгтэй.</p> <p>71.5.Туслах малчны цалин хөлсийг энэ хуулийн 112 дугаар зүйлд заасны дагуу олгоно.</p> <p>71.6.Ажил олгогч туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтантай ажил үүргийн онцлогийг харгалзан ажил, амралтын цагийг энэ хуульд зааснаас өөрөөр харилцан тохиролцож болно. Ажил олгогч нь туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтныг долоо хоногт тасралтгүй 24 цагаас дээш хугацаагаар амрах, энэ хуульд заасны дагуу ээлжийн амралт олгох үүрэгтэй.</p> <p>71.9.Туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээний загварыг ажилтны болон ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагын саналыг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>71.10.Туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтан энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд холбогдох хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг нэгэн адил мөрдөнө.</p> <p>112 дугаар зүйл.Туслах малчны цалин хөлс</p> <p>112.1.Туслах малчин зөвшөөрсөн бол түүний цалин хөлсний 30-аас илүүгүй хувийг мөнгөн бус хэлбэрээр олгож болно.</p> <p>112.2.Энэ хуулийн 112.1-д заасан мөнгөн бус хэлбэрээр олгох цалин хөлс нь чанарын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн, мал, бусад эд хөрөнгө байж болох бөгөөд тэдгээрийн үнийг зах зээлийн дунджаас илүүгүй байхаар тооцно.</p> <p>112.3.Мөнгөн бус хэлбэрээр олгох цалин хөлсөнд тамхи, согтууруулах ундаа, бүх төрлийн эм, хуулиар хориглосон эд зүйл, бараа бүтээгдэхүүн, тусгай</p>
--	--	--

		зөвшөөрөлтэй худалдах бараа, бүтээгдэхүүн олгохыг хориглоно.
5	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль	<p>3.1.9."малчин" гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг;</p> <p>6.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг дараах төсөл, хөтөлбөрийн хэлбэрээр хэрэгжүүлнэ:</p> <p>6.3.3.малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих;</p> <p>7.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, ажил олгогч энэ хуульд заасны дагуу хамрагдана.</p> <p>12 дугаар зүйл.Малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих</p> <p>12.1.Малчин, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих арга хэмжээ нь иргэний ганцаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхлэх санаачилгыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулах, жижиг зээл, санхүүгийн дэмжлэг, бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх зэрэг арга хэрэгслээр дэмжин туслах хэлбэртэй байна.</p> <p>12.2.Малчин, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих зориулалттай жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох бөгөөд уг сангаас олгох жижиг зээлийг банкаар дамжуулан олгоно.</p>

		<p>12.4.Ажил олоход хүндрэлтэй иргэн материал, түүхий эд, үр, бордоо, мал, тэжээвэр амьтан, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл зэргийг худалдан авахад зориулж жижиг зээл авсан бол зээлийн хүүгийн төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нөхөн төлнө.</p> <p>12.5.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэ хуулийн 12.2-т заасны дагуу олгож байгаа зээлийн хүүгийн хэмжээ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мөнгөн хөрөнгийг байршуулсан банкны зээлийн хүүгийн доод түвшингээс бага байна.</p> <p>12.6.Энэ хуулийн 12.2-т заасны дагуу олгож байгаа жижиг зээлд батлан даалт гаргаж болно.</p> <p>12.7.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам, жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн хэмжээг Засгийн газар тогтооно.</p> <p>23.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг дор дурдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулна:</p> <p>23.1.7.малчин, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих;</p>
6	Малын генетик нөөцийн тухай хууль	<p>1.1.Энэ хуулийн зорилт нь мал болон ашиг шимийг нь ашигладаг тэжээвэр амьтан /цаашид "мал" гэх/-ны генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох, хадгалах, хамгаалах, тогтвортой ашиглах, судлан хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>8.2.Малын төрөл, ашиг шимийн чиглэл, үүлдэр, омгийн онцлогийг харгалзан сүргийн зохистой бүтэц, харьцааг хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгаж зохицуулна.</p> <p>8.3.Малын генетик нөөцийг ашиглахад малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээд дараахь эрх эдэлнэ:</p> <p>8.3.1.генетик нөөц ашигласны үр шимийг хүртэх;</p>

		<p>8.3.2.энэ хуулийн 11.2-т заасан үйлчилгээний нэгжийг сонгон мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ авах;</p> <p>8.3.3.энэ хуулийн 13.4-т заасан урамшуулал авах;</p> <p>8.3.4.баталгаажсан цөм сүргээс үржлийн мал бойжуулах, борлуулах;</p> <p>8.3.5.энэ хуулийн 13.2-т заасан бүс нутагт зөвшөөрөгдсөн малын төрөл, үүлдэр, омгоос хээлтүүлэгч сонгон үржилд ашиглах;</p> <p>8.3.6.бэлчээр, ус, хужир марааг зөв зохистой ашиглах.</p> <p>8.4.Малын генетик нөөцийг ашиглахад малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээд дараахь үүрэг хүлээнэ:</p> <p>8.4.1.тухайн бүс нутагт үржүүлэхийг зөвшөөрсөн үүлдэр, омгийн хээлтүүлэгчийг ашиглах, малыг сонгон үржүүлэхдээ ашиг шимийн чиглэлийг дур мэдэн өөрчлөхгүй, эрх бүхий мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөр үүлдрийн малыг сайжруулагчаар ашиглахгүй байх;</p> <p>8.4.2.үр, хөврөлийг энэ хуулийн 11.2-т заасан үйлчилгээний нэгжийн хяналтын доор ашиглах;</p> <p>8.4.4.мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний жишиг үнээр тогтоосон зардлыг хариуцах;</p> <p>8.4.5.мал сүрэгт үзлэг, ангилалтыг технологийн зохистой хугацаанд жил бүр хийлгэж, ашиг шимт чанарыг үнэлүүлэх, баталгаажуулах, үржлийн малын удам гарваль, ашиг шимийн бүртгэл хөтлөх, стандартын шаардлагад тэнцэхгүй хээлтүүлэгчийг үржлээс хасах;</p> <p>8.4.6.малын генетик нөөцийг тогтвортой ашиглахтай холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг биелүүлэх;</p> <p>8.4.7.үржлийн малын удам гарвалийн гэрчилгээ болон шилжилт хөдөлгөөний тодорхойлолтыг сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасгаас авах;</p>
--	--	--

	<p>12.1.Малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах үйл ажиллагаа дараахь хэлбэртэй байна:</p> <p>12.1.1.малыг өвөрмөц шинж байдлаа олж авсан, хадгалж ирсэн орчин зүйн бүрдэлд буюу уугуул орчинд;</p> <p>12.1.2.малыг уугуул орчноос нь шилжүүлж дасгасан орчин зүйн бүрдэлд буюу нутагшуулан;</p> <p>12.1.3.үржүүлгийн бүтээгдэхүүнийг эрх бүхий байгууллагаас баталсан стандартаар тогтоосон буюу тусгай орчинд.</p> <p>12.2.Монгол мал, тэдгээрээс гаралтай үүлдэр, омгийн малыг тухайн бүс нутагт цэврээр үржүүлж, уугуул орчинд хамгаална.</p> <p>12.3.Гадаад улсаас оруулж ирсэн болон үржлийн зориулалтаар нутаг шилжүүлсэн үүлдэр, омог, тэдгээрийг ашиглан бий болгосон үржлийн малыг энэ хуулийн 13.2-т заасан бүс нутагт нутагшуулан үржүүлж, хамгаална.</p> <p>13 дугаар зүйл.Мал хамгаалах</p> <p>13.1.Улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.</p> <p>13.4.Тоо, тархалтын хувьд доройтолд орсон, устаж мөхөж болзошгүй байдалд хүрсэн малын төрөл, зүйлийг тусгайлан хамгаалж, үржүүлэх арга хэмжээ авч, удам гарвал нь тодорхой, стандартын шаардлага хангасан өсвөр хээлтүүлэгч бойжуулж зах зээлд борлуулсан малчин, мал бүхий этгээд, энэ хуулийн 11.2-т заасан үйлчилгээний нэгжид Засгийн газраас дэмжлэг, урамшуулал олгож болох бөгөөд урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.</p> <p>13.7.Малын үүлдэр хамгаалах, ашиглах, хөгжүүлэх үүлдрийн нийгэмлэг байгуулах, зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн мах, сүү үйлдвэрлэлийн төрөлжсөн бүсэд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг Засгийн газраас дэмжинэ.</p>
--	---

7	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль	<p>1.1.Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4.1.1."мал" гэж уламжлагдан маллаж ирсэн таван хошуу малыг;</p> <p>4.1.2."тэжээвэр амьтан" гэж ашиг шимийг нь ашиглах болон бусад хэрэгцээнд зориулан гэршүүлэн үржүүлж байгаа амьтныг;</p> <p>4.1.14."малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасан иргэнийг;</p> <p>4.1.8."мал эмнэлгийн үйлчилгээ" гэж мал, амьтны болон нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр мал эмнэлгийн мэргэжлийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг;</p>
8.	Малын тоо толгойн албан татварын тухай хууль	<p>1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3.1.1. "мал" гэж Малын генетик нөөцийн тухай хуулийн 4.1.1-д заасныг;</p> <p>3.1.2."малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасныг;</p> <p>3.1.3."мал бүхий этгээд" гэж энэ хуулийн 3.1.2-т зааснаас бусад малыг өмчилж байгаа этгээдийг.</p> <p>4.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээд нь албан татвар төлөгч байна.</p> <p>5 дугаар зүйл.Албан татвар ногдуулах, малын тоо толгойг тодорхойлох</p>

		<p>5.1.Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна.</p> <p>5.2.Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно.</p> <p>5.3.Тухайн татварын жилд албан татвар ногдуулах энэ хуулийн 5.2-т зааснаар тодорхойлсон малын тоо толгой нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасан гамшгийн улмаас хорогдсон бол нотлох баримтыг үндэслэн түүнийг албан татвар ногдуулах нийт малын тооноос хасна.</p> <p>5.4.Албан татвар ногдуулах, малын тоо толгойг тодорхойлох зорилгоор холбогдох төрийн байгууллага, эрх бүхий этгээд мал тооллого, бүртгэлийн мэдээлэл, Малын генетик нөөцийн тухай хуулийн 5.8-д заасан сангийн мэдээллийг татварын албанд гаргаж өгнө.</p>
9	Төсвийн тухай хууль	<p>1.1.Энэ хуулийн зорилт нь төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>60.2.8.малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.</p>
10	Зөрчлийн тухай хууль	<p>1.Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах</p>

		<p>замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.</p> <p>13.4 дүгээр зүйл. Малын генетик нөөцийн тухай хууль зөрчих</p> <p>2. Малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээд нь:</p> <p>2.1. цөм сүргийн болон үржлийн малыг технологит хугацаанд үзлэг ангилалтад хамруулаагүй, ашиг шимт чанарыг үнэлүүлж, баталгаажуулаагүй;</p> <p>2.2. үр, хөврөлийг мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжийн хяналтын доор ашиглаагүй бол зөрчлийг арилгуулж, хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>3. Малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээд нь:</p> <p>3.1. эрх бүхий мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөр үүлдрийн мал, эсхүл стандартын шаардлагад тэнцэхгүй хээлтүүлэгчийг сайжруулагчаар ашигласан;</p> <p>3.2. тухайн бүс нутагт үржүүлэхийг зөвшөөрснөөс өөр үүлдэр, омгийн хээлтүүлэгчийг ашигласан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>4. Малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээд нь малыг дахин давтагдахгүй хувийн дугаараар ялган тэмдэглүүлэх, нэгдсэн бүртгэлд хамруулах үүргээ биелүүлээгүй бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>5. Тусгай зөвшөөрөлгүйгээр шинээр малын үүлдэр, омог бий болгох, үр, өндгөн эс, хөврөлийг үйлдвэрлэх, үйлчилгээнд нэвтрүүлэх, бичил биетнийг өсгөвөрлөх үйл ажиллагааг эрхэлсэн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>
11	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	<p>1. Энэ хуулийн зорилт нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, зөрчлийг шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.</p>

-----oOo-----

**“МАЛЧНЫ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ
ТАЙЛАН**

АГУУЛГА

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

**ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

**ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН
БАЙДАЛ**

**ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН НЬ**

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Малчны тухай хуулийн төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай¹ хуулийн 17 дугаар зүйлд заасан тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж, түүний үр нөлөөг тооцож, давхардал, зөрчил, хийдэл байгаа эсэхийг тогтоож арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар чиглэсэн зөвлөмжийг Хууль санаачлагчид хүргүүлэхэд энэхүү үнэлгээний ажлын зорилго нь оршино.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл² хэлбэрээр боловсруулагдсан байна.

Малчны тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлал”³-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх,
5. Зөвлөмж өгөх.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх дээрх үндсэн 5 шалгуур үзүүлэлтийн хүрээнд тэдгээрийг шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн зохицуулалтууд нь уг хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх, хуулийн төслийн зорилгод нийцсэн, түүнд хүрэх боломжтой байдлаар тусгагдсан эсэхэд дүн шинжилгээ хийсэн болно.

Мөн хуулийн төслийн зохицуулалтууд нь хүлээн зөвшөөрөгдөх боломжтой, өнөөгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаанд нийцсэн эсэх, хэм хэмжээнүүд ойлгомжтой байдлаар тусгагдсан эсэх талаар хуулийн төслийн зохицуулалтууд нь ойлгомжтой, харилцан уялдаатай байгаа эсэхийг дээр дурдсан аргачлалын дагуу асуултад хариулах байдлаар дүгнэсэн бөгөөд гарсан үр дүнд үндэслэн анхаарах асуудлын талаар хууль санаачлагчид зөвлөмж өгөхөд дөхөмтэй гэж дүгнэж байна.

Энэхүү үнэлгээг хийснээр Малчны тухай хуулийн төсөл батлагдсанаар уламжлал, өв соёлыг хамгаалж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх малчны эрх зүйн үндсийг тодорхойлох, малчны хөгжил, бүтээмж, хариуцлагатай байдал, хамтын санаачилга, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг дэмжин хэрэгжүүлэх тогтолцоо, эрх хэмжээ, чиг үүрэг, бүртгэл, хяналттай холбоотой

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

² Төрийн мэдээлэл эмхэтгэл.2015.№25

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11993>

харилцааны зохистой түвшинд хүргэх үр нөлөөтэй, давхардал, зөрчилгүй байдлаар боловсруулагдсан эсэхэд хариулт өгсөн болно.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах харилцаа, онцлогтой уялдуулан Аргачлалын 2.9-д⁴ заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг тухайлан сонгох болсон үндэслэл нь уг хуулийн төслийн зорилт болон зохицуулах харилцааны онцлогтой холбоотой.

2.1.Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл, түүний зорилго нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгын хүрээнд боловсруулагдсан эсэх болон хууль зүйн болон практикийн үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт, арга хэмжээнүүд нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэх, хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэлэх шаардлагатай гэж дүгнэв. Энэхүү үнэлгээг гүйцэтгэхдээ хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөлтэй танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан.

2.2.Практикт хэрэгжих боломж:

Хуулийн төсөлд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч малчинтай холбоотой харилцаанд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, баримтлах зарчим, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүргийг нарийвчлан тусгасан зохицуулалт нь хуулиар хэрэгжих боломжтой эсэхийг тодруулах шаардлагыг харгалзан тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

2.3.Ойлгомжтой байдал:

Хуулийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн боловсруулалт, зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдэд ойлгомжтой, логик дараалалтайгаар томъёологдсон эсэхийг шалгах үүднээс тус хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн

⁴ Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9 "... хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно".

тухай хуулийн 23, 26, 29, 30 дүгээр зүйл⁵ болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах зорилгоор хуулийн төслийг бүхэлд нь сонгож үнэлсэн.

2.4.Харилцан уялдаа:

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг⁶ хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилгүй байх тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгасан. Энэ хүрээнд тус хуулийн төсөл нь бүхэлдээ Үндсэн хууль болон холбогдох бусад хуулийн зохицуулалтад нийцэж байгаа эсэхийг Аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийв.

Малчны тухай хуулийн төслийн үзэл баримтлал, төслийн зорилт, зохицуулалтаас үзэхэд малчин хүний эрхэлж байгаа мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвээр хадгалагдахаар байгаа тул хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд хамрагдах этгээд хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий **“хүлээн зөвшөөрөгдөх байдал”** шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

Мөн дээрх үндэслэлээс гадна тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийсэн тул **“зардал тооцох”** шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоов.

Хүснэгт 1. Үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон нь

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 5, 6, 7, 8, 10, 11, 12, 15, 16, 17, 19 дугаар зүйл	Хуулийн зохицуулалтад хамрагдах этгээдийн төлөөлөлтэй ярилцлага зохион байгуулах, статистик мэдээ,

⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawid=11119>

⁶ Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл.

			хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН НЬ

Аргачлалын 4.1-д “энэ үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлнэ.” гэж, мөн аргачлалын 4.4-д “Шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн үр нөлөөг яаж үнэлэхийг тогтооно” гэж тус тус заасныг хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний энэ хэсэгт мөрдөж ажиллав.

Хөдөө аж ахуйн ерөнхий хуулийн төслийн үр нөлөөг үнэлгээний өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлт, түүнд ашиглахаар тогтоосон шалгах хэрэгслийн дагуу дараах байдлаар үнэлж байна.

3.1.Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Малчны тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийсэн. Энэ хүрээнд Малчны тухай хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийв.

Малчны тухай хуулийн төслийн үзэл баримтлал⁷-д төрийн бодлогын хүрээнд үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал, эдийн засгийн болон экологийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа малчдын нийгмийн харилцаанд оролцох эрх зүйн байдлыг тодорхой болгох, хүний эрхийн зарим баталгааг нь хуулиар хамгаалах эрх зүйн таатай орчин зайлшгүй шаардлагатай байна. Түүнчлэн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн “нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан улс орон байх” зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд манай улсын өргөн уудам нутаг, хил хязгаар болон нүүдэлчин ахуй, соёлыг үеэс үед өвлөн

⁷ Малчны тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2024 он

хадгалж, хамгаалж байгаа уугуул иргэд болох малчид, малчин өрхийн талаар төрөөс баримтлах бодлогод онцгой анхаарч, тэдгээрийн нийгмийн баталгаа, амьжиргааны нөхцөлийг сайжруулах, нүүдлийн ахуй уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлээ тогтвортой эрхлэх, хөгжих таатай боломжийг бүрдүүлэх Малчны тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж үзжээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн⁸ бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл уламжлал, өв соёлыг хамгаалж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх малчны эрх зүйн үндсийг тодорхойлох, малчны хөгжил, бүтээмж, хариуцлагатай байдал, хамтын санаачилга, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэхтэй холбогдох харилцааг бие даасан хуулиар нарийвчлан зохицуулснаар Монгол Улсад бэлчээрийн мал аж ахуйг тогтвортой эрхлэх, хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд хуулийн төслийн үндсэн зорилт оршиж байна. Энэ зорилтын хүрээнд зарчмын шинжтэй зорилтуудыг дэвшүүлж, тэдгээрийн биелэлтийг хангах үүднээс малчид, тэдгээрийн эрхлэх тогтвортой үйлдвэрлэл, хөгжлийг дэмжих харилцааг нарийвчлан зохицуулсан эрх зүйн орчныг бий болгох бие даасан хууль батлах хувилбарыг сонгожээ. Иймд Малчны тухай хуулийн төслийн хүрээнд эдгээр асуудлыг шийдвэрлэсэн эсэх, сонгож авсан шийдлийн зорилгод хүрэх байдлыг үнэлэх нь зүйтэй гэж үзлээ.

Ингэхдээ хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан бие даасан хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх, хуулийг батлан хэрэгжүүлснээр зорилгодоо хүрэх боломжтой байдлаар томъёологдсон эсэхийг дараах агуулгын хүрээнд дүн шинжилгээ хийв.

Нэг.Мал аж ахуйн төрийн тогтвортой эрхлэх талаар:

5 дугаар зүйл.Малчныг дэмжих төрийн бодлого
10 дугаар зүйл.Малчны бүтээмжийг дэмжих
13 дугаар зүйл.Малчин өрх, тэдгээрийн бүлэгт газар эдэлбэрийн эрхийг баталгаажуулах
14 дугаар зүйл.Малчны оролцоотой байгалийн нөөцийн сэргэх чадавхыг бэхжүүлэх

Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эрхэм зорилгод “үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэж, өөрийгөө тэтгэсэн эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн, улс болж хөгжинө.” гэж, зорилт 1.2.-д “үндэсний өв соёл, нүүдлийн ахуйг уламжлал, шинэчлэлтэй хослуулсан тэргүүлэх улс болж, нүүдлийн соёл иргэншлийг хадгалах, хамгаалахад чиглэсэн төрөлжсөн байгууллагуудтай болно”, зорилго 8.3-д “хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ”, “нүүдлийн уламжлалт өв соёлыг хадгалсан, экологид ээлтэй, органик мал аж ахуйг тогтвортой эрхлэх, хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн тогтвор суурьшилтай ажиллаж, ая тухтай амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг

⁸ Малчны тухай хуулийн төсөл, 2024 он

сайжруулна” гэж тусгасан нь Монгол Улсын байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, шаардлагыг үндэслэн мал аж ахуйг тэргүүн ээлжид хөгжүүлэх агуулга бүхий төрийн бодлого мөн.

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл -ийн зорилт 1.2-д “нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлсэнд үндэслэн нүүдлийн өв соёл, ёс заншил, уламжлалаа хадгалж байгаа малчны эрх зүйн байдлыг тодорхойлж, нүүдлийн ахуй мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эхлэх, хөгжүүлэх үзэл баримтлалтай хэм хэмжээг тогтоохоор тусгасан нь хуулийн төслийн зорилгод төрийн бодлого, зорилтод нийцсэн байна гэж дүгнэв.

Хоёр. Малчны эрх зүйн үндсийг тодорхойлох

Хуулийн төслийн:

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

Хуулийн төслийн “Нэгдүгээр бүлгийн 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт”-д “мал аж ахуй, малчин, хот айл, мал аж ахуйн зохистой дадал, малчны хөгжил” зэрэг нэр томьёог шинээр тус тус тодорхойлон, малчны эрх зүйн байдлыг нарийвчлан тогтоожээ. Хуулийн төсөлд тусгасан дээрх зохицуулалт нь малчны эрх зүйн үндсийг хуулиар нарийвчлан тодорхойлох, хуулийн үзэл баримтлал, хуулийн зорилтыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлжээ.

Гурав.Малчны хөгжлийн талаар:

Хуулийн төслийн:

7 дугаар зүйл.Малчны мэдлэгийг дээшлүүлэх тогтолцоо, зарчим

8 дугаар зүйл.Малчны хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөр

9 дүгээр зүйл.Малчны үйл ажиллагаанд цахим шилжилтийг нэвтрүүлэх

Дөрөв.Малчны хариуцлагатай байдлыг тодорхойлох талаар:

Хуулийн төслийн:

6 дугаар зүйл.Малчны эрх, үүрэг

Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлгийн 10 дугаар зүйлд малчны бүтээмжийн талаар тусгасан нь хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийн зорилтыг хангахад нийцсэн байна.

Тав.Малчны хамтын санаачилга, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэх талаар:

5 дугаар зүйл.Малчныг дэмжих төрийн бодлого

11 дүгээр зүйл. Малчны хамтын санаачилга, хоршил, кластерын үйл ажиллагаа

12 дугаар зүйл. Малчны өөрөө удирдах байгууллагын тогтолцоо

16 дугаар зүйл. Малчинд үзүүлэх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ

17 дугаар зүйл. Малчны хөрөнгө оруулалт, эдийн засгийн чадамжийг сайжруулах

Хуулийн төслийн “Тавдугаар бүлэг. Малчны хамтын санаачилгыг дэмжих”-т малчны өрсөлдөх чадвар, нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмрийг бэхжүүлэх, малчны хамтын санаачилга, хоршил, кластерын үйл ажиллагаа, малчны өөрөө удирдах байгууллагын тогтолцоо, малчинд үзүүлэх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, малчны хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх эдийн засгийн чадамжийг сайжруулах, малчны нийгмийн баталгаа, ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, алслагдсан бүс нутгийн болон хариуцлагатай нүүдэлчин малчинд төрөөс үзүүлэх дэмжлэгийн талаар нарийвчлан тодорхойлсноор “малчны хамтын санаачилга, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэх” гэсэн хуулийн зорилтын хэрэгжилтийг хангахад нийцсэн зохицуулалтууд тусгажээ.

Хуулийн төслийн эдгээр зохицуулалт нь Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 2.3.-д “гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ”, зорилт 2.6-д “хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ”, зорилго 3-д “хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг бүрдүүлнэ”, зорилт 3.3.5-д “малчин өрхийн аж ахуй эрхлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, малчин өрхийн бэлтгэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх оновчтой тогтолцоог бий болгох” гэж, УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр -ийн зорилт 4.4-д “эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг ханган, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.” гэж заасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд томоохон дэмжлэг болохоор байна. Ялангуяа нийгэм, эдийн засгийн харилцаанд малчны оролцоог нэмэгдүүлэх, малчин хүний нөөц боломжийг нээж, малчдын дунд сайн дурын санаачилга, хоршил, нэгдэлд суурилсан тэгш эрх, нээлттэй тогтолцоог бүрдүүлэх, өрсөлдөөнийг хөгжүүлэх, харилцан туршлага, мэдээллээ солилцох, үйл ажиллагааны үр өгөөж, чанарыг сайжруулахад чиглэсэн харилцааг тодорхой болгож өгсөн байна. Хуулийн төслийн 12.2-д “Малчны өөрөө удирдах байгууллагын тогтолцоо нь багийн түвшинд малчны бүлэг, хэсэг, нөхөрлөл, сум, аймгийн түвшинд холбоо, үндэсний хэмжээнд иргэний нийгмийн байгууллагын нэгдсэн холбоо гэсэн шаталсан хэлбэрээр зохин байгуулагдаж, үйл ажиллагаа явуулна.” гэж заагаад, тэдгээрийн эрх, чиг үүргийг хуульчлахаар заажээ.

Мөн малчдын байгальд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааг санхүүгийн механизмаар дамжуулан дэмжихээр зохицуулалт тусгасан нь хуулийн төслийн зорилтын хэрэгжилтийг хангахад чухал түлхэц болно гэж үзэж байна. Хуулийн төслийн 16.2-д “Арилжааны банкинд малчинд зориулсан нэн хөнгөлөлттэй, хөнгөлөлттэй зээлийн болон даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний шинэ нэр төрлийг нэмэгдүүлж малчин үйлдвэрлэлдээ чанарын өөрчлөлт гаргах, байгальд ээлтэй, тогтвортой үйл ажиллагаа эрхлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.” гэж тусгасан байна. Малчин нь эрхэлж байгаа үйлдвэрлэлийн үйл ажиллагааны цар хүрээгээс хамаарч нэн хөнгөлөлттэй, хөнгөлөлттэй зээлийн болон даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ авахаар зааг, ялгааг гаргаж өгсөн нь “малчин бол малчин”

гэсэн нийгэм, эдийн засгийн нийтлэг хандлагыг өөрчлөх, малчныг нийгэм, эдийн засгийн харилцаанд оролцох, аж ахуйгаа үр ашигтай эрхлэх хариуцлагыг мэдрүүлэх ач холбогдолтой зохицуулалт болсон байна. Гэхдээ хуулийн төслийн "17 дугаар зүйл. Малчны хөрөнгө оруулалт, эдийн засгийн чадамжийг сайжруулах"-ийн 17.1 дэх хэсэгт "Мал аж ахуйн үйлдвэрлэлийн одоогийн болон ирээдүйн хөгжлийг дэмжихэд зориулан сум бүрд Малчны хөгжлийн санг байгуулна." гэж, мөн зүйлийн 17.2-т уг санг бүрдүүлэх эх үүсвэрийг зааж, төслийн 17.3, 17.4 дэх хэсэгт сангийн төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах үйл ажиллагааны чиглэлийг хувь тогтоон зааж хуульчилж байгаа нь санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас санал авах, Төсвийн тухай хуулийн холбогдох зохицуулалттай уялдуулах зэргээр нарийвчлан судлах зохицуулалт гэж дүгнэв.

3.2. Практикт хэрэгжих боломжтой эсэх:

Хуулийн төслийн 19, 20, 21 дүгээр зүйлд заасан зохицуулалтуудыг "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд хэрэгжих боломжтой эсэх, хэрэгжүүлэгч субъектүүдэд ачаалал, бэрхшээл учруулах эсэх, учирч болох эрсдэлийг буруулах арга зам байгаа эсэхийг тодруулахыг зорилгоор малчин, мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр өмнө нь хийгдсэн судалгаанууд, улс, бүс, аймгийн түвшинд зохион байгуулагдсан малчдын зөвлөгөөн, хурал дээр гарсан санал, шүүмжүүд, холбогдох статистик мэдээ, мэдээлэл хуулийн төсөлд ирүүлсэн санал зэрэгт дүн шинжилгээ хийх замаар шалгасан болно.

• Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн зохицуулалт:

Энэ зүйл, заалтаар мал сүргээ идээшлүүлэх зориулалтаар өвөлжөө, хаваржааны болон зуслан, намаржааны бэлчээрийн эдэлбэр газрыг улирлын онцлогтой уялдуулан орон нутгийн бэлчээр ашиглалтын журмын дагуу хязгаарлалттай хүрээнд хамтын оролцоонд тулгуурласан малчны бүлэгт гэрээгээр ашиглуулах зохицуулалтыг тусгажээ. Түүнчлэн малчны бүлэг нь гэрээгээр ашиглуулах бэлчээрийн эдэлбэр газарт эрх ашиг нь хөндөгдөх бусад малчин өрх, малчны бүлгээс зөвшөөрөл авч, гэрээгээр ашиглуулах бэлчээрийн эдэлбэр газарт малчны бүлэг ашиглалт, хариуцлагын гэрээг сумын Засаг даргатай байгуулж, ашиглуулах эрхийг авах, бэлчээрийн эдэлбэр газрыг ашиглах эрхээ баталгаажуулсан малчны бүлэг нь хязгаар тогтоосон хүрээнд мал сүргээ идээшлүүлж, гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хамгаалах үйл ажиллагааг хариуцах зэргээр хуулийн төсөлд энэ зүйл заалтаар бэлчээрийн газар ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг тодорхой болгосон байгаа зэрэг нь нэг талаас практикт тулгамдсан асуудлыг эрх зүйн хүрээнд шийдэх гарцыг тодорхойлсон ч нөгөө төлөөс Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх нь илүү нийцэлтэй гэж үзэж байна.

▪ Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн зохицуулалт:

Хуулийн төслийн энэ зүйлийн зохицуулалтаар малчны оролцоотой байгалийн нөөцийн сэргэх чадавхыг бэхжүүлэх харилцааг зохицуулахаар тусгаж, бэлчээрийн төлөв байдал, чанарын өөрчлөлтийн явцыг хянах, өөрчлөлтийг цаг тухайд нь

илрүүлэх, үнэлэлт, дүгнэлт өгөх үйл ажиллагааг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бэлчээрийн үнэлгээнд суурилан явуулах, үр дүнгийн мэдээлэл, зураглалыг ашиглан холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан, малчны өөрөө удирдах байгууллага, малчны бүлэг, нөхөрлөл тус бүр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон нь одоо хэдийнээ хэрэгжүүлээд эхэлсэн, практикт бүрэн хэрэгжих боломжтой зохицуулалт гэж үзэж байна.

▪ Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн зохицуулалт:

Энэ зүйлийн зохицуулалтад уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн нөлөөллийг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг сум, аймаг бүр боловсруулж, хэрэгжүүлэх, малчин, малчны бүлэг, нөхөрлөл нь учирч болзошгүй гэнэтийн аюул, эрсдэлээс хамгаалахад зориулсан хуримтлал үүсгэж, дундын сан байгуулах боломжийг эрх зүйн хүрээнд нээлттэй болгосон байна. Цаг хүндэрсэн үед ашиглах отрын бүсэд мал оруулах, гаргах харилцааг журмаар зохицуулахаар зааж, журмыг батлах эрх бүхий субъектийг тогтоосон нь практикт бүрэн хэрэгжих боломжтой харилцаа бөгөөд зарим аймаг, сум хэрэгжүүлэх эхлэлийг тавьсан байна.

Дээрх байдлаар хуулийн төслийн зохицуулалтын практикт хэрэгжих боломжийг тус бүрээр нягталж, төсөлд тусгасан холбогдох харилцаа нь практикт нийцэх боломжтой гэж дүгнэж байна

3.3.Ойлгомжтой эсэх:

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Малчны тухай хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ. Мөн хуулийн төслийг ойлгомжтой болгох чиглэлээр Төрийн ордонд хийсэн хэлэлцүүлгийн үед гарсан санал болон бусад иргэд, малчид мэргэжлийн ба иргэний нийгмийн байгууллагаас өмнө нь хийсэн судалгаа, ирүүлсэн санал байгаа эсэхийг нягталж, анализ хийсэн болно.

Малчны тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан анхдагч хуулийн төслийн хэлбэрээр бичигдсэн 6 бүлэг, 27 зүйлтэй байна. Хуулийн төслийн бүтцийн дугаарлалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7-д заасан хуульд заасан шаардлагыг хангасан байна. Түүнчлэн хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх, үүнд хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх, 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгын ерөнхий шаардлагад нийцсэн байна. Малчны тухай хуулийн төслийг дагалдан боловсруулсан Малын генетик нөөцийн тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсэгт заасан дугаарлалт болон хуулийн төслийн заалтын байршилд тавигдах шаардлагыг хангасан байна.

3.4.Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн уялдаа холбоог шалгахдаа хуулийн төслийг бүхэлд нь авч үзэн, Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10 дах заалт болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангах эсэхийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар дараах байдлаар үнэлэв.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:

Д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна.
2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зарчмын томоохон зөрчил байхгүй байна.
3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	Энэхүү хуулийн төсөлд зүйл, заалт хооронд эшлэл хэрэглэсэн байна. Иймд хуулийн төслийн зохицуулалтын өөрчлөлт, засварыг харгалзан, эшлэлийг нягтлах нь зүйтэй.
4	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх	Тус хуулийн төслийг дагаж 2 хуульд нэмэлт, 4 хуульд өөрчлөлт оруулах, нийт 6 хуулийн төслийг боловсруулсан байна.

Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

Д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.

2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Дүн шинжилгээний хүрээнд зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал илрээгүй бөгөөд тодруулах, нэмэлт хийх шаардлагатай зохицуулалт байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй	Энэхүү шаардлагыг хангасан байна.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй	Хуулийн төсөлд оруулах шаардлагатай орхигдуулсан зохицуулалт байхгүй байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	-	Энэхүү зохицуулалтыг нарийвчлан тодорхой зарчмыг тогтоосон байна.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний	Үгүй	Хуулийн төсөлд тусгасан хязгаарлалт нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, хуульд заасан зайлшгүй бөгөөд хүний

11	эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх		хууль ёсны ашиг сонирхлыг хуулиас гадуур хөндөхгүй байх нөхцөлийг тусгасан байна.
12	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
13	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хуулийн төсөлд ийм заалт тусгагдаагүй байна.
14	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хяналтаар хуулийн төсөлд энэ төрлийн зөрчил илрээгүй. Тус төслийн зохицуулалт нь өмнөх эрх зүйн зохицуулалтын хүрээнд байсан тодорхойгүй, мэдээлэл, санхүүжилтийн нууцлагдмал байдлыг өөрчлөн, сайжруулсан давуу талтай хэмээн дүгнэж байна.
15	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Үгүй	Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон энэ хуулиар зохицуулахаар тусгасан байна.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Малчны тухай хуулийн төслийн үр нөлөөг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын дагуу шалгах хэрэгслийг ашиглан үнэлж, үр нөлөөг үнэлэх явцад цуглуулж, ашигласан мэдээлэл тоо баримт, хуулийн төслийн тандан судалгааны тайлан, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, энэ чиглэлээр холбоотой гарсан дүгнэлт, зөвлөмж, саналыг судлах, дүн шинжилгээ хийх зэргээр үр дүнг баримтжуулсны үндсэн дээр дараах Дүгнэлт, зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна.

5.1.Дүгнэлт:

1. "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд Малчны тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйлд болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр хуулийн хоёрдугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан хуулийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагад нийцсэн байдлаар боловсруулагдсан байна.
2. Хуулийн төслийн зорилт нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагын үндэслэлийг бүрэн илэрхийлэх түвшинд томъёологдсон, үзэл баримтлалд тусгасан зорилтуудыг хангахад чиглэсэн, тодорхойлсон зорилтод хүрэх боломжтойгоор илэрхийлэгдсэн зохицуулалтыг тусгасан байна гэж үзэв.
3. Хуулийн төсөлд нүүдлийн ахуй уламжлал, өв соёлыг хамгаалж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх малчны эрх зүйн үндсийг тодорхойлон, малчны хөгжил, бүтээмж, хариуцлагатай байдал, нийгмийн хамгаалал, хамтын санаачилга, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэх менежментийг боловсронгуй болох нөхцөлийг бүрдүүлсэн, практикт хэрэгжих боломжийг хангасан байна.
4. Хуулийн төслийн бүлэг, зүйл, заалт, дэд заалт өөр хоорондоо зөрчилгүй, Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой харилцан уялдсан, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.
5. Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д хуульчилсан "Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна" гэсэн хэм хэмжээг зөрчөөгүй байна гэсэн нэгдсэн дүгнэлт хийв.

5.2.3. Зөвлөмж:

1. Малчны тухай хуулийн төсөлд туссан бэлчээрийн газар, отрын бүс нутгийн ашиглалттай холбоотой зарим зохицуулалтыг Газрын тухай хуультай уялдуулахад илүү анхаарах нь зүйтэй.
2. Малчны санаачилгаар хуримтлалын сан үүсгэх, төвлөрүүлсэн орлогоос зарцуулалт хийх асуудлыг санхүү, хөрөнгө оруулалтын холбогдох хууль тогтоомжтой уялдуулан нягталж үзэх нь зохистой гэж зөвлөж байна.
3. Малчны тухай хуулийн төслийг дагалдан нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

---oOo---

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Малчны тухай хуулийн төсөл. 2024 он.
2. Малчны тухай хуулийн төсөл үзэл баримтлал, 2024 он.
3. Малчны тухай хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд. 2024 он
4. Малчны тухай хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн санал. 2024 он.
5. Малчны тухай хуулийн төслийн тандан судалгааны тайлан.2024 он.
6. Улс, бүс, аймгийн түвшинд зохион байгуулсан малчдын зарим зөвлөгөөн, хурлын тэмдэглэл, шийдвэр

Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, тушаалын жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Хууль тогтоомжийн тухай хууль;
3. Хөдөлмөрийн тухай хууль;
4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль;
5. Малын генетик нөөцийн тухай хууль;
6. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль;
7. Малын тоо толгойн албан татварын тухай хууль;
8. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль;
9. Төсвийн тухай хууль;
10. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
11. Зөрчлийн тухай хууль;
12. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль;
13. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”
14. Төрийн мэдээлэл эмхэтгэл.2015.№25

---000---

“МАЛЧНЫ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Удиртгал

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Малчны тухай хууль батлагдсанаар үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу урьдчилсан байдлаар тооцлоо.

ИРГЭНИЙ ҮҮСЭХ ЗАРДАЛ.

Малчны тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэн, малчдад санхүүгийн нөлөөлөл үүсэхгүй. Иргэнд төрийн үйлчилгээ авах төлбөр, хураамж гарахгүй.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДАЛ.

Малчны тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд санхүүгийн нөлөөлөл үүсэхгүй. Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны хувьд нэмэлт орон тоо гарах, шинэ ажлын байрны шаардлагагүй, нэмэлт зардал гарахгүй.

УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Малчны тухай хуулийн төсөлд дараах төсөвтэй холбогдолтой заалт орсон. Үүнд:

1. Малчин өрхийг 4 жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулах;

Дээрх зохицуулалтын хувьд дараах зардлын тооцооны таамаглал гарч байна. Манай улсын хувьд улсын хэмжээнд нийт 298.338 малчин бүртгэлтэй байна.¹ Үүнээс 30 орчим хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна.²

2024 оны малчны эрүүл мэндийн даатгалд хамрагдах таамаглал

	Нийт малчин		Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан	
			Хамрагдсан	Хамрагдаагүй
1	298.338	Хувь	30	70
		Тоо	89.501	208.836

¹https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1001_022V1&BAG_select_all=0&BAGSingleSelect=0&YearY_select_all=0&YearYSingleSelect=2023&viewtype=table 2024 оны байдлаар.

² Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хараат бус судалгааны хүрээлэн болон Маастрихтын их сургууль 2022. ISBN: 9789220371954 (веб PDF)

Уг тоон судалгаанаас авч үзвэл 208.836 орчин малчны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний зардлыг улсын төсөвт тусгах шаардлагатай.

Малчдыг насны бүлгээр авч үзвэл 6.3 хувь нь 15-24 насныхан, 20.6 хувь нь 25-34 насныхан, 28.4 хувь нь 35-44 насныхан, 25.4 хувь нь 45-54 насныхан, 19.3 хувь нь 55, түүнээс дээш насныхан байна.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчдыг насны бүлгээр авч үзвэл 9.0 хувь нь 15-24 насныхан, 8.0 хувь нь 25-29 насныхан, 10.5 хувь нь 30-34 насныхан, 14.6 хувь нь 35-39 насныхан, 19.6 хувь нь 40-44 насныхан, 21.6 хувь нь 45-49 насныхан, 12.6 хувь нь 50-54 насныхан, 4.1 хувь нь 55, түүнээс дээш насныхан байна. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчдыг насны бүлгийн хувьд жигд тархалттай байна.

Малчдын насны бүлэгт харьцуулж үзвэл 15-24 насны малчдын 31.1 хувь нь, 25-29 насны малчдын 18.7 хувь нь, 30-34 насны малчдын 20.2 хувь нь, 35-39 насны малчдын 23.9 хувь нь, 40-44 насны малчдын 28.4 хувь нь, 45-49 насны малчдын 33.0 хувь нь, 50-54 насны малчдын 24.5 хувь нь, 55, түүнээс дээш насны малчдын 12.3 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна.³

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн багц, төлбөрийн хэмжээ⁴

	Хамрагдах нас	Төлбөрийн хэмжээ
1	18-30	90.000 төгрөг
2	31-45	190.000 төгрөг
3	46-60	200.000 төгрөг
4	61-ээс дээш	180.000 төгрөг

Малчин иргэдийн эрүүл мэндийн даатгалын хамрагдалт мэдээ (2024 оны 01 дүгээр улирал)

дд	Аймгийн нэр	Малчин		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хамрагдалтын хувь
1	Архангай	12,611	2208	18%
2	Баян-Өлгий	6,417	474	7%
3	Баянхонгор	10,507	1274	12%
4	Булган	7,036	1408	20%
5	Говь-Алтай	5,766	999	17%

³ Малчдын орлого, хөдөлмөр эрхлэлтийн судалгаа. 2023 он.

⁴ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 10 дугаар “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай” тогтоолын нэгдүгээр хавсралт “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам”

6	Дорноговь	3,297	683	21%
7	Дорнод	3,499	843	24%
8	Дундговь	5,852	944	16%
9	Завхан	7,075	1166	16%
10	Өвөрхангай	13,293	1947	15%
11	Өмнөговь	4,774	669	14%
12	Сүхбаатар	7,525	870	12%
13	Сэлэнгэ	3,864	746	19%
14	Төв	9,230	1315	14%
15	Увс	7,600	1092	14%
16	Ховд	6,628	1207	18%
17	Хөвсгөл	15,436	2086	14%
18	Хэнтий	6,031	1139	19%
19	Дархан-Уул	624	182	29%
20	Орхон	571	102	18%
21	Говьсүмбэр	511	123	24%
Аймгийн дүн		138,147	21,477	16%
22	Багануур	468	99	21%
23	Налайх	346	36	10%
24	Улаанбаатар	1,609	374	23%
Нийслэлийн дүн		2,423	509	21%
Бүгд		140,570	21,986	16%

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн багц хамрагдах зардлын таамаглал тооцоо

	Малчны нас, хувь	Малчны тоо	Төлбөрийн хэмжээ төгрөг	Нийт төлбөрийн хэмжээ
1	18-30 насны 25 хувь	35,142	3,162,780,000	23,657,772,000 төгрөг
2	31-45 насны 28 хувь	39,359	7,478,210,000	
3	46-60 насны 40 хувь	56,228	11,245,600,000	
4	61-дээш насны 7 хувь	9839	1,771,182,000	
Нийт: 140,570 малчин			23,657,772,000	

Тус гарах зардал нь 2 жилд нэг удаа байх тул тухайн үеийн үнэлгээнээс хамаарч өөрчлөгдөх боломжтой. Мөн дээрх тооцооллоос жирэмсэн, 0-2 насны хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадваргүй иргэдийн тоо хасагдан тооцогдоно.

2. Малчдыг чадавхжуулах, залгамж халааг бэлтгэх үүднээс малчин өрхийн нэг хүүхэд нь мал аж ахуйн чиглэлийн мэргэжлээр суралцаж буй тохиолдолд тухайн оюутны сургалтын төлбөрийг төрөөс даана;

Улсын хэмжээнд 2023 оны байдлаар 247.873 малчин өрх байна.⁵ Үүнээс магадлалын хувьд мал аж ахуйн чиглэлээр суралцах оюутны тоо, төлбөрийг харьцуулан тооцно.

**Хөдөө аж ахуйн чиглэлээр их, дээд сургуульд суралцагчдын тоо
(2023 оны байдлаар)**

	Үзүүлэлт	Үзүүлэлт	2023
1	Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлэг	Бакалавр	1,248
2	Хөдөө аж ахуй	Бакалавр	345
Нийт: 1593 оюутан			

**Мал аж ахуйн чиглэлийн дээд боловсролын сургалтын төлбөр
(Хөдөө аж ахуйн сургууль)**

Мал аж ахуйн чиглэлийн дээд боловсрол	Курс	Төлбөр
	1	4,116,000 төгрөг
2	4,743,900 төгрөг	
3	4,260,900 төгрөг	
4	4,151,700 төгрөг	
5	2,305,800 төгрөг	

Мал аж ахуйн чиглэлээр суралцах малчин өрхийн хүүхдийн сургалтын төлбөрийн таамаглал тооцоолол

	Суралцагч оюутны тоо	Төлбөр	Нийт
1	100	4,116,000 төгрөг	411,600,000 төгрөг
2	300	4,116,000 төгрөг	1,284,800,000 төгрөг
3	500	4,116,000 төгрөг	2,058,000,000 төгрөг
4	800	4,116,000 төгрөг	3,292,800,000 төгрөг
5	1000	4,116,000 төгрөг	4,116,000,000 төгрөг

Малчин өрхийн хүүхэд бүр мал аж ахуйн чиглэлээр суралцах эсэх нь тодорхойгүй байх тул тус чиглэлээр хэдэн оюутан суралцах талаар санамсаргүй тоон дүнгээр тооцож сургалтын төлбөрийн дунджаар тооцоолсон болно.

⁵https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSQ_1001_044V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=t1&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=0&YearY_select_all=0&YearYSingleSelect=2023_2022&viewtype=table

3. Байгалийн гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас малчин нь ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд түүний ар гэрт нэг удаагийн буцалтгүй тусламж олгох.

Буцалтгүй тусламж олгох талаар хуульд заасан зохицуулалтын хувьд тус бүр өөр байх бөгөөд төрийн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэх явцад амь насаа алдсан тохиолдолд нэг удаагийн буцалтгүй тусламжийг жишиг болгон тооцоолсон болно.

Төрийн албан тушаалтанд олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн хувь, хэмжээ

	Албан тушаал	Цалин
1	Гаалийн улсын байцаагч	3 жилийн цалинтай тэнцэх хэмжээ
2	Онцгой байдлын албан хаагч	10 жилийн цалинтай тэнцэх хэмжээ
3	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дураар оролцсон иргэн	ахлагчийн албан тушаалын зэрэглэлийн анхны шатлалын үндсэн цалингаар тооцон 5 жилийн цалинтай тэнцэх хэмжээ
4	Дипломат албан ажилтан	4 жилийн цалинтай тэнцэх хэмжээ
5	Улсын Их Хурлын гишүүн	24 сарын цалинтай тэнцэх хэмжээ
6	Улсын хилд албан үүрэг гүйцэтгэж буй иргэн	5 жилийн цалинтай тэнцэх хэмжээ
7	Шүүгч	15 жилийн цалинтай тэнцэх хэмжээ
8	Прокурор	10 жилийн цалинтай тэнцэх хэмжээ
9	Төрийн албан хаагч	60 сарын цалинтай тэнцэх хэмжээ
10	Төрийн аудитын байгууллагын албан хаагч	3 жилийн цалинтай тэнцэх хэмжээ
11	Цагдаагийн албан хаагч	10 жилийн цалинтай тэнцэх хэмжээ
12	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч	10 жилийн цалинтай тэнцэх хэмжээ
13	Шинжилгээний байгууллагын албан хаагч	10 жилийн цалинтай тэнцэх хэмжээ

Дээрх төрийн албан тушаалтны ар гэрт олгож буй буцалтгүй тусламжийн дундаж 7 жил байна.

Малчны орлого нь тогтсон хувь хэмжээ байхгүй тул хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр жишиг болгон тооцох нь зүйтэй байна. Иймд байгалийн гамшиг болон аюулт үзэгдлийн улмаас малчин ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд 4-10 жилийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх буцалтгүй тусламж олгох боломжтой байна.

Малчинд олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн тооцоолол
(нэг хүнд олгох хэмжээ)

	Буцалтгүй тусламж олгох хэмжээг тооцох жил	Хөдөлмөрийн хөлсний хэмжээ⁶ доод	Нийт олгох мөнгөн дүн
1	4 жил	660,000 төгрөг	31,680,000 төгрөг
3	5 жил	660,000 төгрөг	39,600,000 төгрөг
4	10 жил	660,000 төгрөг	79,200,000 төгрөг

Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр ажлын байр бий болох шаардлагагүй, нэмэлт зардлын тооцоо гарахгүй.


-----oOo-----

⁶ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2023 оны аравдугаар сарын 13-ны өдрийн 12 дугаар тогтоол.

“МАЛЧНЫ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСӨЛД САНАЛ АВСАН БАЙДАЛ

Д/д	Санал авсан байдал	Санал авсан хэлбэр	Хуулийн төсөлд тусгасан эсэх
1	Засгийн газраас санал авсан	Бичиг	- Хуулийн төслийн зарим зүйл, хэсэг, заалтын хувьд тусгасан Зардлын тооцоолол хийсэн - Хуулийн төслийн зарим хэсэг, заалтад өөрчлөлт оруулсан
2	Цахимаар санал авсан	Цахим	Агуулгын хувьд тусгасан
3	Судлаачдаас санал авсан	Бичиг	Агуулгын хувьд тусгасан
4	Иргэдээс санал авсан	Утас	Агуулгын хувьд тусгасан

ЦАХИМ САНАЛ АВСАН



Д/д	Хуулийн төсөлд тусгасан байдал	Санал	Санал ирүүлсэн иргэн
1	4.1.4. “малчны бүлэг, хэсэг” /цаашид “малчны бүлэг” гэх/ гэж сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, бэлчээрийн газар нутгийг хамтран ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах хэлбэр, үүргээ харилцан тохиролцож, баталгаажуулсан малчин өрхийн нэгдлийг;	4.1.4. “малчны бүлэг, хэсэг” /цаашид “малчны бүлэг” гэх/ гэж сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, өөрсдийн жилийн 4 улиралд нутагладаг бэлчээрийн газар нутгийг хамтран ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах хэлбэр, үүргээ харилцан тохиролцож, баталгаажуулсан малчин өрхийн нэгдлийг;	ЛХАГВАСҮРЭН
2	4.1.6. “мал аж ахуйн зохистой дадал” гэж малчны хотноос хэрэглэгч хүртэлх бэлтгэн	4.1.6. “мал аж ахуйн зохистой дадал” гэж мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, малчны	ГАНЦОГТ

	нийлүүлэлтийн орчин, нөхцөл, үе шат бүрт болон мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тавьж байгаа шаардлага, шалгууртай үйл ажиллагааны дадлыг;	хотноос хэрэглэгч хүртэлх бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, орчин, нөхцөл, үе шат бүрт болон мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тавьж байгаа шаардлага, шалгуурыг биелүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагааг;	
3	7.6. Боловсруулах үйлдвэр нь малчин өрх, малчны бүлэгтэй мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтвортой байдлын гэрээг 3 жил тутамд хийдэг тогтолцоонд шилжинэ.	Малчин өрх, Хоршоотой мал малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлтийн тогтвортой гэрээг 3-н жилийн хугацаатай байгуулж жил тутам гэрээг дүгнэнэ	ГҮРРАГЧАА
4	7.9. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтын түвшний өсөлт болон хариуцлагатай байдлын үнэлгээний үзүүлэлтийг улс, аймаг, сумын аварга, малчин, тэргүүний аймаг, сум шалгаруулах болзолд тусгаж, бүтээмжийг үнэлдэг байна.	Улс, аймаг, сумын аварга малчин, тэргүүний малчны хамт олон Малчны хэсэг\Бүлэг\, Хоршоог болзолд тусгаж бүтээмжийг үнэлэх, олон нийтэд тэргүүн туршлагыг сурталчилах үнэлэх	ГҮРРАГЧАА
8	10.3. Малчин, малчны бүлэг, нөхөрлөл нь учирч болзошгүй гэнэтийн аюул, эрсдэлээс хамгаалж, үйл ажиллагааны борлуулалтын орлогоос хуримтлал үүсгэж, дундын сантай байж болно.	Малын тоо толгойн албан татвар бусад эх үүсвэр хамтын санаачилга, борлуулалтын орлого зэргээс учирч болзошгүй гэнэтийн аюул, эрсдлээс хамгаалах сантай байна.	ГҮРРАГЧАА

СУДЛААЧДААС ИРҮҮЛСЭН САНАЛ

№	Гаргасан санал	Хуулийн үзэл баримтлалтай нийцэж буй эсэх	Тайлбар
1	Уламжлалт мал аж ахуй орчин цагийн уур амьсгалтай уялдуулан хүн амыг хүнс, аж үйлдвэрийг түүхий эдээр хангах талаар зорилтод оруулна	Нийцсэн	Агуулга давхардсан
2	Таримал ургамал ойлголтын талаар тусгах 1 наст, олон наст	Нийцэхгүй	Ургамалын тухай хууль, Тариалангийн тухай хууль зэрэг хуулиудаар зохицуулна
3	Татвар, болон нийгмийн даатгалын талаар тусгах	Нийцэхгүй	Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан учир давхардуулан зохицуулах шаардлагагүй
4	Төмс хүнсний ногоог тариалах талаар тусгах	Нийцэхгүй	Газрын ногоо, тэжээл тариалах талаар Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд энэ хуулиар бүрэн эрхийг шилжүүлэх
5	Сум, аймаг дахь малчдын холбоог дэмжиж, туршлага нэвтрүүлэх сургалт зохион байгуулах	Нийцнэ	Хуулийн төслийн 7 дугаар зүйлд тусгагдсан
6	Хүн ам, малыг ус эрдэс бодисоор хангах	Нийцэхгүй	Хүнсний тухай хууль, Мал, амьтаны эрүүл мэндийн тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай зохицуулна
7	Хангай, хээр, говийн бүсүүдээр мал тэжээх хугацааг тогтоох 150-250 хоног тэжээх	Нийцэхгүй	Хуулиар мал тэжээх талаарх зохицуулалт нь сургалтаар дамжуулан хүргэнэ. Хуулиар хатуу зохицуулах нь хуулийн хариуцлага хүлээлгэх эрсдэл үүснэ
8	Бүс нутгуудаар үйлдвэр байгуулах	Нийцэхгүй	Нэгдүгээрт улсын төсөвт заавал тусгах ингэснээр зардлын тооцоо гаргах шаардлагатай. Хоёрдугаарт Үйлдвэрийн тухай хуулийн төсөл болон бусад хуульд энэ талаар тусгах шаардлагатай

8	Мал, эмнэлэгийн мэргэжилтэн, багаж төхөөрөмж, эмээр хангах	Нийцнэ	Агуулгын хувьд хуульд тусгагдсан
9	Мал үржлийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэх, мал үржүүлэх бүс нутгийг тогтоох	Нийцэхгүй	Малын генетик нөөцийн тухай хуулиар зохицуулж байгаа
10	Байгальд ээлтэй экологийн цэвэр материалыг өргөн ашиглах	Нийцэхгүй	Барилга, байгууламж эсхүл малчны эрүүл ахуйн бараа материал зэрэг нь Монгол улсад орж ирж буй бараа бүтээгдэхүүний стандарт шалгагдах учир энэ агуулга зохицуулах шаардлагагүй
11	Хэдэн заалтуудад хоршоо оруулах санал гаргасан	Нийцэхгүй	Хоршооны холбоотой харилцааг хоршооны тухай хуулиар зохицуулна. Хуулийн төслийн 13.3-т заасан.
12	Ан, амьтан хамгаалах, үржүүлэх	Нийцэхгүй	Амьтны тухай хууль, Генетик нөөцийн тухай хууль зэрэг холбогдох хуулиар зохицуулна
13	Таримал, хадлангийн болон тэжээлийн ургамлыг хамгаалсан, бордож арвин ургац авсан байх	Нийцнэ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тэжээл тариалах бэлчээрийн менежмент батлах тул бүх малчид тариалах боломжгүй. Иймд уг зохицуулалт тусгах ялгамжтай байдал бий болгох ёстой. Хуулийн төслийн 9.3-т заасан
14	Отог хэрзэнг овоолж биотермийн аргаар ариутгаасан хэвийн нөөц бүрдүүлэх	Нийцнэ	Хуулийн төслийн 6.4.3-т оруулж болно.
15	Хуулийн төслийн 18.4.2-т 30 хүртэлх хувийг 50 хүртэл болгох	Нийцэхгүй	Нийт мал сүргийн 50 хүртэл хувь эргэлтэд оруулах гэх агуулга хэт их өндөр хувь хэмжээ гэж үзсэн учир 30 байхаар төсөлд тусгасан
16	Орон нутгийн чанартай үйлдвэрийг цех байгуулах. Гутал, хувцас тавилга үйлдвэрлэх	Нийцнэ	Хуулийн төсөлд "хуульд заасан бусад" гэх зохицуулалтыг оруулж өгсөн бөгөөд үйлдвэрлэлийг дэмжих нь Засгийн газрын тусгай сангаар дамжих зохицуулалт учир тусгах шаардлагагүй
17	Холбоог ерөнхийлөгч тэргүүлэгчдийн зөвлөл, гүйцэтгэх алба удирдана	Нийцнэ	Холбоо нь сайн дурын байгууллага бөгөөд хуулийн төслийн 21.4.2-т заасан болон Төрийн бус байгууллагын дүрэм, Иргэний хуулийн дагуу өөрсдөө дүрмээ батална

18	Холбоо өөрийн мэдээллийн сонин сэтгүүлтэй байх	Нийцэхгүй	Хуулийн үзэл баримтлал нь цахимжуулалтыг дэмжиж байх тул сонин сэтгүүлтэй байх нь заавал байх үүрэг байж болохгүй
19	Зоорь барихад хөнгөлөлтэй зээл олгох	Нийцнэ	Хуулийн төслийн 16.6.4-т тусгасан.
20	Улиралд нийцсэн хувцас өмсөх, ахуйн барааг эко хэрэглэх	Нийцнэ	Хуульд нарийвчилсан ийм зохицуулалт оруулах боломжгүй. Мөн тухайн хувцас, ахуйн хэрэглээ нь хувь хүний шийдвэрлэх асуудал болно
21	Байгалийн чадамжид нийцсэн гэдгийг шууд байгаль орчинд ээлтэй гэж хэлэх. Зорилго хэсэгт байгаль орчинд ээлтэй, эрсдэлгүй, бүтээмжтэй мал аж ахуйг хөгжүүлэхэд оршино гэх	Нийцнэ	Агуулгын хүрээнд тусгагдсан
22	Хууль тогтоомжид газрын тухай хууль орох	Нийцнэ	Хуулийн төсөлд тусгасан
23	3.1-д ... мал бүхий иргэн, аж ахуйн нэгжийн гэх	Нийцнэ	Хуулийн төсөлд тусгасан
24	4.1.4 ... түүнээс +ДЭЭШ	Нийцнэ	Хуулийн төсөлд тусгасан
25	4.1.5. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хүн ба байгаль ээлтэй, бүтээмжтэй, эрсдэлгүй эрхлэх уламжлалт болон шинэ арга технологи, үйл ажиллагааг гэсэн санаагаар зохистой дадлыг тодорхойлох	Нийцнэ	Хуулийн төсөлд тусгасан
26	5-р зүйл дээр малаас гарах бүтээгдэхүүнийг борлуулах экспортын гарцийг нээх, үнэ цэнэ шингэсэн бүтээгдэхүүн экспортлох кластерийг хөгжүүлэх нь төрийн бодлого байхаар нэмэлт заалт оруулах (5.1.6 дээр нэмэж найруулах ялангуяа экспортын кластер)	Нийцнэ	"...бэлтгэн нийлүүлэлт хийх тогтолцоо" гэх агуулгын хүрээнд тусгагдсан
27	6.2.1 -д Өөрийн ашиглаж буй бэлчээрийн төлөв байдал, нөөцд нийцүүлэн малын тоо толгойг зохицуулан өсгөж үржүүлэх гэсэн санааг оруулах.	Нийцнэ	Хуулийн төслийн заалтуудтай давхацсан
28	Малчны үүрэг дотор мал эрүүлжүүлэх болон гоц	Нийцнэ	Хуулийн төслийн заалтуудтай давхацсан

	халдварт өвчний үед мэргэжлийн байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж хэрэгжүүлэх гэсэн санаа оруулах		
29	6.3.1 нь заавал хамтаараа бүлэг байгуулах ёстой болчихоод байгааг анхаарах. Зуслангийн газар ашиглах, өвөлжөө хаваржаагаа хамгаалах дээр нутгаараа, голын хөндийгөөр	Нийцнэ	Хуулийн төслийн заалтуудтай давхцсан. “хот айл” гэх тодорхойлод “нутгаараа, голын хөндийгөөр” хамаарна
30	6.4.6-д зөвхөн уламжлалт аргыг ашиглахгүй ээ. Мал эмнэлгийн байгууллагын тавьсан дүрэм журамд нийцүүлэн тээвэрлэх, шилжилт хөдөлгөөн хийх гэсэн санаагаар хийх	Нийцнэ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-234 дүгээр тушаалын хавсралт “МАЛ БЭЛТГЭХ, ТУУВАРЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРТ ХҮЛЭЭН АВАХ ҮЕИЙН МАЛ ЭМНЭЛЭГ, ХОРИО ЦЭЭРИЙН ЖУРАМ” тусгагдсан учир хуульд давхацуулан тусгах шаардлагагүй.
31	7.5.4 Мал аж ахуйг байгальд ээлтэй эрхлэх цогц сургалт гэсэн санаагаар. Ер нь малчинд олгох сургалт хэсэг нь 1. Хүн ба байгальд ээлтэйгээр, 2. Эрсдэлгүй, 3.Бүтээмжтэй маа эрхлэх	Нийцнэ	Хуулийн төслийн 7.4. дэх заалттай давхцсан
32	... он гэхэд сургалтанд суусан сертификаттай малчин мал аж ахуй эрхэлдэг болгох гэсэн санааг энэ хуулинд хийж өгвөл зүгээр байна. Хуулийн хэмжих үзүүлэлд юм даа. 7.6.-д энэ санааг оруулчихвал...	Нийцэхгүй	-
33	8.1-ийн малчны хөгжлийн төвийн сургагч багш бэлтгэх асуудлыг энэ чиглэлийн ангийг ХААИС-д бэлтгэнэ гэсэн санааг аль нэг газар нь тусгаж өгөх. Одоо сургагч багшийн нөөц огт байхгүй байгаа юмаа.	Нийцэхгүй	Багшийн хөгжлийн тухай хууль, Боловсролын ерөнхий хуулиар зохицуулах харилцаа
34	8.7. Нийтлэг Журмыг ЗГ-ын тогтоолоор батлаж аймаг сум бүр нийлтгэг журамд нийцүүлсэн журам батлаж хэрэгжүүлэх	Нийцнэ	Тусгаагүй

35	11.3.-т хүн, байгальд ээлтэй мал аж ахуй эрхэлсэн шалгуур үзүүлэгтийг нэмэж оруулах	Нийцнэ	-
36	ХАА нэг газар нь гэрээгээр эзэмшиж буй бэлчээрийг хэт их малын ачаалалаар доройтуулсан тохиолдолд өвөлжөө хаваржааны газрыг ашиглах гэрээг цуцлах эрхийг ЗД-д олгох заалт оруулах	Нийцэхгүй	Гэрээгээр зохицуулах учир хуулийн төсөлд тусгах шаардлагагүй
37	17.5 ба 17.6-г нэгтгээд жагсаамаар санагдав. Алинд нь нэн хөнгөлөлттэй, алинд нь хөнгөлөлттэй зээл олгохыг тухайн цаг үед нийцүүлэн ЗГ тогтоодог байвал зүгээр байж болох талтай	Нийцэхгүй	Хуулийн төслийн үзэл баримтлалд ялгамжтай байхаар тусгасан
38	18-р зүйлийг малчны хөгжлийн сан гэх үү мал аж ахуйн хөгжлийн сан гэх үү. Энэ сангийн 10-15 хувийг өвөлжөө хаваржаа тус бүрийн бэлчээрийн төлөв байдлыг үнэлэх, ашиглуулж буй бэлчээрийг малчид ээлтэй ашиглаж чадсан эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч гэрээг дүгнэж цаашид гэрээг сунгах эсэхийг шийддэг байхад зориулбал маш сайн. Байгаль ээлтэй мал аж ахуй эрхлэж байгаа эсэхээ дүгнэж байгаа юм.	Нийцэхгүй	Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаанд хамаарахгүй
39	21-р зүйлд бэлчээрийг доройтуулсан малчинд хүлээлгэх хариуцлага орвол сайн бна.	Нийцнэ	Хуулийн төслийн 20.2-т Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэнэ.